



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



UN
DP

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ "МОНГОЛ УЛСАД
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТ ОУЯЛДСАН ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ
ДЭМЖИХ НЬ" ТӨСӨЛ

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

2024 он

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

Тайланг боловсруулсан:

Далхсүрэнгийн Долгорсүрэн, НҮБХХ-ийн зөвлөх

Хянан тохиолдуулсан:

Г. Золбоо, Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга

Энэхүү “Байгаль орчны салбарын төсвийн зарлагын шинжилгээ” судалгааны тайланг “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий мэдэгдэл

978-9919-9177-8-4

Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.	5
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.	9
ТОВЧИЛСОН ҮГС.	10
1. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ	11
1.1 Зарлагын шинжилгээний зорилго	11
1.2 Зарлагын шинжилгээний хамрах хүрээ	11
1.3 Зарлагын шинжилгээний арга зүй	11
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	13
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	15
3.1 Монгол Улсын байгаль орчны салбарын урт ба дунд хугацааны бодлогууд	15
3.1.1 “Алсын хараа 2050” болон “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”	16
3.1.2 “Монгол Улсыг 2020-2024 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”	19
3.1.3 Шинэ сэргэлтийн бодлого	19
3.1.4 Тогтвортой хөгжлийн зорилго 2030	20
3.1.5 Биологийн олон янз байдлын тухай үндэсний хөтөлбөр	21
3.1.6 Хөгжлийн бодлогуудын уялдаа, харилцан холбоо	22
3.2 Байгаль орчны салбарын хууль эрх зүйн орчин	22
3.2.1 Байгаль орчны салбарын олон улсын конвенц, протокол, хэлэлцээр	22
3.2.2 Байгаль орчны салбарын хууль эрх зүйн орчин	23
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ИНСТИТУТ	26
4.1 Төрийн байгууллагын тогтолцоо	26
Төрийн байгууллагын ажиллагсдын мэдээлэл	26
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН МАКРО ҮЗҮҮЛЭЛТҮҮД	37
5.1 Салбарын макро үзүүлэлтүүдийн нөхцөл байдал	37
5.2 Салбарын нэгдсэн төсвийн зарлагын шинжилгээ	39
5.2.1 Салбарын нэгдсэн төсвийн зарлага	39
5.2.2 Салбарын улсын болон орон нутгийн төсвийн зарлага	40
6. САЛБАРЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ШИНЖИЛГЭЭ	43
6.1 Улсын төсөвт байгууллагуудын зарлагын гүйцэтгэл	43
6.2 Орон нутгийн төсөвт байгууллагуудын зарлагын гүйцэтгэл	47
6.2.1 Байгаль орчны салбарын байгууллагуудын зарлагын шинжилгээ	47
6.2.2 ЗДТГ-ын хүрээлэн буй орчны хөтөлбөрийн зарлагын шинжилгээ	49
6.3 Салбарын хөдөлмөр эрхлэгчдийн дундаж цалин	50
7. САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХӨТӨЛБӨР, ЗОРИУЛАЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ	52
7.1 Хүрээлэн буй орчны төсвийн зарлагын хөтөлбөрийн ангиллын олон улсын туршлага	52
7.2 Төсвийн зарлагын гүйцэтгэл, хөтөлбөрийн ангиллаар	54

7.3 Төсвийн зарлагын гүйцэтгэл, зориулалтын ангиллаар	65
8. САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААРХ ГҮЙЦЭТГЭЛ	68
9. САЛБАРЫН ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ БОЛОН ГАДААД ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ	72
9.1 Хөрөнгийн зардлын гүйцэтгэл	72
9.2 Гадаадын зээл тусламжийн гүйцэтгэл	74
10. САЛБАРЫН ҮР ӨГӨӨЖИЙН ШИНЖИЛГЭЭ	76
10.1 Улсын ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүн, зардлын өгөөж	76
10.1.1 Ойжуулалт хөтөлбөрийн үр дүн, зардлын өгөөж	79
10.1.2 Ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн үр дүн, зардлын өгөөж	83
10.2 Орон нутгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүн, зардлын өгөөж	85
10.3 Байгаль орчны салбарын сүүлийн 3 жилийн онцлох үр дүнгүүд	88
11. САЛБАРЫН ТӨСВИЙН ОРЛОГЫН ЧИГ ХАНДЛАГА	90
11.1 Байгалийн нөөц ашигласны төлбөр (БНАТ)	90
11.1.1 Газрын нөөцийн төлбөрийн орлого	91
11.1.2 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	92
11.1.3 Ойн нөөц ашигласны төлбөр	93
11.1.4 Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр болон ан амьтны нөөц ашигласны төлбөр	93
11.1.5 Аймгуудын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлэлт	94
11.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын зарцуулалт	95
11.3 Байгаль орчин, уур амьсгалын сан	98
11.3.1 Байгаль орчин, уур амьсгалын сангийн орлого	98
11.3.2 Байгаль орчин, уур амьсгалын сангийн зарлага	100
11.4 Орон нутгийн хөгжлийн сан	102
12. ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	104
13. ДҮГНЭЛТ	105
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	113
АШИГЛАСАН НОМ ЗҮЙ	119
ХАВСРАЛТ	120

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.

Хүснэгт 1. Байгаль орчны салбарын урт ба дунд хугацааны бодлогын зорилтууд	16
Хүснэгт 2. “Алсын хараа 2050” хөгжлийн бодлого, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ	16
Хүснэгт 3. ТХЗ-ын шалгуур үзүүлэлт болон НХБ-ын шалгуур үзүүлэлтүүд	23
Хүснэгт 4. Байгаль орчны салбар дахь олон улсын гэрээ, конвенц, протоколууд	26
Хүснэгт 5. Байгаль орчны салбарын ерөнхий хуулиуд	27
Хүснэгт 6. Байгаль орчны салбарын төрийн захиргааны төв байгууллагын түүхэн замнал	30
Хүснэгт 7. 2023 онд улсын төсвөөс санхүүжсэн байгаль орчны салбарын байгууллагууд	32
Хүснэгт 8. 2023 онд орон нутгийн төсвөөс санхүүжсэн байгаль орчны салбарын байгууллагууд	40
Хүснэгт 9. Салбарын харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч	47
Хүснэгт 10. Салбарын батлагдсан төсөв ба гүйцэтгэл, санхүүжүүлэх эх үүсвэрээр	53
Хүснэгт 11. Салбарын томоохон байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он	54
Хүснэгт 12. УТХГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он	55
Хүснэгт 13. ДЦГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он	55
Хүснэгт 14. БЦГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он	56
Хүснэгт 15. Сав газрын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он	57
Хүснэгт 16. Аймгуудын байгаль орчны салбарын бодлого хариуцсан газруудын зарлагын гүйцэтгэл, 2023 он	59
Хүснэгт 17. Ойн ангиудын зарлагын гүйцэтгэл, 2023 он	60
Хүснэгт 18. Нийслэлийн байгаль орчны салбарын байгууллагуудын зарлагын гүйцэтгэл, 2023 он	61
Хүснэгт 19. Хүрээлэн буй орчны төсвийн хөтөлбөрийн ангилал	68
Хүснэгт 20. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл, хөтөлбөрийн ангиллаар, /тб.₮/	69
Хүснэгт 21. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн өсөлт, хөтөлбөрийн ангиллаар	72
Хүснэгт 22. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн хувь, хөтөлбөрийн ангиллаар	73
Хүснэгт 23. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зориулалтын ангилал	79
Хүснэгт 24. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл, эдийн засгийн ангиллаар, /тб.₮/	82
Хүснэгт 25. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн хувь, эдийн засгийн ангиллаар	83
Хүснэгт 26. Салбарын гадаад зээл, тусламжийн зардал, /тб.₮/	84

Хүснэгт 27. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн томоохон төслүүд	88
Хүснэгт 28. Байгаль орчны салбарын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	90
Хүснэгт 29. Хөтөлбөрийн зардал, хүрсэн үр дүнгийн хамаарлын шинжилгээ	97
Хүснэгт 30. Хөтөлбөрийн зардлын өсөлт, шалгуур үзүүлэлтийн хамаарлын шинжилгээ	97
Хүснэгт 31. Орон нутгийн ТЕЗ нарын ойжуулалт хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	99
Хүснэгт 32. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын батлагдсан төсөв ба гүйцэтгэл /тб.₮/	100
Хүснэгт 33. БНАТ-ийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаар	102
Хүснэгт 34. БНАТ-ийн орлогоос зарцуулбал зохих дүн (бүрэлдэхүүнээр)	102
Хүснэгт 35. Аймгуудын байгаль орчны салбарт зарцуулсан зардал болон БНАТ-ийн орлогын эх үүсвэрээс зарцуулбал зохих зардлын харьцуулалт /2023 оны байдлаар/	103
Хүснэгт 36. Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн ангилал шинэчлэх санал	103
Хүснэгт 37. Батлагдсан хөтөлбөрийн ангилал, санал болгож буй хөтөлбөрийн ангилал хоорондын хамаарал	105
Хүснэгт 38. Байгаль орчин хамгаалах зориулалт арга хэмжээний ангилал шинэчлэх санал	105

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.

График 1. Улсын төсвөөс санхүүждэг байгаль орчны салбарын байгууллагуудын тоо, 2017-2024 он	32
График 2. Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгаль орчны салбарын байгууллагуудын тоо, 2017-2024 он	39
График 3. Улсын төсвөөс санхүүждэг байгаль орчны салбарын байгууллагууд ажилчдын тоо, 2017-2024 он	45
График 4. Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгаль орчны салбарын байгууллагууд ажилчдын тоо, 2017-2024 он	45
График 5. Салбарын төсвийн зарлагын ДНБ ба нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувь /тб.₮/	48
График 6. Улс орнуудын ДНБ-д эзэлж буй байгаль орчны салбарын зардал, хувиар	48
График 7. Улс орнуудын нэгдсэн төсвийн зардалд эзэлж буй байгаль орчны салбарын зардал, хувиар	49
График 8. Салбарын батлагдсан болон зарцуулсан нэгдсэн төсвийн зарлага/тб.₮/	50
График 9. Салбарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хувь	50
График 10. Байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилтийн эх үүсвэрээр /тб.₮/	51
График 11. Байгаль орчны салбарын улсын төсвийн зарлага/тб.₮/, өсөлт	51
График 12. Байгаль орчны салбарын орон нутгийн төсвийн зарлага/тб.₮/, өсөлт	52
График 13. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил/тб.₮/	63
График 14. Салбарын ажилчдын тоо ба сарын дундаж цалин/мян.₮/	64
График 15. Хог хаягдлын үйлчилгээний хураамж/тб.₮/	71
График 16. Салбарын төсвийн зарлага, зориулалтын ангиллаар/тб.₮/	79
График 17. Салбарын төсвийн зарлагад эзэлж буй байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зориулалтуудын дундаж хувь	80
График 18. Салбарын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл, эдийн засгийн ангиллаар/тб.₮/	82
График 19. Салбарын хөрөнгийн зардлын гүйцэтгэл/тб.₮/	83
График 20. Улсын төсвийн ойжуулалт хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл/сая.₮/	83
График 21. Ойжуулах, ойг нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ/мян.га/	85
График 22. Ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх талбайн хэмжээ/мян.га/	86
График 23. Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ/мян.га/	86
График 24. Улсын төсвийн ус, цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл/тб.₮/	89
График 25. Цаг агаарын төлөв байдал, ус цаг уурын үзэгдэлд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр ашгийн хувь	89

График 26. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын батлагдсан төсөв ба гүйцэтгэл /тб.₮/	98
График 27. БНАТ-ийн орлогод эзлэх объектын дүн	99
График 28. Газрын нөөцийн төлбөрийн орлого/тб.₮/	102
График 29. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого/тб.₮/	103
График 30. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого/тб.₮/	103
График 31. Орон нутгийн татварын орлогод эзлэх БНАТ-ийн дүн/тб.₮ ба хувь/	108
График 32. БНАТ-ийн орлого бүрдүүлэлтэд аймгуудын эзлэх хувь	109
График 33. БНАТ-ийн орлогоос зарцуулбал зохих дүн болон зарцуулсан дүнгийн харьцуулалт, /тб.₮/	110
График 34. Агаарын бохирдлын төлбөрийн орлого/тб.₮/	111
График 35. Ус бохирдуулсны төлбөрийн орлого/тб.₮/	112
График 36. Байгаль орчин уур амьсгалын сангийн төсвийн зарцуулалт/сая.₮/	112
График 37. Улсын төсвийн агаар болон ус бохирдуулсны төлбөрийн орлого, БОУС-аас агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт зарцуулсан зардлын харьцуулалт/тб.₮/	113
График 38. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж буй ОНХС-ийн хөрөнгө оруулалт/сая.₮/	114

ЗУРГИЙН ЖАГСААЛТ.

Зураг 1. Монгол орны цөлжилт	14
Зураг 2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны бүтэц	31
Зураг 3. Орон нутгийн төсвийн зарлагад аймгуудын эзлэх хувь	52
Зураг 4. БНАТ-ийн орлого бүрдүүлэлтэд аймгуудын эзлэх дүн /тб.₮/	94
Зураг 5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж буй ОНХС-ийн нийт хөрөнгө оруулалтад аймгуудын эзлэх хувь	103

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ.

Шигтгээ 1. 2024 оны байгаль орчны салбарын батлагдсан төсөв, (хөтөлбөрийн ангиллаар)	75
Шигтгээ 2. 2024 оны байгаль орчны салбарын батлагдсан төсөв, (зориулалтын ангиллаар)	81
Шигтгээ 3. 2024 оны байгаль орчны салбарын батлагдсан төсөв, (эдийн засгийн ангиллаар)	85
Шигтгээ 4. 2024 оны байгаль орчны салбарын батлагдсан хөрөнгийн зардал	87

ТОВЧИЛСОН ҮГС.

ААН	Аж ахуйн нэгж
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОУАС	Байгаль орчин, уур амьсгалын сан
БОЯБ	Биологийн олон янз байдал
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ДЦГ	Дархан цаазат газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕРІ	Environmental Performance Index
СОФОС	Classification of the Functions of Government
ЗГ	Засгийн Газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУ	Монгол Улс
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НХБ	Ногоон хөгжлийн бодлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар
УИХ	Улсын их хурал
ҮДСТТ	Үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт

1.1 Зарлагын шинжилгээний зорилго

Байгаль орчны салбарын төсвийн зарлагын шинжилгээний зорилго нь байгаль орчны салбарын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэгдсэн төсвөөс зарцуулсан төсвийн зарлагын хэмжээ, чиг хандлага, төсвийн ил тод, найдвартай байдал, төсвийн хуваарилалт ба бодлогын уялдаа, салбарын төсвийн зорилтын үр дүнгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Сангийн яамны бодлого боловсруулагч нарт нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, бодлогын санал дэвшүүлэх, зөвлөмж өгөхөд оршино.

Түүнчлэн энэхүү дүн шинжилгээгээр салбарын төсвийг бодлогын зорилттой уялдуулан үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт (ҮДСТТ)-ийн аргачлалаар төлөвлөдөг зарчимд шилжихэд хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, урьдчилсан нөхцөлийг тодорхойлох зорилготой болно.

1.2 Зарлагын шинжилгээний хамрах хүрээ

Энэхүү сэдэвчилсэн зарлагын шинжилгээнд байгаль орчны салбарт 2015-2023 онд улсын болон орон нутгийн төсвөөс баталсан нийт төсөв, түүний зарцуулалт, урсгал ба хөрөнгийн зардал, хүрээлэн буй орчны хөтөлбөр, зориулалтын ангиллаар зардлын бүтцийн шинжилгээг хамруулна.

Байгаль орчны салбарт үйл ажиллагаа эрхлэгч улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг нийт 145 орчим байгууллагын чиг үүрэг төсвийн гүйцэтгэл, зарлагын шинжилгээ болон 2017-2024 онуудын байгаль орчны салбарт ажиллагч төрийн албан хаагчдын тоон үзүүлэлтүүд, цалингийн шинжилгээг мөн хамруулав.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг санхүүжүүлэх, тухайлсан хууль эрх зүйн орчинд тусгасан байгаль орчны салбарын томоохон төсвийн орлогуудын 2015-2023 онуудын орлогын шинжилгээ болон санхүүжилтийн эх үүсвэрээс зарцуулах зардлын нормативаар тогтоосон мөнгөн дүнгүүдийн харьцуулсан шинжилгээг хийж хамруулав.

Мөн салбарын төсвийн бодлогын өнөөгийн орчинд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох зорилгоор 2024 оны батлагдсан төсвийн шинжилгээг нэмэлтээр тусгалаа.

1.3 Зарлагын шинжилгээний арга зүй

Байгаль орчны салбарын төсвийн зарлагын шинжилгээнд хүчин зүйлсийн хамаарлын регрессийн шинжилгээ, энгийн нийцлийн шинжилгээ, чиг хандлагын шинжилгээ, хугацаан цувааны статистик болон динамик шинжилгээний бусад арга зүйг ашиглалаа. Ингэхдээ салбарын статистикийн тоон ба чанарын өөрчлөлтийн үзүүлэлтүүдийг харьцуулах, хүчин зүйлүүд ба үзүүлэлтийн хамаарлыг графикаар илэрхийлэх арга зүйг ашигласан болно.


Түүнчлэн чанарын судалгааны арга зүйд үндэслэсэн салбарын урт ба дунд хугацааны бодлого, хууль эрх зүйн орчин, дотоод, гадаадын судалгааны байгууллага, судлаачдын боловсруулсан ном, тайлангуудыг уншиж харьцуулан дүгнэлт, санал зөвлөмжид тусгалаа. Мөн зарлагын шинжилгээний хүрээнд салбарын асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтнууд, төлөөлөгчидтэй санал солилцох уулзалт, ярилцлагууд хийж, дүгнэлт, санал зөвлөмжүүдийг энэхүү тайланд тусгасан болно.

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол орон нь Сибирийн тайга болон Төв Азийн хээр, цөлийн экосистемийн шилжилтийн заагт оршдог учраас Биологийн Олон Янз Байдал (БОЯБ)-ийн хувьд баялаг болохын сацуу биологийн төрөл зүйлийн өвөрмөц байдлаараа бүс нутгийн хэмжээнд онцлог бөгөөд чухал ач холбогдолтой (Batjargal et al, 1999). Монгол Улсын хэмжээнд сүүлийн 80 жилд агаарын дундаж температур 2.4 хэм өссөн нь дэлхийн агаарын дундаж температур сүүлийн 100 жил 1.1 хэмээр өссөнөөс ойролцоогоор 2 дахин өссөн үзүүлэлт юм.

Монгол орны нийт газар нутгийн 76.9 хувь нь цөлжсөн ба 50-70 хувийг Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгууд эзэлж байгаа бөгөөд нийт хур тунадасны хэмжээ сүүлийн 70 жилд 7.3 хувиар буурсан байна.

Зураг 1. Монгол орны цөлжилт



Нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгарал дэлхийн дунджаас 2.7 дахин өссөн ба сүүлийн 20 жилд гамшигт үзэгдлийн давтамж 2 дахин өссөн байна.

Монгол орны нийт усны нөөцөд эзлэх гадаргын усны хэмжээ 98 хувьтайгаас гадна 2021 оны байдлаар нийт газар нутгийн 7.9 хувийг ойгоор бүрхэгдсэн талбай бүрдүүлж байна. Мөн улсын хэмжээнд дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ нийт хог хаягдлын ердөө 10 орчим хувийг бүрдүүлж байна.

Йелийн их сургууль, Колумбын их сургууль хамтран боловсруулсан 2022 оны EPI (Environmental Performance Index)¹ буюу Байгаль орчны гүйцэтгэлийн индексийн тайланд Монгол Улс 100 онооноос 29.6 оноо авч 180 орноос 155 дугаарт эрэмбэлэгдсэн байснаас 2024 оны байдлаар 37.0 авч 11-н байр ахиж 144-т эрэмбэлэгдсэн байна.

¹ EPI (Environmental Performance Index) буюу Байгаль орчны гүйцэтгэлийн индекс нь улс орнуудын засгийн газраас явуулж буй байгаль орчны бодлогын хэрэгжилтийг хэмжиж, харьцуулан үнэлдэг индекс юм.

Монгол Улсын EPI оноонд агаарын бохирдол (48.2 оноогоор 145-т), агаарын чанар (17.8 оноогоор 160-т), хог хаягдлын менежмент(12.3 оноогоор 176 дугаар байр), уур амьсгалын өөрчлөлт(17.6 оноогоор 177-т) гэсэн үзүүлэлтүүд сөрөг нөлөө үзүүлж байна. Харин биологийн олон янз байдал ба амьдрах орчин (63.4 оноогоор 38-т), улаан жагсаалтын индекс (84.9 оноогоор 31-т)-ээр дээгүүр байранд эрэмбэлэгдсэн байна.

3.1 Монгол Улсын байгаль орчны салбарын урт ба дунд хугацааны бодлогууд

Монгол Улсын Засгийн Газар (ЗГ)-аас байгаль орчны салбарын асуудлууд болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах хүрээнд “НОГООН ХӨГЖИЛ”-ийн бодлогын арга хэмжээ, зорилтуудыг салбарын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод тусган хэрэгжүүлж байна. 2014 оны 6-р сарын 13-ний өдөр Улсын Их Хурал (УИХ)-ын 43 дугаар тогтоолоор Ногоон хөгжлийн бодлого (НХБ)-ыг баталснаар ногоон хөгжлийн үндэсний бодлоготой болсон анхдагч улсуудын нэгээр тодорсон юм.

Монгол Улс НХБ-оо тодорхойлсон нь дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагатай нэгдэж байгаль орчинд ээлтэй, ирээдүй хойч үедээ эрүүл амьдрах орчныг өвлүүлэн үлдээх гэсэн эрмэлзлээ тодотгож өгсөн юм. Үүнтэй холбоотойгоор өнөөг хүртэл НХБ-ын хөгжлийн зорилт, хүрэх үр дүн, хэрэгжилтүүдийг Монгол Улсын хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдэд мөн тусгаж уялдааг хангахыг зорьж байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”²
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050”,
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол “Шинэ сэргэлтийн бодлого”
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоол “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг нь багтана.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Ногоон хөгжил” зургаадугаар бүлгийн Зорилго 6-д “Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна” гэж заажээ. Монгол Улс нь байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нийт хүн амд хүртээж, хүний амьдрах орчин, амьдралын чанарыг сайжруулах зорилгыг нэн тэргүүнд тавьж байна.

Байгаль орчны салбарын “НОГООН ХӨГЖИЛ”-ийн бодлогын дунд ба урт хугацааны тэргүүлэх зорилтуудыг /Хүснэгт 1/-т харуулав.

² “Алсын хараа-2050” батлагдсаны дараагаар хүчингүй болсон.

АЛСЫН ХАРАА 2050 (2020.05.07)

Эх байгаль анхдагч экосистем
Байгалийн баялгийн үр өгөөж
Үнэт баялаг ус
Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил

МУ-ЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ (2020.08.28)

Эх байгаль анхдагч экосистем
Байгалийн баялгийн үр өгөөж
Үнэт баялаг ус
Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил

МУ-ЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ (2020.08.28)

Ногоон хөгжил

Байгаль орчны салбарын хөгжлийн бодлогын тэргүүлэх зорилтууд нь байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна.

3.1.1 “Алсын хараа 2050” болон “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”

Байгаль орчны салбарын хөгжлийн бодлогын зорилтуудын хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг /Хүснэгт 2/-т харуулав.

Хүснэгт 2. “Алсын хараа 2050” хөгжлийн бодлого, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын Хараа-2050”	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020.08.28)
<p>ЭХ БАЙГАЛЬ АНХДАГЧ ЭКОСИСТЕМ</p> <p>Зорилт 6.1. Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн I үе шат (2021-2030): Монгол орны унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, даацыг тогтоож, үнэлэмжийг нэмэгдүүлж эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх үе.</p> <ol style="list-style-type: none">Байгалийн баялгийн нөөц, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, даацыг тогтоож, үнэлгээг шинэчилнэ.Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистемийг тусгай хамгаалалтад авч, унаган байгалийг хамгаална.	<p>ЭХ БАЙГАЛЬ АНХДАГЧ ЭКОСИСТЕМ</p> <p>Зорилт 6.1. Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистем бүхий газар нутгийг судалж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн эдийн засгийн үр өгөөжийг үнэлнэ:</p> <ol style="list-style-type: none">Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөн нийт газар нутгийн 27 хувьд хүргэж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна.Монгол орны ургамал газарзүйн 4-өөс доошгүй тойргийн ашиглалтад өртөмтгий 200 зүйл ургамал, 10 зүйл амьтны тархац нөөцийг тогтоож, Олон улсын улаан дансны шалгуураар 600 зүйл амьтан, ургамлыг нарийвчлан үнэлж, ховордлын шалтгааныг тодорхойлно.

Монгол Улсын урт хугацааны
хөгжлийн бодлого
“Алсын Хараа-2050”

Монгол Улсыг 2021-2025 онд
хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
(2020.08.28)

БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ҮР ӨГӨӨЖ

Зорилт 6.2. Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.

Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

I үе шат (2021-2030): Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгох үе.

1.Биологийн олон янз байдлыг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэж хомсдолоос сэргийлэх, ашигт зүйлийг үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөц бүрдүүлнэ.

2.Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна.

3.Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.

4.Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлж, шинэ үеийн техник, технологийн шинэчлэл хийнэ.

БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ҮР ӨГӨӨЖ

Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно:

6.2.1. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна.

6.2.2. Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээж, ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар үржүүлэн тарималжуулж ашиглалтын нөөц бий болгоно.

6.2.3. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.

6.2.4. Хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийнэ.

6.2.5. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

ҮНЭТ БАЯЛАГ УС

Зорилт 6.3. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

I үе шат (2021-2030): Усны нөөцийн шаталсан үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэн, цэвэр усны үнэлэмжийг нэмэгдүүлж хамгаалах, усны нөөцийг хуримтлуулах үе.

1.Усны нөөцийн үнэ тарифт шатлан өсгөх зарчим тогтоож, усны хэрэглээг төлбөртэй болгон хэмнэлт, дахин ашиглалтыг нэмэгдүүлнэ.

2.Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна.

ҮНЭТ БАЯЛАГ УС

Зорилт 6.3. Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ:

6.3.1. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна.

6.3.2. Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж, томоохон голууд дээр урсцын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барьж эхэлнэ.

6.3.3. Нийт хүн амын 85-аас доошгүй хувийг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангасан байна.

<p style="text-align: center;">Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын Хараа-2050”</p>	<p style="text-align: center;">Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020.08.28)</p>
<p>3.Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж, томоохон голууд дээр урсцын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барьж эхэлнэ.</p> <p>4.Хүн амыг баталгаат ундны усаар хангах, усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлэх, төлөвлөлт, менежмент хийх нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	<p>6.3.4. Нийт газар нутгийн 23 хувьд гидрогеологийн дунд масштабын зураглал хийж, усны нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлж, төлөвлөлт, менежмент хийх боломж бүрдүүлнэ.</p>
<p style="text-align: center;">НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ, БҮТЭЭМЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ НОГООН ХӨГЖИЛ</p> <p>Зорилт 6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Ногоон санхүүгийн үндэсний тогтолцоог бий болгон хөгжүүлж, байгальд ээлтэй, үр ашигтай цэвэр технологи, хэмнэлттэй хэрэглээг дэмжих үе.</p> <p>1.Байгальд ээлтэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлж хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, байгалийн нөөцийг хэмнэх хаягдалгүй эдийн засгийг хөгжүүлнэ.</p> <p>2.Эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлнэ.</p> <p>3.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна.</p> <p>4.Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан ногоон санхүүгийн үндэсний тогтолцоог дэмжин хөгжүүлж, олон улсын санхүүгийн арга хэлбэрийг ашиглан байгальд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ.</p> <p>5.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, боловсруулах 3R цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулан хог хаягдлын дахин боловсруулах хэмжээг нэмэгдүүлнэ.</p>	<p style="text-align: center;">НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ, БҮТЭЭМЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ НОГООН ХӨГЖИЛ</p> <p>Зорилт 6.4. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлнэ:</p> <p>6.4.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан үндэсний ногоон санхүүгийн корпорац (НСК) байгуулан ногоон эдийн засгийг дэмжих төсөл, хөтөлбөрийн санхүүгийн шинэ эх үүсвэрийг бүрдүүлнэ.</p> <p>6.4.2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна.</p> <p>6.4.3. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.</p> <p>6.4.4. Хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.</p> <p>6.4.5. Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлж, 20 хувьд хүргэнэ.</p> <p>6.4.6. Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ 27 хувьд хүрнэ.</p> <p>6.4.7. Аймгийн төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдэж, хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.</p>

3.1.2 “Монгол Улсыг 2020-2024 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”

Монгол Улсыг 2020-2024 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд байгаль орчны салбарт дараах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

НОГООН ХӨГЖИЛ: Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Байгаль орчны салбарын зорилт болон зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд:

- 5.1.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 5.1.2. Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 5.1.3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, нийслэлийн цэвэр усны хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.
- 5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.
- 5.1.5. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэж, мод тарьж ногоон хөгжилд хувь нэмэр оруулсан иргэд, аж ахуйн нэгжид мөнгөн урамшуулал олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.1.6. Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна.
- 5.1.7. Ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлж, ашиглалтын нөөц бий болгоно.
- 5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.
- 5.1.9. Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжиж, хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх, аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулна.
- 5.1.10. Туул голын сав газраас түгээмэл тархацтай ашигт малтмал олборлохыг таслан зогсоож, нөхөн сэргээлт хийж, усны түвшинг нэмэгдүүлнэ.
- 5.1.11. “Хөх морь” төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.
- 5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулахаар тусгажээ.

3.1.3 Шинэ сэргэлтийн бодлого

Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн “Шинэ сэргэлтийн бодлого”-д байгаль орчны салбарт дараах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ:

5.1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

5.2. Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.

5.3. Байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулна.

5.4. Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлох үндсэн зорилтуудтай.

Ногоон сэргэлтийн хүрээнд доорх төслүүдийг хэрэгжүүлэхээр баталсан. Үүнд:

1. Байгальд ээлтэй дэвшилтэт технологид суурилан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, энгийн болон аюултай хог хаягдлын төвлөрсөн эко байгууламж байгуулах төсөл;
2. Усны нөөцийг хуримтлуулж, говийн бүсийн ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх “Хөх морь” төсөл тус тус багтана.

3.1.4 Тогтвортой хөгжлийн зорилго 2030

“Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ) 2030”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ)-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилж, 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс ТХЗ албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжүүлж эхэлсэн.

Дэлхий нийтэд байгаль орчинд үзүүлэх хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн нөөцийг хамгаалах, ээлтэйгээр ашиглах, нөхөн сэргээх, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлын асуудлуудыг шийдвэрлэх нь нэн чухал болоод байна. Иймд улс орон бүр өөрийн үйлдвэрлэл, хэрэглээнийхээ хэв шинжийг өөрчилж, байгальд ээлтэй загварт шилжиж байна. Үүнтэй уялдуулан НҮБ-аас 2013 онд ногоон хөгжлийн конвенцыг батлан гаргаж, улс орнууд санал нэгтгэйгээр дэмжин нэгдсэн.

Монгол Улсын хувьд 2014 оны УИХ-ын 43 дугаар тогтоолоор “Ногоон хөгжлийн бодлого”-ыг баталсан ч 2021 оны 11 дүгээр сард УИХ-ын 89 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.

Гэсэн ч ТХЗ-ын хэд хэдэн үзүүлэлтүүд, Монгол Улсын “Ногоон хөгжлийн бодлого”-ын шалгуур үзүүлэлтүүдтэй уялдаатай байдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг /Хүснэгт 3/-т харуулав.

Хүснэгт 3. ТХЗ-ын шалгуур үзүүлэлт болон НХБ-ын шалгуур үзүүлэлтүүд

Зорилго	Үзүүлэлт	Алсын Хараа 2050 “Ногоон хөгжлийн бодлого”
ЗОРИЛГО 6. Баталгаат ундны ус ариун цэврийн байгууламжаар хангах	6.1.1 Баталгаат ундны усны үйлчилгээгээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Шалгуур үзүүлэлт 7
	6.2.1a Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн үйлчилгээгээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Шалгуур үзүүлэлт 8
ЗОРИЛГО 11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	11.6 Хот суурин газарт тогтмол цуглуулдаг хатуу хог хаягдал, түүнээс эцсийн боловсруулалт хийгдсэн хатуу хог хаягдлын эзлэх хувь, хотоор	Шалгуур үзүүлэлт 11
	11.6.2 Хотын агаар дахь тоосонцрын агууламж PM _{2.5} , мг/м ³ болон PM ₁₀ , мг/м ³	
ЗОРИЛГО 12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих	12.2.1 Дотоодын материалын хэрэглээ, нэг хүнд ногдох дотоодын материалын хэрэглээ, ДНБ-д ногдох дотоодын материалын хэрэглээ	Шалгуур үзүүлэлт 13
	12.5.1 Хог хаягдлын дахин боловсруулалтын үндэсний түвшин, дахин боловсруулсан материал, тонноор	Шалгуур үзүүлэлт 10
ЗОРИЛГО 15. Хуурай газрын эко системийг хамгаалах	15.1.1 Ойгоор бүрхэгдсэн газрын нийт газар нутагт эзлэх хувь	Шалгуур үзүүлэлт 4
	15.1.2 Хамгаалалттай газар бүхий хуурай болон цэнгэг усны биологийн олон янз байдлын томоохон газруудын эзлэх хувь, экосистемийн төрлөөр	Шалгуур үзүүлэлт 3
	15.3.1 Доройтсон газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь	Шалгуур үзүүлэлт 5
	15.4.1 Өндөр уулын биологийн олон янз байдлын хувьд чухал ач холбогдолтой хамгаалагдсан газар нутгийн эзлэх хувь	Шалгуур үзүүлэлт 2

3.1.5 Биологийн олон янз байдлын тухай үндэсний хөтөлбөр

БОЯБ-ын тухай үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн 2015 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 325 дугаар тогтоолоор баталсан.

БОЯБ гэдэг нь дэлхий дээрх амьд бие организмын олон янз байдал тухайлбал хуурай газар, далай тэнгис, усан орчны экосистем, экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох амьтан, ургамал зэрэг амьд биет болон тэдгээрийн генетикийн олон янз байдлыг багтаасан нийлмэл ойлголт юм.

Монгол орны БОЯБ-ын үндэсний хөтөлбөрийн эрхэм зорилго нь Монгол Улсын иргэн бүрийн Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг нь баталгаатай болгох нөхцөлийг бүрдүүлэх явдал мөн.

Монгол орны биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах тэргүүлэх чиглэлийг баримтална:

Тэргүүлэх чиглэл 1: биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах талаарх шийдвэр гаргагч, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх;

³ Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эхний 2 шалгуур үзүүлэлт

Тэргүүлэх чиглэл 2: биологийн олон янз байдлын нөөцийн талаарх шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан зохистой ашиглах болон хамгааллын бодлогыг бий болгон хэрэгжүүлэх;

Тэргүүлэх чиглэл 3: биологийн олон янз байдлын тогтвортой ашиглах нөхцөлийг хангах;

Тэргүүлэх чиглэл 4: биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хамгаалах, ашиглах бодлого, эрх зүйн орчныг сайжруулах гэсэн чиглэлүүд багтана.

3.1.6 Хөгжлийн бодлогуудын уялдаа, харилцан холбоо

Хавсралт 1-д тусгасан “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын “Ногоон хөгжил”-ийн бүлэг нийт 13 шалгуур үзүүлэлтээр, Хавсралт 2-д тусгасан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн “Ногоон хөгжил”-ийн бүлэг мөн адил 13 шалгуур үзүүлэлтээр хэмжигдэж байна. Эдгээр хөгжлийн бодлогуудад тусгасан шалгуур үзүүлэлтүүд болон тэдгээрийн 2025 онд хүрэх зорилтот үр дүн ижил буюу салбарын хөгжлийн бодлого хоорондын зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтүүдийн уялдаа холбоо харьцангуй сайн байна.

Хавсралт 3-т тусгасан Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Ногоон хөгжлийн бодлого” бүлэг 14 шалгуур үзүүлэлтээр хэмжигдэнэ. Үүнээс 11 шалгуур үзүүлэлт Хавсралт 1 болон 2-т заасантай ижил байна. Хавсралт 1 болон 2-т Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI-ийг 2025 онд 58-д хүргэхээр зорьсон бол Хавсралт 3-т 2023 онд 58-д хүргэхээр заасан байгаа нь ялгаатай байна. Мөн Хавсралт 3-т тусгасан шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь гэсэн үзүүлэлтийн суурь түвшин ялгаатай байна.

Хэдийгээр бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо сайн байгаа ч бодлогын хэрэгжилт, шалгуур үзүүлэлтүүдийн хүрч буй үр дүн тодорхой бус байгаа бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрийн хувьд хариуцагч байгууллагууд бодлогын хэрэгжилтийг тогтмол үнэлж тооцоолох шаардлагатай байна.

3.2 Байгаль орчны салбарын хууль эрх зүйн орчин

Байгаль орчны салбарын олон улсын хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээр болон хууль эрх зүйн орчин зохих хэмжээнд сайн боловсруулагдаж, сайжирсаар байгаа ч хангалттай хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлоход мөн хүндрэлтэй юм.

3.2.1 Байгаль орчны салбарын олон улсын конвенц, протокол, хэлэлцээр

Байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах явдал нь зөвхөн нэг орны хэмжээнд шийдвэрлэх боломжгүй, сүүлийн хагас зуун жилд БОЯБ-ын нөөц хурдацтай хомсдож байгааг харгалзан дэлхийн улс орнууд энэ чиглэлд шинэ арга зам, чиг хандлагыг эрэлхийлэн, өргөн цар хүрээтэй, томоохон үйл ажиллагааг нэгэн зорилго, цаг хугацаанд төлөвлөн хэрэгжүүлдэг болсон байна. Үүний нэг хэлбэр нь олон улсын гэрээ буюу конвенц юм.

Конвенцод нэгдэн орсон улс орнууд бие биедээ тусалж хамтран ажиллахын хамт тодорхой үүрэг хүлээж, хариуцлага үүрдэг. Монгол Улс нь 1990 оноос хойш олон улсын өмнө байгаль орчин, БОЯБ-ыг хамгаалах, зүй зохистой ашиглахад шууд ба шууд бус утгаараа чиглэгдсэн олон улсын гэрээ, холбогдох протоколуудыг /Хүснэгт 4/-т харуулав.

Хүснэгт 4. Байгаль орчны салбар дахь олон улсын гэрээ, конвенц, протоколууд

Нэгдэн орсон он	Олон улсын гэрээ, конвенц, протоколуудын нэр
1	НҮБ-ын БСШУБ, Дэлхийн өвийн конвенц
1990	2 Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд хяналт тавих тухай Базелийн конвенц
1993	3 Биологийн олон янз байдлын тухай конвенц
4	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын конвенц
1994	5 Нүүдэллэдэг зэрлэг ан амьтдын төрөл зүйлийн тухай конвенц
6	Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенц
7	Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц
8	Озоны давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протокол
1996	9 Устах аюулд ороод байгаа зэрлэг амьтан, ургамлын олон улсын худалдааны тухай конвенц
10	Ус намгархаг газрын олон улсын ач холбогдлын тухай конвенц (Рамсар конвенц)
11	НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц
1998	12 Олон улсын худалдааны аюултай зарим химийн бодис, пестицидийн талаар урьд өмнө мэдэгдсэн зөвшөөрөл авах тухай Роттердамын конвенц
13	Удаан задардаг Органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц
1999	14 Цаг уурын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Киотогийн протокол
2003	15 Био аюулгүй байдлын тухай Картагенагийн протокол
2014	16 Биологийн олон янз байдлын конвенцын Үр шимийг хуваан хүртэх тухай Нагоягийн протокол
2016	17 Парисын хэлэлцээр

3.2.2 Байгаль орчны салбарын хууль эрх зүйн орчин

Байгаль орчны салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ерөнхий хуулиудыг /Хүснэгт 5/-д харуулав. Доорх томоохон хууль эрх зүйн зохицуулалтуудаас гадна тэдгээртэй нийцүүлэн гаргасан салбарын үйл ажиллагаа, бодлогыг зохицуулах зорилт бүхий 80 гаруй хууль тогтоомжууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хүснэгт 5. Байгаль орчны салбарын ерөнхий хуулиуд

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Хуулийн зорилго
1	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995.03.30	Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах
2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	2012.05.17	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулах
3	Агаарын тухай хууль	2012.05.17	Хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах
4	Амьтны тухай хууль	2012.05.17	Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах
5	Байгалийн ургамлын тухай хууль	1995.04.11	Ой болон таримал ургамлаас бусад ургамал /цаашид "ургамал" гэх/-ыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулах
6	Ойн тухай хууль	2012.05.17	Монгол Улсын ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах
7	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	1994.01.15	Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх,соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах,танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах
8	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль	1997.10.23	Тусгай хамгаалалттай газар нутагт орчны бүсийг тогтоох, орчны бүсэд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах
9	Усны тухай хууль	2012.05.17	Усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулах

10	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	2012.05.17	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус бохирдуулсны төлбөр ногдуулах, төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах
11	Ус цаг, уур орчны хяналт шинжилгээний тухай хууль.	1997.11.13	Ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах
12	Ургамал хамгааллын тухай хууль	2007.11.15	Бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах
13	Хог хаягдлын тухай хууль	2017.05.12	Хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулах
14	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	2012.05.17	Хөрсийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилтөөс сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах
15	Хими хорт болон аюултай бодисын тухай хууль	2006.05.25	Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах
16	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	2012.05.17	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6-р бүлэгт “Байгаль орчин, байгалийн баялгийг хамгаалах талаар аж ахуйн нэгж (ААН), байгууллагын үүрэг”-ийг хуульчилж заасан байгаа нь байгаль хамгаалах ажлыг зохион байгуулах бүтэц тогтолцооноос гадна байгаль хамгаалах ажлын санхүүжилтийн механизмыг өргөжүүлэн тодорхойлсон нэг арга хэлбэр болж байна. Судалгаагаар Монгол Улсад байгаль орчны чиглэлээр 500 гаруй мэргэжлийн байгууллагууд байна. Эдгээрийн дийлэнх нь ой, усны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.⁴ Энэхүү шинжилгээний хүрээнд байгаль орчны салбарын төрийн байгууллагуудын талаарх мэдээлэл дүн шинжилгээг багтаана.

4.1 Төрийн байгууллагын тогтолцоо

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар бүлэгт “Байгаль орчныг хамгаалах талаарх төрийн байгууллагын бүрэн эрх”-ийг хэрэгжүүлэх удирдлагын тогтолцоонд “Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг дарга, Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг дарга, Баг хорооны иргэдийн Нийтийн Хурал болон Засаг дарга”-ын бүрэн эрхийг тус тус тодорхойлсон байдаг. Байгаль орчны салбарын төрийн захиргааны төв байгууллага болох “Байгаль орчин, аялал жуулчлалын яам”-ны түүхэн замналыг /Хүснэгт 6/-д харуулав.

Хүснэгт 6. Байгаль орчны салбарын төрийн захиргааны төв байгууллагын түүхэн замнал


Байгуулагдсан он	Төрийн захиргааны төв байгууллагын нэр
1987 оны 12 сарын 09	Бүгд найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1987 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Бүгд найрамдах Монгол Ард Улсын зарим яамд байгуулах тухай” 169 дүгээр зарлигаар Байгаль орчныг хамгаалах яамыг анх байгуулсан түүхтэй.
1990 оны 9 сарын 26	“БНМАУ-ын Засгийн газрын бүрэлдэхүүнийг тогтоох тухай” хуулиар Байгаль орчны хяналтын улсын хороо
1992 оны 7 сарын 30	Монгол Улсын “Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар Байгаль орчны яам
1996 оны 7 сарын 25	1996 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай” хууль, Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 182 дугаар тогтоолоор Байгаль орчны яам
2000 оны 8 сарын 03	“Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар Байгаль орчны яам
2004 оны 9 сарын 22	“Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар Байгаль орчны яам
2008 оны 9 сарын 17	2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар Байгаль орчин, аялал жуулчлалын яам
2012 оны 8 сарын 16-	2012 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
2014 оны 12 сарын 04	2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
2016 оны 7 сарын 21	“Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай” хуулиар Байгаль орчин, аялал жуулчлалын яам нэртэйгээр өнөөг хүртэл үйл ажиллагаа явуулж байна.

Эх сурвалж: БОАЖЯ , 2024 он

⁴ Монгол Улсын биологийн олон янз байдлын санхүүжилтийн хэрэгцээ, бодлого, хандлага/BIOFIN/

Засгийн газрын 2023 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-дагуу Байгаль орчин аялал жуулчлалын яам нь 7-н газар, 4-н хэлтэс, 129 албан хаагчийн орон тоотой байхаар баталсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны бүтцийг /зураг 2/-т харуулж байна.


Зураг 2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны бүтэц



Эх сурвалж: БОАЖЯ , 2024 он

2023 оны байдлаар байгаль орчны салбарт нийт 147 төсөвт байгууллага үйл ажиллагаа эрхэлж байгаагаас улсын төсвөөс 83 байгууллага, орон нутгийн төсвөөс 64 байгууллага тус тус санхүүжсэн байна.

График 1. Улсын төсвөөс санхүүждэг байгаль орчны салбарын байгууллагуудын тоо, 2017-2024 он



Эх сурвалж: Сангийн яам, Fiscal, 2024 он

2017 онд байгаль орчны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг улсын төсвөөс санхүүждэг нийт 81 байгууллага байсан бол 2023 оны байдлаар 83 болж 2 байгууллагаар нэмэгдсэн байна. 2023 онд улсын төсвөөс санхүүжсэн байгууллагууд болон тэдгээрийг үйл ажиллагааны чиглэлийг /Хүснэгт 7/-д харуулав.

Байгууллагын нэр	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ
<p>Байгаль орчин, аялал жуулчлалын яам</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 20 дугаар зүйлийн 13 дах заалт:</p> <ul style="list-style-type: none"> • ногоон хөгжлийн бодлого • байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого • усны нэгдсэн бодлого • цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал • усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах асуудал • ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал, мэдээллийн сан • байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал • биоаюулгүй байдлын бодлогын асуудал • салбарын мэргэжлийн хяналтын асуудал • төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал • агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.
<p>Ойн газар (Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг)</p>	<p>Ойн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 3 дах заалт: 16.4. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • 14.3.1.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах, агро-ойн аж ахуйн талаарх хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, ойн аж ахуйн арга хэмжээг удирдан зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах • 14.3.2.улсын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих • 14.3.3.улсын ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх • 14.3.4.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ашиглах зориулалтаар батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулах, энэ хуулийн 30.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах • 14.3.5.ойн аж ахуйн арга хэмжээний заавар, аргачлалыг батлах, холбогдох стандарт, журмыг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх • 14.3.6.ойн мэргэжлийн боловсон хүчний давтан болон ойн мэргэшлийн зэрэг олгох сургалтыг энэ хуулийн 41.2.2-т заасныг үндэслэн холбогдох их, дээд сургуультай хамтран зохион байгуулах • 14.3.7.ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх шинэ техник, технологийг судлах, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүн, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх • 14.3.8.таримал ой ургуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангах, талуудын уялдаа холбоог зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх • 14.3.9.агро-ойн аж ахуйн арга хэмжээг удирдан зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах • 14.3.10.ойн аж ахуйн арга хэмжээний зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал хийх ажлыг зохион байгуулах, баталгаажуулах • 14.3.11.ойн үрийн улсын нөөцийн сан байгуулах, баяжуулах, үйл ажиллагааг эрхлэх, үржлийн материал бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэх • 14.3.12.үржлийн материалын гарал үүслийн болон чанарын гэрчилгээний загвар боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах • 14.3.13.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэргэмжлүүлэх, эргүүл, харуул ажиллуулах, бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тодорхой үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж, шийдвэрлүүлэх • 14.3.14.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

	<ul style="list-style-type: none"> • 14.3.15.хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах талаар бусад улстай гэрээ, хэлэлцээр байгуулж, хамтран ажиллах • 14.3.16.ашиглалтын болон хамгаалалтын бүсийн ойн менежментийг сайжруулах, ойн нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашиглахтай холбоотой ойн техник, технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх • 14.3.17.ойн экологи, эдийн засгийн үнэлгээг боловсруулах • 14.3.18.энэ хуулийн 7.2-т заасны дагуу ойн тооллого, ой зохион байгуулалт хийх, ойн мониторингийн системийг хөгжүүлэх, ойн сангийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх • 14.3.19.ойн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах • 14.3.20.таримал ойг улсын ойн санд хүлээн авах • 14.3.21.ойн ангийн үлгэрчилсэн дүрмийг батлах • 14.3.22.ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт гаргах • 14.3.23.ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох • 14.3.24.мод үржүүлэг, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагад газар эзэмшүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мөнгөн урамшуулал олгох, тэдгээрт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж шийдвэрлэх • 14.3.25.ойн нөөцийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх ажилд дотоод хяналтыг зохион байгуулах.
<p>Усны газар (Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг)</p>	<p>Усны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 16 дүгээр зүйл 4 дэх заалт: 16.4.Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага усны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • 16.4.1.улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, уг төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах • 16.4.2.усны хайгуул, зураг төсөл, судалгааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавих • 16.4.3.усны ашиглах боломжит нөөцийн хэмжээг сав газрын хэмжээнд ашиглалтын зориулалт бүрээр тогтоон боловсруулж мөрдүүлэх, хяналт тавих • 16.4.4.энэ хуулийн 4.9-д заасан ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг тогтоох санал боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих • 16.4.5.улсын усны мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх, усны төлөв байдалтай холбоотой мэдээллээр иргэн, хуулийн этгээдийг хангах • 16.4.6.улсын усны тоо бүртгэл, статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулах, усны нөөц, ус ашиглалтын тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах • 16.4.7.усны экологи-эдийн засгийн үнэлгээ, усны үнэ, тариф тогтоох чиглэлээр судалгаа хийх аргачлал, зааврыг боловсруулах, усны нөөцөд учруулсан хохирлыг тооцох • 16.4.8.ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартыг дэвшилтэт технологи, шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих • 16.4.9.энэ хуулийн 28.4-т заасны дагуу гаргасан ус ашиглах дүгнэлт, 28.6-д заасан ус ашиглах зөвшөөрөл, 28.11-д заасан гэрээнд хяналт тавих • 16.4.10.голын голдирлыг өөрчлөх, урсацад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах • 16.4.11.стратегийн томоохон орд газарт цооног өрөмдөх, ус ашиглах судалгаа хийхэд дүгнэлт гаргах • 16.4.12.ган, цөлжилт, хуурайшилтын үед усны нөөц хомсдох, бохирдсон тохиолдолд тухайн сав газарт ус ашиглагчийн ашиглах усыг хуваарилах, хязгаарлах, ус, түүний орчныг нөхөн сэргээх зорилгоор ус ашиглахыг тодорхой хугацаагаар түр хориглох • 16.4.13.бэлчээрийн усжуулалт, усалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд дүгнэлт гаргах • 16.4.14.бэлчээрийг усжуулах зориулалтаар инженерийн хийцтэй худаг байгуулах, уст цэг тогтоох хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төлөвлөгөөг боловсруулах • 16.4.15.хуульд заасан бусад бүрэн эрх.


<p>Сав газрын захиргаа (Гол нуур, тал, говь)</p>	<p>Усны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 17 дугаар зүйл 1 дэх заалт:</p> <p>17.1.Сав газрын захиргаа нь усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг тухайн сав газартаа хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • 17.1.1.сав газрын менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах • 17.1.2.сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, хэрэгжилтэд хяналт тавих • 17.1.3.бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг мэргэжлийн зөвлөмжөөр хангах • 17.1.4.усны тоо бүртгэлийг жил бүр сав газрын хэмжээнд нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж, усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах • 17.1.5.сав газрын усны мэдээллийн дэд санг эрхэлж, олон нийтийг мэдээллээр хангах • 17.1.6.ус ашиглах зорилгоор кооног өрөмдөх, худаг гаргах, суваг хоолой татах тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг үндэслэн энэ хуулийн 28.4-т заасны дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргах, улсын нөөцөд бүртгэгдсэн рашааныг эмчилгээ-сувилгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах талаар дүгнэлт гаргах, мэдээллийн санд оруулж бүртгэх • 17.1.7.ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулах үндэслэлийг тодорхойлох • 17.1.8.сав газрын хэмжээнд ус хангамжийн эх үүсвэрийн болон хаягдал ус зайлуулах цэг тогтоох • 17.1.9.ус ашиглах, хаягдал ус зайлуулах шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах, хаягдал ус зайлуулах эрхийг цуцлах дүгнэлт гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах • 17.1.10.сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах • 17.1.11.сав газрын зөвлөл байгуулах тухай саналыг харьяалагдах орон нутгийн захиргаатай зөвшилцөн боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах • 17.1.12.гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулах • 17.1.13.хаягдал усыг зохих журмын дагуу байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах. • 17.1.14.хуульд заасан бусад бүрэн эрх.
<p>Цаг уур, орчны шинжилгээний газар</p>	<p>Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйл 1 дэх заалт:</p> <p>6.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/ ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> • 6.1.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сүлжээний нэгжийг байгуулах, татан буулгах, шилжүүлэх • 6.1.2. ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шуурхай үйлчлэх, аюулт үзэгдэл, гамшиг, орчны бохирдлоос сэрэмжлүүлэх арга хэмжээ авах • 6.1.3.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдал, мэдээллийн стандартчиллыг хангах • 6.1.4.шаардлагатай тохиолдолд цаг агаарын төлөв байдал, цаг уурын үзэгдэлд нөлөөлөх ажиллагаа явуулах • 6.1.5.ус цаг уур, орчны шинжилгээний мэдээллийг цуглуулах, солилцоонд гаргахад олон улсын мэдээллийн суваг ашиглах асуудлыг зохицуулах, Дэлхийн цаг уурын байгууллагын конвенцийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх • 6.1.6.ус цаг уур, орчны төлөв байдлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах • 6.1.7.ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилтын ажлыг зохицуулах.
<p>Аймаг, нийслэлийн ус цаг уур, орчны шинжилгээний төвүүд</p>	

<p>Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн</p>	<ul style="list-style-type: none"> • Ус цаг уур, уур амьсгал, байгаль орчны бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр төр засаг, нийгэм-эдийн засаг, хүн амын эрэлт хэрэгцээг хангах. • Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний арга зүй, технологийг боловсруулах, үйлдвэрлэлийн туршилт хийх. • Ус цаг уур, уур амьсгал, байгаль орчин, тандан судалгаа, мэдээллийн технологийн чиглэлээр судалгаа хийх, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, технологи, төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, оролцох, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж, үнэлгээ гаргах, • Дэлхийн ажиглалтын бүлэг, Дэлхийн цаг уурын байгууллага болон бусад улс орон, олон улсын холбогдох хөтөлбөр, гэрээ, хэлэлцээртэй үйл ажиллагаа уялдуулах, Дэлхийн цаг уурын байгууллагын мэдээллийн сүлжээн дэх цаг уурын холбооны үндэсний төвийн үүргийг гүйцэтгэх, Зайнаас тандан судлах үндэсний төвийн үүргийг гүйцэтгэх. • Байгаль орчны мэдээллийн төвийн үүргийг гүйцэтгэж, мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, Орчил урсгал, урт хугацааны прогнозын судалгаа, арга зүй, технологи боловсруулах.
<p>Байгаль орчны шинжилгээний төв лаборатори</p>	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны бохирдлын хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх, арга зүйн удирдлагаар хангах, чанарын хяналт, чанарын баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх. • Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, цаг уурын багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалтын талаар арга зүйн зөвлөгөө өгөх, шалгах аргачлалыг бий болгох.
<p>Нислэгийн цаг уурын төв</p>	<ul style="list-style-type: none"> • Нислэгийн цаг уурын төв нь нислэгт аюулгүй ажиллагааг хангасан цаг агаарын төрөл бүрийн мэдээ, мэдээллээр шуурхай үйлчлэхэд оршино.
<p>Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв</p>	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлэх, бохирдлыг бууруулах, саармагжуулах, нөхөн сэргээх чиглэлээр, судалгаа, шинжилгээ хийж, байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, байгальд ээлтэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх сургалт, сурталчилгааг оновчтой явуулж, байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааг хөгжүүлэх.
<p>Байгаль орчин, уур амьсгалын сан</p>	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн төлөв байдлыг судлан тогтоох, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, өөрчлөлтөд засан зохицох, иргэдэд экологийн боловсрол олгох чиглэлээр сангийн хөрөнгийг оновчтой, үр ашигтай зарцуулахад оршино.
<p>Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв</p>	<ul style="list-style-type: none"> • Байгаль хамгаалах суурь зарчимд нийцүүлэн талуудын оролцоонд тулгуурласан үр ашигтай менежментийг хэрэгжүүлэх • Байгаль хамгаалах өсвөрийн байгаль хамгаалагчдын нэгдсэн сүлжээг бий болгох • Байгаль орчны сургалтын нэгдсэн төв болох • Эрдэм шинжилгээ, судалгааны хүрээг өргөжүүлэх замаар байгаль орчны судалгаа, эрдэм шинжилгээний мэдээллийн төв бий болгох • Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгээр манлайлсан байгаль орчны мэдээ мэдээллийн түүхээ болох.

<p>Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа</p>	<p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 30 дугаар зүйл:</p> <p>Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа /цаашид "хамгаалалтын захиргаа" гэх/ нь дараах үйл ажиллагаа явуулна:</p> <ul style="list-style-type: none"> • 1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах. • 2/ судалгаа, шинжилгээ хийх зөвшөөрөл авсан байгууллагатай гэрээ байгуулах, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих. • 3/ зохих журмын дагуу судалгаа, шинжилгээний зориулалтаар дээж, сорьц авах, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх. • 4/ ан амьтанд зориулан ус задгайлах, хадлан бэлтгэх, өвс тэжээл, хужир, шүү тавих, нөмөр хорго барих болон биотехникийн бусад арга хэмжээг зохих журмын дагуу гүйцэтгэх. • 5/ рашаан,эмчилгээ, сувилгааны зориулалттай эрдэс, байгалийн дагалт баялгийг зохих журмын дагуу ашиглуулах. • 6/ зөвшөөрөгдсөн аялал, жуулчлалын зам, чиглэлийг тэмдэгжүүлэх, шаардлагатай орон байр барих, тээврийн хэрэгслэлийн зогсоол гаргах, биеийн тамирын болон нийтийн бусад арга хэмжээ явуулах газар, журмыг тогтоох, эрүүл ахуйн нөхцөлийг нь хангах, тэдгээрийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран тохижуулах. • 7/ зөвшөөрөгдсөн бүс дэх сууринг тохижуулах, барилга байгууламж барих ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих. • 8/ уул, овоо тахиу,уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх ажиллагааг зохицуулах. • 9/ тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол, хамгаалалтын горим, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, он дарааллын бичиг хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх. • 11/тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтийг хангах.
<p>Дархан цаазат газрын хамгааллын захиргаа</p>	
<p>Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа</p>	

Улсын төсвөөс санхүүждэг дээрх байгууллагуудаас гадна аймаг, нийслэл, сум, дүүрэгт байгаль орчны салбарын бодлого, үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын мэдээллийг доорх зургаар харуулж байна.

График 2. Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгаль орчны салбарын байгууллагуудын тоо, 2017-2024 он



Эх сурвалж: Сангийн яам, Fiscal, 2024 он

Байгаль орчны салбарт 2017 оны байдлаар орон нутгийн төсвөөс санхүүждэг нийт 49 байгууллага үйл ажиллагаа эрхэлж байсан бол 2023 оны байдлаар 64 болж 15 байгууллагаар нэмэгдсэн ба 2024 онд зарим сумын болон сум дундын ойн ангиудын санхүүжилт батлагдаагүйтэй холбоотойгоор 57 байгууллагад төсөв батлагдсан

байна. 2023 онд орон нутгийн төсвөөс санхүүжсэн байгууллагууд болон тэдгээрийг үйл ажиллагааны чиглэлийг /Хүснэгт 8/-д харуулав.

Хүснэгт 8. 2023 онд орон нутгийн төсвөөс санхүүжсэн байгаль орчны салбарын байгууллагууд

Байгууллагын нэр	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ
Сум дундын ойн анги	<p>Ойн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 18 дугаар зүйлийн 3 дах заалт: 18.3.Сум дундын болон сум, дүүргийн ойн анги нь дараах эрх, үүрэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> • 18.3.1.ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах • 18.3.2.бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох • 18.3.3.сум, дүүргийнхээ мод бэлтгэсэн болон хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн газрын ойжуулалтын ажил, ойн хөнөөлт шавж, өвчний тоймчилсон судалгаа гүйцэтгэх • 18.3.4. ойг нөхөн сэргээх, ойжуулах, мод үржүүлэх ажил эрхлэн модны үр, тарьц, суулгац худалдаалах, ойд учирсан хохирлын экологи эдийн засгийн үнэлгээ тогтоох • 18.3.5.ойн арчилгааны гэрэлжүүлэх, тохируулах огтлолтыг гүйцэтгэх болон сум, дүүргийн ойн хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж хангуулах • 18.3.6.ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх • 18.3.7.ойн баялгийг ашигласны төлбөр, хураамжийг ногдуулж, тэдгээрийн гүйцэтгэлийг хангах • 18.3.8.аймаг, сумын түвшинд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох • 18.3.9.мэдээллийн санг эрхлэх • 18.3.10.иргэдэд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах • 18.3.11.ойг аюулт үзэгдэл, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэдгээртэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх • 18.3.12.ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, зөрчлийг арилгах • 18.3.13.ойн анги нь төсөв, түүнчлэн сургалт, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлсний болон өөрийн ажил, үйлчилгээний орлого зэрэг эх үүсвэрээс санхүүжих • 18.3.14.нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах • 18.3.15.ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд сумын нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах.
Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар	<p>Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар нь (цаашид “газар” гэнэ) аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчны багц хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.</p> <ul style="list-style-type: none"> • Газар нь байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, байгаль орчны сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг гүйцэтгэнэ. • “Төсвийн тухай хууль”-ийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, хяналт тавих, үйл ажиллагааг хэрэгжүүлэх. • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар санхүүгийн баталгаатай эх үүсвэрийг буй болгож, хэрэгжилтийг хангуулах, байгаль хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх. • Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд байгаль орчны багц хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд экологийн боловсрол олгох. • Байгаль орчны холбогдолтой судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах.

Байгууллагын нэр	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ
	<ul style="list-style-type: none"> Аймгийн нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмжээг нарийвчлан тогтоолгох, зөвшөөрөгдсөн хэмжээнд нь ашиглах.
<p>Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх /ЗДТГ/</p>	<p>Байгаль хамгаалах тухай хуулийн 3 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн заалт:</p> <ol style="list-style-type: none"> Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: <ul style="list-style-type: none"> 1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих 2/нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох 3/байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих 4/хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчинг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох 5/байгаль орчны төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх. 6/шинээр томилогдсон Засаг даргад тухайн нутгийн байгалийн нөөцийн санг энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-6 дахь заалтад заасан үзүүлэлтээр бүртгэж хүлээлгэн өгөх бөгөөд түүний өөрчлөлтийн тайланг жил тутам хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгч байна. 7/Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх газрын хэмжээ, байршлыг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал болон сумын Засаг даргаас санал авч тогтооно. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: <ul style="list-style-type: none"> 1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах 2/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах 3/байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь ирүүлэх 4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх 5/нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах 6/аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж томилох, чөлөөлөх 7/нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх 8/нөхөрлөлийн үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах 9/тухайн жилд нөхөрлөлийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэх


	<ul style="list-style-type: none"> • 10/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах • 11/хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлөхөд шаардагдах хөрөнгийг тухайн төсөл, арга хэмжээний төсөвт тусгуулах.
<p>Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх</p>	<p>Байгаль хамгаалах тухай хуулийн 3 дугаар бүлгийн 17 дугаар зүйлийн заалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: <ul style="list-style-type: none"> • 1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих • 2/нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн хэмжээг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу тогтоох • 4/байгаль орчныг хамгаалах талаар Засаг даргын ажлын тайлан хэлэлцэх • 5/нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлд хариуцуулах асуудлыг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн шийдвэрлэх • 6/энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад заасан үнэлэлт, дүгнэлт өгч байх • 7/нутаг дэвсгэртээ нөхөрлөлд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн үзэл баримтлалын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлах, хэрэгжилтийг хянах. 2. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: <ul style="list-style-type: none"> • 1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах • 2/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг хууль тогтоомжийн дагуу олгох • 3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгалийн баялгийн ашиглалтад хяналт тавьж, тэдний ургуулсан ой, ургамал, өсгөн үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан, засаж тохижуулсан газар, уст цэгийг хүлээн авах • 4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх • 5/байгаль хамгаалагчийн ажлыг удирдан чиглүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар орон нутгийн төсөвтөө тусган хангах, шаардлагатай бусад туслалцаа үзүүлэх • 6/аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын цэг тогтоох, бохирдлыг багасгах арга хэмжээ авах. • 7/энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад заасан шийдвэрийг үндэслэн иргэдийн нөхөрлөлд хариуцуулах байгалийн тодорхой төрлийн баялгаас нь зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих. • 8/байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах • 9/энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ нутгийн иргэдийн байгалийн нөөцийг зохистой ашиглах ухамсрыг төлөвшүүлэх, байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай тэмцэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх • 10/нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГСДЫН МЭДЭЭЛЭЛ

Байгаль орчны салбарт 2023 оны байдлаар нийт 147 төрийн байгууллагад 4,632 албан хаагч ажиллаж байна.


Үүнээс улсын төсвөөс санхүүждэг байгаль орчны салбарын байгууллагуудад 2017-2024 оны хугацаанд дунджаар 2,990 албан хаагч хөдөлмөр эрхэлсэн байна.

График 3. Улсын төсвөөс санхүүждэг байгаль орчны салбарын байгууллагууд ажилчдын тоо, 2017-2024 он



Улсын төсвөөс 2017 онд 81 байгууллага санхүүжиж, 2,858 албан хаагч хөдөлмөр эрхэлж байсан бол 2024 оны байдлаар 86 байгууллагад 3,191 албан хаагч хөдөлмөр эрхэлж 333 орон тоо нэмэгдсэн байна. Үүнээс дийлэнх буюу 84.2 хувийг гүйцэтгэх ажилтан эзэлж байгаа бол 4.6 хувийг удирдах ажилтан, 4.8 хувийг үйлчлэх ажилтан, 6.3 хувийг гэрээт ажилтан бүрдүүлж байна. Сүүлийн 4 жилийн хугацаанд гэрээт ажилтны тоо 0-ээс 201 болж нийт ажилчдын тоо 201-ээр нэмэгдсэн байна.

График 4. Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгаль орчны салбарын байгууллагууд ажилчдын тоо, 2017-2024 он



Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгаль орчны салбарын байгууллагуудад 2017-2024 оны дунджаар 1,235 албан хаагч хөдөлмөр эрхэлсэн байна. 2017 онд 49 байгууллагад 866.5 албан хаагч хөдөлмөр эрхэлж байсан бол 2024 оны байдлаар 57 байгууллагад 1,380 албан хаагч хөдөлмөр эрхэлж 513 орон тоо нэмэгдсэн байна.

Үүнээс дийлэнх буюу 71.9 хувийг гүйцэтгэх ажилтан эзэлж байгаа бол 4.3 хувийг удирдах ажилтан, 18.1 хувийг үйлчлэх ажилтан, 5.6 хувийг гэрээт ажилтан бүрдүүлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд гэрээт ажилтны тоо 14-өөс 77 болж 63 орон тоогоор нэмэгдсэн байна.

5.

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН МАКРО ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Байгаль орчны салбарын төсвийн зарлагын шинжилгээг хийхдээ 2015-2023 он хүртэлх хугацааны нэгдсэн төсвийн үзүүлэлтүүдийг хамруулан авч үзлээ⁵. Байгаль орчны салбарын төсвийн бодлого нь улсын болон орон нутгийн төсвийг хамруулан нэгдсэн төсвийн хүрээнд хэрэгждэг. Улсын төсвийн хувьд тайлант хугацаанд хоёр Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд улсын төсвөө батлуулж, төсвийн зарцуулалтын гүйцэтгэлээ тайлагнаж ирсэн бол орон нутгийн төсвийн хувьд⁶ аймаг, нийслэл, сум, дүүргийн Төсвийн Ерөнхийлөн Захирагч(ТЭЗ)-ийн хүрээнд салбарын төсвөө батлуулж, гүйцэтгэлээ тайлагнаж байна.

Хүснэгт 9. Салбарын харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч


Харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч	Он
Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд /БОНХАЖЯ/	2015-2016 он
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /БОАЖЯ/	2016.07.21оноос хойш

Байгаль орчны салбарын төсвийн зарлагын макро үзүүлэлтүүдэд байгаль орчны салбарын батлагдсан төсөв болон гүйцэтгэлийн ерөнхий чиг хандлагыг Дотоодын Нийт Бүтээгдэхүүн(ДНБ) болон нэгдсэн төсвийн нийт гүйцэтгэлд харьцуулсан дүн шинжилгээг хамруулна.

5.1 Салбарын макро үзүүлэлтүүдийн нөхцөл байдал

Байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2015 онд 58.3 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 228.3 тэрбум төгрөг болж 3.9 дахин өссөн байна. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийг ДНБ-тэй харьцуулахад 2015 онд 0.3 хувь байсан бол 2023 онд дүнд эзлэх хувь өөрчлөгдөөгүй ба тайлант хугацаанд жилд дунджаар 0.3 хувийг эзэлж байна/График 5/. Энэ нь нэрлэсэн ДНБ болон салбарын зардал ойролцоо түвшинд өссөнтэй холбоотой. Өөрөөр хэлбэл 2015 оны нэрлэсэн ДНБ 22.9 их наяд төгрөгөөс 2023 онд 68.9 их наяд төгрөг болж 3.0 дахин өссөн байна.

График 5. Салбарын төсвийн зарлагын ДНБ ба нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувь/тб.₮/



⁵Тооцоололд ашигласан тоон мэдээллүүдийг СЯ-ны төсвийн фискал систем болон Төрийн сангийн газрын төсвийн гүйцэтгэлийн мэдээллүүдэд үндэслэн, судлаачийн зүгээс тоон мэдээллийн базэ үүсгэж энэхүү шинжилгээнд ашигласан болно.


⁶21 аймаг, 330 сум, нийслэл 9 дүүргийг хамарна.

Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийг нэгдсэн төсвийн нийт зарлагатай харьцуулахад 2015 онд 0.8 хувь байсан бол 2023 онд 1.0 хувь болж 0.2 нэгж хувиар өссөн ба тайлант хугацаанд жилд дунджаар 1.0 хувийг эзэлж байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага 2015 онд 7.1 их наяд төгрөг байсан бол 2023 онд 22.4 их наяд төгрөгт хүрч 3.1 дахин өссөн байна. Энэ нь салбарын төсвийн зарлагын есөлт нэгдсэн нийт төсвийн зарлагын есөлтөөс өндрөөр өссөнтэй холбоотой юм.


Монгол Улсын хувьд байгаль орчны салбарт төрөөс зарцуулж байгаа төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ/График 6/ хөгжиж буй улс орнуудынхтай ойролцоо боловч хөгжингүй улс орнууд болон дэлхийн дунджаас ойролцоогоор 2 дахин бага байна.

График 6. Улс орнуудын ДНБ-д эзэлж буй байгаль орчны салбарын зардал, хувиар



Дэлхийн улс орнуудад байгаль орчны салбарын төсвийн зардал нь ДНБ-ий 0.8 орчим хувийг эзэлж байгаагаас дийлэнх буюу 0.3 хувийг хог хаягдлын менежментийн арга хэмжээнд зарцуулдаг байна. Монгол Улсын хувьд байгаль орчны салбарын төсвийн зардал бусад улсуудын дундажтай харьцуулахад 0.4 нэгж хувиар бага буюу ДНБ-ий 0.3 орчим хувьтай тэнцэж байна.

График 7. Улс орнуудын нэгдсэн төсвийн зардалд эзэлж буй байгаль орчны салбарын зардал, хувиар



Үүнээс гадна дэлхийн улс орнуудад байгаль орчны салбарын зардал нь нэгдсэн төсвийн нийт зардлынхаа 1.7 орчим хувийг эзэлдэг бол Монгол Улсын хувьд дунджаас 0.7 нэгж хувиар бага буюу нэгдсэн төсвийн нийт зардлын 1.0 орчим хувийг эзэлж байна⁷.

ДНБ болон нийт зардалд эзэлж буй байгаль орчны салбарын зардал бусад улсуудтай харьцуулахад дундаж түвшинтэй ойролцоо байгаа хэдий ч эдгээр улсуудын 1 кв.2 газар нутагт зарцуулж буй төсвийн зардал нь жилд дунджаар 900 орчим сая төгрөгтэй тэнцдэг бол Монгол улсын хувьд 0.13 сая төгрөгтэй тэнцэж байгаа нь маш бага дүн юм.


5.2 Салбарын нэгдсэн төсвийн зарлагын шинжилгээ

5.2.1 Салбарын нэгдсэн төсвийн зарлага

Байгаль орчны салбарын батлагдсан төсөв 2015 онд 64.6 тэрбум төгрөг байснаас 2023 онд 263.8 тэрбум төгрөгт хүрч 4.0 дахин өссөн бол төсвийн зарлагын гүйцэтгэлийн хувьд 58.3 тэрбум төгрөгөөс 228.3 тэрбум төгрөг болж 3.9 дахин өссөн байна.

2015-2023 оны хугацаанд салбарын батлагдсан төсөв жилд дунджаар 20.8 хувиар, салбарт зарцуулсан төсөв 20.9 хувиар тус тус өссөн бөгөөд тухайн 9 жилийн хугацаанд салбарт нийт 1,360.3 тэрбум төгрөгийн зардал төлөвлөснөөс 1,241.6 тэрбум төгрөгийг бүрэн зарцуулсан ба жилийн дундаж төсвийн зарлагын гүйцэтгэл 91.8 хувьтай байна.

График 8. Салбарын батлагдсан болон зарцуулсан нэгдсэн төсвийн зарлага/тб.₮/




Салбарын нэгдсэн төсвийн гүйцэтгэл 2016 он, 2017 он, 2019 он, 2021 онуудад дундаж гүйцэтгэлийн хувиас дээгүүр байсан бол 2015 он, 2018 он, 2020 он, 2022 он, 2023 онуудад дундаж гүйцэтгэлийн хувиас доогуур /График 9/ бөгөөд сүүлийн 2 жилийн гүйцэтгэл огцом буурсан байна.

Байгаль орчны салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл 2015-2023 оны хугацаанд дунджаар 92.3 хувийн гүйцэтгэлтэй байсан бол 2020 онд 87.5 хувьд хүрсэн нь дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахлын үеийн хөл хорионы нөхцөл байдалтай холбоотой бол сүүлийн 2 жилийн хувьд агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн гүйцэтгэл хангалтгүй байсан нь салбарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн байна.

⁷COFOG- Environmental protection ангиллаар зардлаа ангилдаг улсуудтай харьцуулав.

График 9. Салбарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хувь




Төсвийн гүйцэтгэл нь төсвийг зөв төлөвлөж, батлагдсан төсвийг зөв удирдан гүйцэд зарцуулан төсвийн найдвартай, нийцтэй байдлыг хангах нь татвар төлөгчдийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж байгааг илтгэх шалгуур болдог.

5.2.2 Салбарын улсын болон орон нутгийн төсвийн зарлага


2015-2023 оны дунджаар байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зарлагын 68 хувь буюу 93.3 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 32 хувь буюу 44.7 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлсэн байна. Салбарын улсын төсвийн зардал 2015 онд 38.4 тэрбум төгрөг байсан бол 2023 оны байдлаар 3.5 дахин өсөж 132.5 тэрбум төгрөгт хүрсэн бол орон нутгийн төсвийн зардлын хувьд 2015 онд 19.9 тэрбум төгрөг байснаас 4.8 дахин өсөж 96.0 тэрбум төгрөгт хүрсэн байна.

График 10. Байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилтийн эх үүсвэрээр /тб.₮/




2015-2023 оны хугацаанд байгаль орчны салбарт улсын төсвөөс нийтдээ 839.6 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд жилд дунджаар 20.6%-аар өссөн бол 2022 онд 29.4 хувиар буурсан байна/График 11/. Энэхүү бууралтад хүрээлэн буй орчны бохирдол, доройтол, агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, ус цагуур, орчны шинжилгээ зэрэг хөтөлбөрүүдийн зардлын бууралт голлон нөлөөлсөн байна.

График 11. Байгаль орчны салбарын улсын төсвийн зарлага/тб.₮/, өсөлт




2015-2023 оны хугацаанд байгаль орчны салбарт орон нутгийн төсвөөс нийтдээ 402.0 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд жилд дунджаар 23.3%-аар өссөн байна. Салбарын орон нутгийн төсвийн зарлага 2017 онд өмнөх оноос 12 хувиар буурсан бол бусад жилүүдэд харьцангуй тогтвортой өссөн байна/График 12/.

График 12. Байгаль орчны салбарын орон нутгийн төсвийн зарлага/тб.₮/, өсөлт



2023 оны байдлаар орон нутгийн төсвийн нийт зардлын дийлэнх буюу 46.4 хувийг Улаанбаатар, 7.8 хувийг Булган, 5.1 хувийг Дархан-Уул, 4.1 хувийг Сэлэнгэ аймаг, 4.0 хувийг Төв аймагт зарцуулсан байна. Харин Дундговь, Говьсүмбэр, Өвөрхангай аймгууд хамгийн бага буюу нийт зардлын 0.7-1.0 хувийг зарцуулсан байгааг /Зураг 3/-т харуулав.

Зураг 3. Орон нутгийн төсвийн зарлагад аймгуудын эзлэх хувь



Байгаль орчны салбарын 2015-2023 оны хугацаанд батлагдсан төсвийн зардал болон төсвийн зарлагын гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувийг санхүүжилтийн эх үүсвэрээр алган /Хүснэгт 10/-т харуулав.

Хүснэгт 10. Салбарын батлагдсан төсөв ба гүйцэтгэл, санхүүжүүлэх эх үүсвэрээр

Төсвийн жил	Нэгдсэн төсөв				Улсын төсөв			Орон нутгийн төсөв		
	Бат /тб.төг/	Гүйц /тб.төг/	Зөрүү /тб.төг/	Гүйц%/	Бат /тб.төг/	Гүйц /тб.төг/	Гүйц%/	Бат /тб.төг/	Гүйц /тб.төг/	Гүйц%/
2015	64.6	58.3	(6.3)	90.3%	41.2	38.4	93.1%	23.4	19.9	85.3%
2016	74.2	68.6	(5.6)	92.5%	45.2	42.8	94.9%	29.0	25.8	88.8%
2017	76.8	73.4	(3.4)	95.6%	53.0	50.7	95.7%	23.8	22.7	95.4%
2018	102.2	92.4	(9.8)	90.4%	76.1	68.8	90.3%	26.0	23.6	90.8%
2019	167.3	161.2	(6.2)	96.3%	122.7	128.3	104.6%	44.7	32.8	73.5%
2020	206.7	180.8	(25.9)	87.5%	137.3	130.4	95.0%	69.5	50.4	72.6%
2021	199.2	205.9	6.7	103.3%	132.5	145.3	109.7%	66.7	60.6	90.8%
2022	205.5	172.7	(32.8)	84.0%	124.6	102.5	82.3%	80.9	70.2	86.7%
2023	263.8	228.3	(35.5)	86.6%	149.9	132.4	88.3%	113.9	96.0	84.3%
2015-2023	151.1	138.0	(13.2)	91.8%	98.0	93.3	94.9%	53.1	44.7	85.4%

Дээр дурдсанчлан 2015-2023 оны хугацаанд байгаль орчны салбарын улсын төсөв жилд дунджаар 91.8 хувийн гүйцэтгэлтэй, орон нутгийн төсөв 85.4 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Салбарын төсөвт байгууллагууд, институт, хөдөлмөр эрхлэлтийн талаар бүлэг 4-т дэлгэрэнгүй дурдсан болно.

6.1 Улсын төсөвт байгууллагуудын зарлагын гүйцэтгэл

Улсын төсвөөс 2023 оны байдлаар нийт 83 байгууллага санхүүжсэн ба нийт 149.9 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж 88.3 хувийн гүйцэтгэлтэйгээр 132.4 тэрбум төгрөгийг байгаль орчны салбарт зарцуулсан байна.

Хүснэгт 11. Салбарын томоохон байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он

	БАЙГУУЛЛАГУУД	Батлагдсан /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /сая.төг/	Гүйцэтгэлийн хувь
№	НИЙТ ТӨСӨВ	121,438.4	107,645.4	13,793.1	88.6%
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	50,995.9	39,129.2	-11,345.9	76.7%
2	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (22)	39,202.4	38,576.6	-625.8	98.4%
3	Ойн газар	15,741.8	14,698.2	-1,043.6	93.4%
4	Цаг уур, орчны шинжилгээний газар	5,281.6	5,240.5	-41.1	99.2%
5	Усны газар	2,951.7	2,819.1	-132.5	95.5%
6	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн	2,436.3	2,425.6	-10.7	99.6%
7	Нислэгийн цаг уурын төв	1,677.5	1,635.5	-41.9	97.5%
8	Байгаль орчны шинжилгээний төв лаборатори	1,067.2	1,061.9	-5.4	99.5%
9	Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв	703.7	701.9	-1.7	99.8%
10	Байгаль орчин, уур амьсгалын сан	691.7	677.5	-14.3	97.9%
11	Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв УТҮГ	688.6	679.4	-9.3	98.7%

Дээрх байгууллагууд нь салбарын улсын төсвийн зардлын 91.6 хувь буюу 121.4 тэрбум төгрөгийг эзэлж байна. Салбарын улсын төсвийн нийт зардлын 29.5 хувь буюу 39.1 тэрбум төгрөгийг БОАЖЯ дангаараа эзэлдэг ба 2023 оны байдлаар байгаль орчны салбарын байгууллагуудаас хамгийн бага гүйцэтгэлтэй буюу 76.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл 57.6 хувьтай биелсэн нь голлон нөлөөлсөн байна. Үүнээс гадна салбарын улсын төсвийн 29.1 хувь буюу 38.6 тэрбум төгрөгийг 21 аймаг болон нийслэлийн Ус цаг уур, орчны шинжилгээний газар, 11.1 хувь буюу 14.7 тэрбум төгрөгийг Ойн газар тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. УТХГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он

	БАЙГУУЛЛАГУУД	Батлагдсан /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /сая.төг/	Гүйцэтгэлийн хувь
	НИЙТ ТӨСӨВ	7,049.9	6,210.00	839.9	88.1%
1	Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргаа	1,635.2	1,487.8	-147.5	91.0%
2	Хөвсгөлийн УТХГ-ын хамгаалалтын захиргаа	1,225.7	1,078.2	-147.4	88.0%
3	Улаан тайгын УТХГ-ын хамгаалалтын захиргаа	1,145.2	876.9	-268.3	76.6%
4	Увс нуурын ай савын УТХГ-ын хамгаалалтын захиргаа	901.5	846.6	-54.9	93.9%
5	Хар - Ус нуурын УТХГ-ын хамгаалалтын захиргаа	737.1	633.3	-103.7	85.9%
6	Хан-Хөхийн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаа	714.8	630.7	-84.1	88.2%
7	Монгол Алтайн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаа	690.6	656.5	-34.1	95.1%

УТХГ-уудын хамгаалалтын захиргааны нийт төсвийн зардал нь салбарын улсын төсвийн нийт зардлын 4.7 хувь буюу 6.2 тэрбум төгрөгийг эзэлж байгаа бөгөөд нэг УТХГ-ын хамгаалалтын захиргаанд жилд дунджаар 890 сая төгрөгийг зарцуулж байна.

УТХГ-уудын хамгаалалтын захиргаанаас Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зардал хамгийн их буюу 1.5 тэрбум төгрөг байна. Тус байгууллагын нийт зардлын 96.9 хувь буюу 1.44 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардал (43.4 хувийг үндсэн цалин, 17.8 хувийг нэмэгдэл, 4.9 хувийг унаа хоолны хөнгөлөлт, 5.6 хувийг урамшуулал, 2.8 хувийг байрны түрээс, 2.4 хувийг тээвэр шатахуун, 6.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 2.7 хувийг бараа үйлчилгээний бусад зардал)-д, ердөө 1 хувийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд, 0.8 хувийг ургамал хамгааллын зардалд тус тус зарцуулж байна.

Хүснэгт 13. ДЦГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он

	БАЙГУУЛЛАГУУД	Батлагдсан /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /сая.төг/	Гүйцэтгэлийн хувь
	НИЙТ ТӨСӨВ	6,757.2	5,750.9	1,006.3	85.1%
1	Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргаа	1,430.9	1,352.8	-78.1	94.5%
2	Говийн бага ДЦГ-ын хамгаалалтын захиргаа	748.62	704.33	-44.3	94.10%
3	Отгонтэнгэрийн ДЦГ-ын хамгаалалтын захиргаа	733.79	642.51	-91.28	87.60%
4	Говийн Их ДЦГ-ын А" хэсгийн хамгаалалтын захиргаа"	743.91	612.35	-131.56	82.30%
5	Зэд хантай бүтээлийн нурууны ДЦГ-ын хамгаалалтын захиргаа	689.55	567.91	-121.64	82.40%
6	Говийн Их ДЦГ-ын Б" хэсгийн хамгаалалтын захиргаа"	777.73	557.82	-219.92	71.70%
7	Дорнодын ДЦГ-ын хамгаалалтын захиргаа	723.02	510.07	-212.95	70.50%
8	Нөмрөгийн ДЦГ-ын хамгаалалтын захиргаа	495.88	404.39	-91.5	81.50%
9	Хөх сэрхийн нурууны ДЦГ-ын хамгаалалтын захиргаа	413.88	398.81	-15.06	96.40%

ДЦГ-уудын хамгаалалтын захиргааны нийт төсвийн зардал нь салбарын улсын төсвийн нийт зардлын 4.3 хувь буюу 5.8 тэрбум төгрөгийг эзэлж байгаа бөгөөд нэг ДЦГ-ын хамгаалалтын захиргаанд жилд дунджаар 640 орчим сая төгрөгийг зарцуулж байна. Эдгээр байгууллагууд нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрт чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг.

ДЦГ-уудын хамгаалалтын захиргаанаас Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зардал хамгийн их буюу 1.4 тэрбум төгрөг байна. Тус байгууллагын нийт зардлын 92.0 хувь буюу 1.24 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардал (29.9 хувийг үндсэн цалин, 6.5 хувийг нэмэгдэл, 6.3 хувийг унаа хоолны хөнгөлөлт, 5.4 хувийг урамшуулал, 3.9 тэтгэврийн даатгал, 3.0 хувийг урсгал засвар, 3.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 18.7 хувийг газрын төлбөр)-д, 4.6 хувийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд, 1.0 хувийг ургамал хамгааллын зардалд тус тус зарцуулж байна.

Хүснэгт 14. БЦГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он

	БАЙГУУЛЛАГУУД	Батлагдсан /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /сая.төг/	Гүйцэтгэлийн хувь
	НИЙТ ТӨСӨВ	8,948.4	7,683.3	1,265.1	85.9%
1	Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	874.4	778.6	-95.8	89.0%
2	Говь-Гурван сайханы БЦГ-ын хамгаалалтын захиргаа	961.7	753.8	-207.9	78.4%
3	Онон Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	700.5	675.1	-25.4	96.4%
4	Орхоны хөндийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	710.3	666.4	-43.9	93.8%
5	Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	678.2	647.5	-30.7	95.5%
6	Тарвагтайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	657.4	588.4	-69.1	89.5%
7	Мөнххайрханы БЦГ-ын хамгаалалтын захиргаа	718.9	554.9	-164.0	77.2%
8	Их богдын БЦГ-ын хамгаалалтын захиргаа	668.2	519.1	-149.1	77.7%
9	Мянган угалзатын нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	520.1	425.5	-94.7	81.8%
10	Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргаа	517.4	412.5	-104.8	79.7%
11	Монгол элсний БЦГ-ын хамгаалалтын захиргаа	425.3	405.1	-20.2	95.3%
12	Тужийн нарсны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	403.8	361.8	-41.9	89.6%
13	Хөгнө-Тарнын БЦГ-ын хамгаалалтын захиргаа	460.6	353.4	-107.2	76.7%
14	Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа	365.4	295.2	-70.2	80.8%
15	Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ	286.3	246.3	-40.1	86.0%

БЦГ-уудын хамгаалалтын захиргааны нийт төсвийн зардал нь салбарын улсын төсвийн нийт зардлын 5.8 хувь буюу 7.7 тэрбум төгрөгийг эзэлж байгаа бөгөөд нэг БЦГ-ын хамгаалалтын захиргаанд жилд дунджаар 510 орчим сая төгрөгийг зарцуулж байна. Эдгээр байгууллагууд нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрт чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг.

БЦГ-уудын хамгаалалтын захиргаанаас Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын

захиргааны төсвийн зардал хамгийн их буюу 778.6 тэрбум төгрөг байна. Тус байгууллагын нийт зардлын 95.0 хувь буюу 736.3 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардал (34.2 хувийг үндсэн цалин, 12.6 хувийг нэмэгдэл, 6.9 тэтгэврийн даатгал, 4.1 хувийг тээвэр шатахуун, 8.3 хувийг урсгал засвар, 3.9 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 3.8 хувийг бараа, үйлчилгээний зардал)-д, 1.5 хувийг хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, 2.1 хувийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд, 1.5 хувийг ургамал хамгааллын зардалд тус тус зарцуулж байна.

Хүснэгт 15. Сав газрын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он

	БАЙГУУЛЛАГУУД	Батлагдсан /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /сая.төг/	Гүйцэтгэлийн хувь
	НИЙТ ТӨСӨВ	5,709.80	5,242.01	467.79	91.8%
1	Туул голын сав газрын захиргаа	527.07	435.77	-91.31	82.7%
2	Орхон-Чулуут голын сав газрын захиргаа	369.8	369.8	0	100.0%
3	Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаа	316.6	299.6	-17	94.6%
4	Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа	307.0	278.5	-28.47	90.7%
5	Онон-Улз голын сав газрын захиргаа	271.2	268.2	-3	98.9%
6	Хөвсгөл-Эгийн голын сав газрын захиргаа	253.8	251.4	-2.4	99.1%
7	Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаа	275.7	245.1	-30.6	88.9%
8	Алтайн өвөр говийн сав газрын захиргаа	243.3	243.0	-0.3	99.9%
9	Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаа	282.6	241.0	-41.6	85.3%
10	Бөөнцагаан нуур-Орог нуур сав газрын захиргаа	247.5	240.5	-6.9	97.2%
11	Сэлэнгийн голын сав газрын захиргаа	267.9	235.6	-32.4	87.9%
12	Идэр голын сав газрын захиргаа	259.5	234.9	-24.6	90.5%
13	Хүйсийн говь-Цэцэг нуур сав газрын захиргаа	265.7	233.4	-32.3	87.8%
14	Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа	249.3	230.8	-18.4	92.6%
15	Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа	230	229.9	-0.1	100.0%
16	Онги-Таац голын сав газрын захиргаа	244.2	224.5	-19.8	91.9%
17	Хараа-Ерөө голын сав газрын захиргаа	249.6	212.1	-37.6	84.9%
18	Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргаа	206.1	205.8	-0.3	99.8%
19	Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа	242.3	205.3	-36.9	84.7%
20	Хэрлэн голын сав газрын захиргаа	206.0	191.6	-14.4	93.0%
21	Хануй голын сав газрын захиргаа	194.6	165.1	-29.5	84.9%

Сав газруудын захиргааны нийт төсвийн зардал нь салбарын улсын төсвийн нийт зардлын 4.0 хувь буюу 5.2 тэрбум төгрөгийг эзэлж байгаа бөгөөд нэг сав газрын захиргаанд жилд дунджаар 250 орчим сая төгрөгийг зарцуулж байна. Эдгээр байгууллагууд нь усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрт чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг.

Сав газрын захиргаануудаас Туул голын сав газрын захиргааны төсвийн зардал хамгийн их буюу 435.8 сая төгрөг байна. Тус байгууллагын нийт зардлыг бүхэлд нь

үндсэн үйл ажиллагааны зардал(52.2 хувийг үндсэн цалин, 9.5 хувийг нэмэгдэл, 12.6 хувийг унаа хоолны хөнгөлөлт, 4.6 хувийг урамшуулал, 6.7 хувийг тэтгэврийн даатгал, 1.9 хувийг тээвэр шатахуун, 2.4 хувийг багаж, техник, хэрэгсэл, 1.6 хувийг дотоод албан томилолт, 2.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 3.8 хувийг бараа, үйлчилгээний зардал)-д зарцуулж байна.

6.2 Орон нутгийн төсөвт байгууллагуудын зарлагын гүйцэтгэл

Орон нутгийн төсвөөс 2023 оны байдлаар байгаль орчны салбарын нийт 64 байгууллага санхүүжсэн бол хүрээлэн буй орчны хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд бусад 88 байгууллага санхүүжиж нийт 113.9 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж 84.3 хувийн гүйцэтгэлтэйгээр 96.0 тэрбум төгрөгийг байгаль орчны салбарт зарцуулсан байна.

6.2.1 Байгаль орчны салбарын байгууллагуудын зарлагын шинжилгээ

Хүснэгт 16. Аймгуудын байгаль орчны салбарын бодлого хариуцсан газруудын зарлагын гүйцэтгэл, 2023 он

БАЙГУУЛЛАГУУД		Батлагдсан /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /сая.төг/	Гүйцэтгэлийн хувь
НИЙТ ТӨСӨВ		28,008.29	25,861.89	-2,146.39	92.3%
1	Ар.БОАЖГазар	1,307.1	1,251.7	(55.4)	95.8%
2	Бө.БОАЖГазар	884.1	884.0	(0.1)	100.0%
3	Бу.БОАЖГазар	1,311.7	1,250.2	(61.5)	95.3%
4	Бх.БОАЖГазар	1,121.1	1,115.6	(5.5)	99.5%
5	Га.БОАЖГазар	1,225.3	1,172.3	(53.0)	95.7%
6	Гс.БОАЖГазар	546.1	495.0	(51.1)	90.6%
7	Да.БОАЖГазар	854.6	485.4	(369.2)	56.8%
8	Дд.БОАЖГазар	2,442.5	2,003.0	(439.5)	82.0%
9	До.БОАЖГазар	1,879.5	1,786.7	(92.7)	95.1%
10	Ду.БОАЖГазар	578.8	574.9	(3.8)	99.3%
11	За.БОАЖГазар	1,441.5	1,439.4	(2.1)	99.9%
12	Ор.БОАЖГазар	514.1	502.0	(12.1)	97.6%
13	Өв.БОАЖГазар	883.1	786.3	(96.8)	89.0%
14	Өм.БОАЖГазар	1,054.4	887.3	(167.1)	84.1%
15	Сү.БОАЖГазар	1,274.8	1,036.7	(238.1)	81.3%
16	Сэ.БОАЖГазар	3,271.7	3,152.9	(118.9)	96.4%
17	Тө.БОАЖГазар	1,191.4	1,165.7	(25.6)	97.8%
18	Ув.БОАЖГазар	1,283.3	1,281.6	(1.7)	99.9%
19	Хо.БОАЖГазар	946.9	944.7	(2.2)	99.8%
20	Хө.БОАЖГазар	2,544.6	2,303.7	(240.9)	90.5%
21	Хэ.БОАЖГазар	1,451.9	1,342.9	(109.0)	92.5%

Орон нутгийн төсвөөс санхүүждэг 21 аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар(БОАЖГ) нь салбарын орон нутгийн төсвийн нийт зардлын 26.9 хувь буюу 25.9 тэрбум төгрөгийг эзэлж байгаа бөгөөд нэг аймгийн БОАЖГ-т дунджаар 1.2 тэрбум төгрөг зарцуулж байна.

Аймгуудын БОАЖГ-уудаас Сэлэнгэ аймгийн БОАЖГ-ын төсвийн зардал хамгийн их буюу 3.2 тэрбум төгрөг байна. Тус байгууллагын нийт зардлыг бүхэлд нь байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрт зарцуулж байгаа бөгөөд 52.1 хувийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан бол 45.8 хувийг үндсэн үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 17. Ойн ангиудын зарлагын гүйцэтгэл, 2023 он

	БАЙГУУЛЛАГУУД	Батлагдсан төсөв/сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /сая.төг/	Гүйцэтгэлийн хувь
	НИЙТ ТӨСӨВ	6,628.6	5,946.2	(681.0)	89.7%
1	Ар.Ихтамир СД ойн анги	85.8	76.5	(9.4)	89.1%
2	Ар.Цэнхэр СД ойн анги	107.9	106.4	(1.5)	98.6%
3	Ар.Эрдэнэмандал СД ойн анги	83.1	80.4	(2.7)	96.8%
4	Бө.Сум дундын ойн анги	95.6	95.6	-	100.0%
5	Бу.Булган Ойн анги	84.4	80.2	(4.2)	95.0%
6	Бу.Хутаг-Өндөр Ойн анги	87.4	67.3	(20.2)	76.9%
7	Бу.Хял сум дундын ойн анги	129.2	128.9	(0.3)	99.8%
8	Га.Ойн анги	186.0	168.3	(17.7)	90.5%
9	Гс.Сум дундын ойн анги	228.8	216.6	(12.2)	94.6%
10	Да.Сум дундын ойн анги	87.2	65.8	(21.4)	75.4%
11	Дд.Баян-уул СД ойн анги	98.6	97.4	(1.2)	98.7%
12	Дд.Халхгол Сум дундын ойн анги	74.5	73.3	(1.2)	98.5%
13	До.Замын-Үүд ойн анги	454.1	446.1	(8.0)	98.2%
14	Ду.Сум дундын ойн анги	69.7	68.7	(1.0)	98.6%
15	За.Ойн анги	166.6	161.7	(4.9)	97.0%
16	За.Түдэвтэй Ойн анги	56.8	53.5	(3.4)	94.1%
17	Ор.Сум дундын ойн анги	337.7	318.3	(19.3)	94.3%
18	Өв.Сум дундын ойн анги	151.2	150.7	(0.4)	99.7%
19	Өм.Ойн анги	1,417.5	1,108.6	(308.9)	78.2%
20	Өм.Сэврэй Сум дундын ойн анги	89.5	74.6	(14.9)	83.3%
21	Өм.Цогтовоо Сум дундын ойн анги	118.8	63.0	(55.8)	53.0%
22	Сэ.Баруунбүрэн СД ойн анги	66.1	64.4	(1.7)	97.4%
23	Сэ.Ерөө СД ойн анги	197.0	167.8	(29.2)	85.2%
24	Сэ.Мандал Ойн анги	256.6	240.2	(16.4)	93.6%
25	Сэ.Сүхбаатар Ойн анги	163.4	142.1	(21.3)	87.0%
26	Сэ.Сэлэнгэ бүсийн СД ойн анги	131.1	129.0	(2.1)	98.4%
27	Тө.Батсүмбэр Ойн анги	103.8	102.2	(1.6)	98.5%
28	Тө.Лүн Сум дундын ойн анги	469.3	464.2	(5.1)	98.9%
29	Тө.Мөнгөнморьт Ойн анги	89.3	76.1	(13.3)	85.2%
30	Ув.Малчин Ойн анги	81.9	70.2	(11.6)	85.8%
31	Ув.Өндөрхангай СД ойн анги	87.7	80.8	(6.9)	92.1%
32	Ув.Түргэн СД ойн анги	99.9	90.1	(9.8)	90.2%
33	Хо.Ойн анги	106.1	103.1	(3.0)	97.2%
34	Хө.Жаргалант Ойн анги	54.0	54.0	-	100.0%
35	Хө.Мөрөн Ойн анги	68.4	68.4	-	100.0%
36	Хө.Нарс шинэсэн төгөл ойн анги	54.0	54.0	-	100.0%
37	Хө.Улаан-Уул Ойн анги	54.0	54.0	-	100.0%
38	Хэ.Батширээт ойн анги	108.9	87.0	(21.9)	79.9%
39	Хэ.Биндэр Сум дундын ойн анги	111.7	95.7	(16.0)	85.7%
40	Хэ.Өм Хэнтий Шинэс ойн анги	115.0	101.3	(13.8)	88.0%

Орон нутгийн төсвөөс аймаг, сум, сумдын дундын нийт 40 ойн анги санхүүждэг ба эдгээр ойн ангиудын зардал нь салбарын орон нутгийн нийт төсвийн зардлын 6.2 хувь буюу 5.9 тэрбум төгрөгийг эзэлж байгаа бөгөөд нэг ойн ангид жилд дунджаар 149 орчим сая төгрөг зарцуулж байна.

Ойн ангиудаас Өмнөговь аймгийн Ойн ангийн төсвийн зардал хамгийн их буюу 1,108.6 сая төгрөг байна. Тус байгууллагын нийт зардлыг бүхэлд нь ойжуулах хөтөлбөрт зарцуулж байгаа бөгөөд 84.6 хувийг үндсэн үйл ажиллагааны зардал, 14.7 хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тус тус зарцуулж байна.

Хүснэгт 18. Нийслэлийн байгаль орчны салбарын байгууллагуудын зарлагын гүйцэтгэл, 2023 он

	БАЙГУУЛЛАГУУД	Батлагдсан /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /сая.төг/	Гүйцэтгэлийн хувь
	НИЙТ ТӨСӨВ	52,528.08	44,569.51	-7,958.57	84.8%
1	Нийслэлийн Байгаль орчны газар	4,521.2	3,914.1	(607.1)	86.6%
2	УБ.Агаар орчны бохирдолтой тэмцэх газар	39,534.6	33,050.5	(6,484.1)	83.6%
3	УБ.Орон сууцны бодлогын газар	910.2	778.5	(131.7)	85.5%
4	УБ.Хотын Хатуу хог хаягдлын БШТөсөл	205.0	127.5	(77.6)	62.2%
5	УБ.Хяналт шалгалтын газар	2,169.6	1,705.9	(463.8)	78.6%
6	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	5,187.4	4,993.1	(194.3)	96.3%

Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж буй байгаль орчны салбарын байгууллагуудын хувьд салбарын орон нутгийн нийт төсвийн зардлын 46.4 хувь буюу 44.6 тэрбум төгрөгийг эзэлж байгаа бөгөөд үүнээс Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газар дангаараа 34.4 хувь буюу 33.0 тэрбум төгрөгийг эзэлж байна.

Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газар нь нийт зардлаа бүхэлд нь агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд зарцуулдаг бөгөөд нийт зардлын 96.5 хувийг агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд, 3.5 хувийг үндсэн үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан байна.

Дээр дурдсан байгууллагуудаас гадна 2023 оны байдлаар аймаг болон сумдын нийт 23 “Байгаль хамгаалах сан” орон нутгийн төсвөөс санхүүжсэн ба салбарын орон нутгийн төсвийн нийт зардлын 8.1 хувь буюу 7.8 тэрбум төгрөгийг эзэлж байна. Байгаль хамгаалах сангууд нь байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх болон хүрээлэн буй орчны бодлого удирдлага хөтөлбөрүүдийн арга хэмжээг санхүүжүүлдэг.

- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн хүрээнд Дорнод аймгийн 10 сумын байгаль хамгаалах сан, Орхон аймгийн байгаль хамгаалах сан, Хэнтий аймгийн 10 сумын байгаль хамгаалах сан нийтдээ 1.8 тэрбум төгрөгийн зарцуулсан байна. Байгаль хамгаалах сангууд дийлэнх зардлаа үндсэн үйл ажиллагаа болон байгаль хамгаалах нөхөн арга хэмжээнд зарцуулсан бол Орхон аймгийн байгаль хамгаалах сан нийт 1.5 тэрбум төгрөгийн зардлаас 1.1 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.
- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хүрээнд Булган аймгийн байгаль хамгаалах сан 5.9 тэрбум төгрөгийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний бараа үйлчилгээний бусад зардалд, Булган аймгийн Баян-Агт сумын байгаль хамгаалах сан 13 сая төгрөгийг мөн адил байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулсан байна.

6.2.2 ЗДТГ-ын хүрээлэн буй орчны хөтөлбөрийн зарлагын шинжилгээ

Байгаль орчны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг төсөвт байгууллагуудаас гадна аймаг болон сумдын нийт 94-н ЗДТГ хүрээлэн буй орчны хөтөлбөрийн арга хэмжээнд


төсөв зарцуулсан бөгөөд энэ нь салбарын орон нутгийн төсвийн нийт зардлын 9.9 хувь буюу 9.5 тэрбум төгрөгийг эзэлж байна.

- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хүрээнд Хөвсгөл аймгийн ЗДТГ, Төв аймгийн ЗДТГ болон тус аймгийн 27 сумын ЗДТГ нийтдээ 2.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Энэхүү зардлыг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний бараа үйлчилгээний бусад зардал, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ арга хэмжээний хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал болон агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнүүдэд тус тус зарцуулсан байна.
- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн хүрээнд Дорноговь болон Дундговь аймгийн ЗДТГ, Хөвсгөл аймгийн 24 сумын ЗДТГ, Ховд аймгийн ЗДТГ болон тус аймгийн 17 сумын ЗДТГ, Увс аймгийн ЗДТГ болон тус аймгийн 17 сумын ЗДТГ, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ЗДТГ нийтдээ 2.9 тэрбум төгрөгийн төсвийг зарцуулжээ. Тус зардлыг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний бараа үйлчилгээний бусад зардал болон агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид тус тус зарцуулсан байна.
- Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд Хэнтий аймгийн ЗДТГ 109 тэрбум төгрөгийг ойжуулах арга хэмжээний бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.
- Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн хүрээнд Дорнод аймгийн ЗДТГ 157 тэрбум төгрөгийг агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний бараа үйлчилгээний бусад зардал, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулсан байна.
- Ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн ЗДТГ 30 тэрбум төгрөг ус цаг уурын судалгаа, шинжилгээ арга хэмжээний бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.
- Хог хаягдал хөтөлбөрийн хүрээнд Дархан аймгийн ЗДТГ 4.2 тэрбум төгрөгийг нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, тордолт, хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ, хотын доторх золбин муур, нохой устгал, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээний бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид зарцуулсан байна. Мөн Дархан аймгийн Хонгор сумын ЗДТГ 141 тэрбум төгрөгийг хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээний төрийн өмчит байгууллагад олгох татаасын зардалд зарцуулсан байна.

6.3 Салбарын хөдөлмөр эрхлэгчдийн дундаж цалин

2015-2023 оны дунджаар байгаль орчны салбарын нийт зардлын 33.7 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал эзэлсэн бөгөөд байгаль орчны салбарын нийт цалин, хөлс болон нэмэгдэл урамшил жилд дунджаар 18.8 хувиар өссөн бол 2023 оны байдлаар 79.5 хувиар өсөж 86.9 тэрбум төгрөгт хүрсэн байна/График 13/. Энэ нь салбарын нийт төсвийн зардлын 42 орчим хувьтай тэнцэнэ.

График 13. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, тб.₮



2015-2023 оны дунджаар байгаль орчны салбарын нэг албан хаагчид ногдох сарын цалин 15.9 хувиар өсөж 912.3 мянган төгрөг байсан бол 2023 оны байдлаар 69.6 хувиар өсөж 1.6 сая төгрөгт хүрсэн байна/График 14/.

График 14. Салбарын ажилчдын тоо ба сарын дундаж цалин, мян.₮



2023 оны байдлаар салбарын улсын төсвийн нийт зардал 29.3 хувиар өсөж 132.5 тэрбум төгрөгт хүрснээс 22.5 хувийн өсөлтийг цалин хөлс, нэмэгдэл урамшлын өсөлт эзэлж байгаа бол орон нутгийн нийт төсвийн зардал 43.9 хувиар өсөж 74.8 тэрбум төгрөгт хүрснээс 31.2 хувийн өсөлтийг цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлын өсөлт эзэлж байна.

Монгол Улсын хувьд хөтөлбөрт суурилсан төсөвлөлтөд 2013 оноос шилжсэн. Төсвийг хөтөлбөрөөр төлөвлөх нь төсвийн зарлагыг зорилго, үр дүнд чиглүүлэн төлөвлөх, зарцуулалтад хяналт тавих зорилготой юм. Монгол Улсын хувьд НҮБ-ын Статистикийн хорооноос гаргасан Засгийн газрын чиг үүргийн ангилал(COFOG)-д үндэслэсэн төсвийн хөтөлбөрийн ангиллыг Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.

Хөтөлбөрийг “Тодорхой хугацаанд, зорилтод өөрчлөлтийг илэрхийлсэн нэг үр дүнг бий болгохоор зорьж буй хэд хэдэн багц арга хэмжээ буюу гарцыг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг. Мөн Дэлхийн Банкнаас 2013 онд гаргасан “Гүйцэтгэлд суурилсан төсвийн ангилал: Нотолгоонд суурилсан төсвийн бүтэц” товхимолд “Үр дүнд суурилсан хөтөлбөр гэж нэг үр дүнд хүрэх зорилготой, эсвэл нэгдмэл зорилтод бүлэгт чиглэсэн төрөл бүрийн гарцуудын багц/төлбөрийн шилжүүлгийг хэлнэ” гэж Марк Робинсон тодорхойлсон байна.

Харин Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг хэлнэ гэж заасан байна.

7.1 Хүрээлэн буй орчны төсвийн зарлагын хөтөлбөрийн ангиллын олон улсын туршлага

Олон улсын түвшинд хүрээлэн буй орчны төсвийн хөтөлбөрийн зарлагын ангиллыг тодорхойлохдоо НҮБ-ийн статистикийн газар, Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас системчилсэн олон улсад стандартчилсан Засгийн газрын чиг үүргийн ангилал болох (COFOG)-ийг өргөн ашигладаг. COFOG ангиллыг НҮБ, ОУВС, Дэлхийн банк, Европын Холбооны болон ЭЗХАХБ-ийн дийлэнх гишүүн орнууд ашигладаг. Энэхүү засгийн газрын чиг үүргийн ангиллын “Environmental protection” ангилалд хүрээлэн буй орчны салбарын төсвийн зарлагын ангиллуудыг тусгадаг. Үүнд:

1. Хог хаягдлын менежмент
2. Хаягдал усны менежмент
3. Бохирдлыг бууруулах
4. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт
5. Хүрээлэн буй орчин хамгаалах судалгаа шинжилгээ
6. Байгаль хамгаалах бусад арга хэмжээ гэсэн хөтөлбөрүүд багтдаг.

1. Хог хаягдлын менежментийн хөтөлбөр

Хөтөлбөрт хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, устгахтай холбоотой зардлуудыг багтаадаг. Хог хаягдлыг цуглуулахдаа гудамж, талбай, зам, зах, олон нийтийн цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт газруудыг цэвэрлэх, ангилан ялгасан болон бусад бүх төрлийн хог хаягдлыг цуглуулж, дахин боловсруулах эсвэл хаягдлын цэгрүү тээвэрлэх зардлууд багтана.

Хог хаягдлыг боловсруулах гэдэг нь хог хаягдлын физик, хими, биологийн шинж

чанар, найрлагыг саармагжуулах, хоргүй болгох, тээвэрлэхэд аюулгүй болгох, нөхөн сэргээх, хадгалах боломжтой болгох эсвэл эзэлхүүнийг нь багасгах зорилготой арга хэмжээ, процессуудыг хэлнэ. Хог хаягдлыг устгах гэдэг нь хог хаягдлыг булаах, хадгалах, далайд хаях болон бусад холбогдох аргуудыг ашиглан дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг эцсийн байдлаар устгах үйл ажиллагааг багтаадаг.

Хөтөлбөрийн зардлууд.

Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, устгах арга хэмжээний удирдлага, хяналт, шалгалт, үйл ажиллагааны зардлууд болон хог хаягдлын арга хэмжээтэй холбоотой бүтээн байгуулалтуудын хөрөнгө оруулалтын зардал, гадаад зээл тусламж, татаасын зардлууд бүгд багтана. Цөмийн хог хаягдал мөн багтана.

2. Хаягдал усны менежментийн хөтөлбөр

Хөтөлбөрт бохир усны системийн үйл ажиллагаа, бохир ус цэвэршүүлэхтэй холбоотой зардлуудыг багтаадаг.

Бохир усны системийн үйл ажиллагаа нь борооны ус, ахуйн болон бусад бохир усыг үүссэн цэгээс бохир ус цэвэрлэх байгууламж эсвэл гадаргын ус руу зайлуулах цэг хүртэл зөөвөрлөх цуглуулагч, хоолой, шугам сүлжээ, насосны системийн менежмент болон барилгын ажлыг багтаадаг.

Бохир ус цэвэршүүлэх нь бохир усыг байгаль орчны стандарт болон бусад чанарын стандартад нийцүүлэн тохируулах механик, биологийн болон дэвшилтэт процессуудыг багтаадаг.

Хөтөлбөрийн зардлууд.

Бохир усны систем болон бохир ус цэвэрлэх байгууламжийн удирдлага, хяналт, шалгалтын үйл ажиллагааны зардлууд болон системийн үйл ажиллагаа, барилга, засвар үйлчилгээ болон сайжруулалтыг дэмжих зорилгоор олгох хөрөнгө оруулалт, татаас, зээл, тусламжийн зардлууд багтана.

3. Бохирдлыг бууруулах хөтөлбөр

Хөтөлбөрт агаар мандал, уур амьсгалын хамгаалалт, хөрс болон газрын доорх усны хамгаалалт, дуу чимээ болон чичиргээний нөлөөллийг бууруулах, цацрагаас хамгаалахтай холбоотой

Бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд хяналтын систем, станц (цаг уурын станцаас бусад) байгуулах, ажиллуулах, дуу чимээ багасгах далан хамгаалалтын хашлага болон бусад байгууламж барих, хотын авто зам, төмөр замын хэсгүүдийг дуу чимээ багасгах гадаргуугаар шинэчлэх, агаарын чанарт сөргөөр нөлөөлдөг хүлэмжийн хий болон бусад бохирдуулагч бодисын ялгаруулалтыг хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бохирдсон хөрсийг цэвэрлэх болон бохирдуулагч бүтээгдэхүүнийг хадгалах байгууламж барих, ажиллуулах, бохирдуулагч бүтээгдэхүүнийг тээвэрлэх ажлууд багтана.

Хөтөлбөрийн зардлууд.

Бохирдлыг бууруулах, хянахтай холбоотой удирдлага, хяналт, шалгалтын үйл ажиллагааны зардлууд болон бохирдлыг бууруулах, хянах үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгох татаас, зээл тусламжийн зардлууд багтана.

4. Биологийн олон янз байдлыг хамгаалах

Хөтөлбөрт амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах (устаж үгүй болсон биологийн төрөл зүйлийг дахин нутагшуулах, нэн ховордсон ан амьтныг сэргээн хамгаалах), амьдрах орчныг хамгаалах (байгалийн цэцэрлэгт хүрээлэн, дархан цаазат газруудын менежмент) болон байгалийн унаган төрхийг хамгаалах үйл ажиллагаа (гэмтсэн газрыг нөхөн сэргээх, орхигдсон уурхай, карьерын талбайг сэргээн засварлах зэрэг)-ны зардлууд багтана.

Хөтөлбөрийн зардлууд.

Биологийн олон янз байдал, байгаль хамгаалахтай холбоотой үйл ажиллагааны удирдлага, хяналт, шалгалт, үйл ажиллагааны зардлууд, биологийн олон янз байдал болон байгалийн унаган төрхийг хамгаалах үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгох татаас, зээл тусламжийн зардлууд багтана.

5. Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ

Хүрээлэн буй орчинтой холбоотой суурь судалгаа, хавсарга судалгаа, туршилтын судалгаа болон бүтээн байгуулалтын судалгаа шинжилгээний зардлуудыг багтаадаг. Хөтөлбөрийн зардлууд.

Байгаль орчин хамгаалалттай холбоотой хавсарга судалгаа, туршилт хөгжүүлэлтэд оролцож буй төрийн байгууллагуудын удирдлага, үйл ажиллагааны зардлууд, судалгааны институт, их сургуулиуд зэрэг төрийн бус байгууллагуудын явуулж буй байгаль хамгаалалттай холбоотой судалгаа, туршилт хөгжүүлэлтийг дэмжих зорилгоор олгох татаас, зээл тусламжийн зардлууд багтана.

6. Хүрээлэн буй орчны ангилагдаагүй бусад зардал

Хөтөлбөрт багтах зардлууд.

Байгаль орчны хамгааллын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсвийг боловсруулж, удирдаж, зохицуулж, хянах, хяналт тавих, үйл ажиллагааны зардлууд, байгаль орчны хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх хууль тогтоомж, стандартуудыг боловсруулах, хэрэгжүүлэх, байгаль орчны хамгааллын талаарх ерөнхий мэдээлэл, техникийн баримт бичиг, статистик үйлдвэрлэх, тараах үйл ажиллагааны зардлуудыг хамардаг. Мөн бусад 5-н хөтөлбөрт ангилагдаагүй байгаль орчин хамгаалах арга хэмжээ, үйлчилгээний зардлууд багтана.

7.2 Төсвийн зарлагын гүйцэтгэл, хөтөлбөрийн ангиллаар

Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ний өдрийн 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад байгаль орчны салбар буюу хүрээлэн буй орчны төсвийн зардлын дараах хөтөлбөрүүдийг баталсан. Үүнд:

Хүснэгт 19. Хүрээлэн буй орчны төсвийн хөтөлбөрийн ангилал

№	714	Хүрээлэн буй орчин	Улсын төсвөөс хэрэгжүүлсэн он	Орон нутгийн төсвөөс хэрэгжүүлсэн он
1	71401	Хог хаягдал	-	2015-2024
2	71402	Биологийн төрөл зүйлийн хамгаалалт	2015	2015-2019
3	71403	Ойжуулалт	2015-2024	2015-2024
4	71404	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	2015-2024	2015
5	71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	2016-2024	2018
6	71406	Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	2015	2015-2024
7	71407	Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт	2015-2024	2015-2024
8	71408	Ус цаг уур, орчны шинжилгээ	2015-2024	2019-2024
9	71409	Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт	-	2016-2019
10	71410	Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх	2015, 2020-2024	-
11	71411	Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	2015-2024	2015-2024
12	71412	Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ	2015, 2017-2024	-
13	71413	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх -		2018-2024

Дээрх хөтөлбөрүүд нь улсын төсөв болон орон нутгийн төсөв дээр ялгаатай байдлаар хэрэгждэг. Өөрөөр хэлбэл улсын төсвөөс 71403 ойжуулалт, 71404 усны нөөц, нуур, гол мөрний менежмент, 71405 тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, 71407 агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, 71408 ус цаг уур орчны шинжилгээ, 71410 газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх, 71411 хүрээлэн буй орчны бодлого удирдлага, 71412 хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ гэсэн хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг.

Харин орон нутгийн төсвөөс 71401 хог хаягдал, 71403 ойжуулалт, 71406 хүрээлэн буй орчны бохирдол доройтол, 71408 ус цаг уур орчны шинжилгээ, 71407 агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, 71411 хүрээлэн буй орчны бодлого удирдлага, 71413 байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх гэсэн хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг.

Өнөөгийн байдлаар хүрээлэн буй орчны төсвийн зарлагын хөтөлбөрүүдээс биологийн төрөл зүйлийн хамгаалалт, нэн ховор, ховордсон амьтан ургамлын хамгаалалт гэсэн хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэггүй байна.

Хүснэгт 20. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл, хөтөлбөрийн ангиллаар, /тб.₮/

Хөтөлбөрийн гүйцэтгэл			2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	/Дүнд эзлэх хувь/
№	71400	Хүрээлэн буй орчин	58.3	68.6	73.4	92.4	161.2	180.8	205.9	172.7	228.3	100.0%
1	71401	Хог хаягдал	5.5	6.9	8.0	-	0.6	0.8	1.1	4.7	6.5	2.7%
2	71402	Биологийн төрөл зүйлийн хамгаалалт	1.0	0.8	1.5	1.0	0.0	-	-	-	-	0.3%
3	71403	Ойжуулалт	6.2	4.1	10.0	11.8	8.1	6.2	5.4	5.4	21.0	6.3%
4	71404	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	2.5	2.5	2.7	3.0	3.3	4.5	5.0	6.1	8.8	3.1%
5	71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	-	6.3	6.4	6.5	7.3	10.4	10.8	10.6	19.7	6.3%
6	71406	Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	2.1	1.1	1.3	1.7	0.2	0.4	0.5	0.3	0.2	0.6%
7	71407	Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт	5.8	4.8	5.2	11.9	75.2	75.8	101.6	56.0	48.5	31.0%
8	71408	Ус цаг уур, орчны шинжилгээ	21.3	20.7	21.9	22.4	24.9	33.2	37.7	32.2	49.0	21.2%
9	71409	Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт	-	0.3	0.3	0.3	0.3	-	-	-	-	0.1%
10	71410	Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх	0.0	-	-	-	-	0.5	0.9	0.8	0.8	0.2%
11	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	13.8	21.2	15.6	30.8	34.4	37.7	31.9	43.0	52.9	22.7%
12	71412	Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ	0.0	-	0.7	1.1	0.5	0.1	0.0	-	0.0	0.2%
13	71413	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	-	-	-	1.9	6.5	11.3	11.0	13.5	21.0	5.3%

Монгол улсын байгаль орчны салбарт 2015-2023 оны хугацаанд улсын төсвөөс жилд дунджаар 138 орчим тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд нийт зардлын дийлэнх буюу 31.0 хувийг агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, 22.7 хувийг хүрээлэн буй орчны бодлого удирдлага, 21.2 хувийг ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрт тус тус зарцуулсан бөгөөд энэхүү 3 хөтөлбөр нь нийт зардлын 75 орчим хувийг эзэлж байна. Үүнээс гадна байгаль орчны салбарт тулгамдаж буй зарим салбарын хөтөлбөр болох хог хаягдлын хөтөлбөрт 2.7 хувь /3.8 тб.₮/, хүрээлэн буй орчны бохирдол доройтол хөтөлбөрт 0.1 хувь /0.9 тб.₮/, газрын доройтлыг бууруулах,


цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрт 0.3 хувь /0.3 тб.₮/-ийг тус тус зарцуулж байна.

• “ХОГ ХАЯГДЛЫН ХӨТӨЛБӨР”

“Хог хаягдлын тухай хууль”-ийн 41.8-д хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ гэж заасны дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг. “Хог хаягдлын тухай хууль”-ийн 41.9-д хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хог хаягдлыг булшлах, хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлсэн тохиолдолд үйлчилгээний шимтгэл төлөх гэсэн үйл ажиллагаануудыг санхүүжүүлнэ гэж заасан байдаг.

Орон нутгийн төсөвт 2015-2023 оны хугацаанд жилд дунджаар “хог хаягдлын үйлчилгээний төлбөр”-ийн 20 орчим тэрбум төгрөг төвлөрсөн ба хүрээлэн буй орчны хог хаягдал хөтөлбөрийн хүрээнд жилд дунджаар 3.8 тэрбум төгрөгийг зарцуулсан ба зардлыг үндсэн үйл ажиллагааны зардал, нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ, нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, байгууламжийн арчилгаа, тордолт, хотын дотор золбин муур, нохой устгалын арга хэмжээнүүдэд зарцуулсан байна.

График 15. Хог хаягдлын үйлчилгээний хураамж, тб.₮



2023 оны байдлаар орон нутгийн төсөвт хог хаягдлын үйлчилгээний хураамж 28.6 тэрбум төгрөг төвлөрсөн бол хог хаягдал хөтөлбөрийн хүрээнд 6.5 тэрбум төгрөг буюу нийт хог хаягдлын хураамжийн 22.8 хувийг зарцуулсан байна.

2023 оны хог хаягдлын хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ, орон нутгийн өмчит үйлвэрийн газар нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээний арга хэмжээнүүдэд 2.1 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Дархан аймгийн ЗДТГ-аас “нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, тордолт, хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ хотын доторх золбин муур, нохой устгал, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээний арга хэмжээнд 4.2 тэрбум төгрөг, Дархан аймгийн Хонгор сум “хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ”-ний арга

хэмжээнд 141 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. Үүнээс гадна Улаанбаатар хотын “Хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл”-ийн үндсэн үйл ажиллагааны зардалд 127 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дээр дурдсан хог хаягдлын хөтөлбөрийн зарцуулалт нь улсын хэмжээн дэх нийт хог хаягдлын салбарт зарцуулж буй төсвийн зардлыг бүрэн хамардаггүй бөгөөд ердөө 2.5 орчим хувийг энэхүү хөтөлбөрт бүртгэж байна. Өөрөөр хэлбэл 2023 оны байдлаар хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээнд улсын хэмжээнд нийтдээ 71.2 тэрбум төгрөгийг зарцуулсан ба үүний 63.9 хувь нь хот байгуулалт, тохижилтын хөтөлбөрт, 4.8 хувь нь орон нутгийн гүйцэтгэх удирдлагын хөтөлбөрт бүртгэгдсэн байна. Энэхүү хог хаягдлын хөтөлбөрөөс бусад хөтөлбөрт бүртгэгдэж буй хог хаягдлын зардлууд нь хог хаягдлын салбар болон хөтөлбөрийн зардлыг оновчтой бүртгэх, хөтөлбөрийн үр өгөөжийг тооцоход хүндрэл учруулж байгаа бөгөөд улсын хэмжээнд хог хаягдлын салбарын нийт зардлыг зөвхөн хог хаягдлын хөтөлбөрт оновчтой бүртгэх шаардлагатай байна. Үүнээс гадна ТЕЗ-ийн батлуулж буй хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтэд хог хаягдлын хөтөлбөрийг салбарын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогуудтай уялдуулан батлуулж төсвийн зарцуулалтын үр дүнг хэмждэг болох шаардлагатай байна.

Хүснэгт 21. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн өсөлт, хөтөлбөрийн ангиллаар

Хөтөлбөрийн гүйцэтгэл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	/Дунд аж өсөлт/
№ 71400 Хүрээлэн буй орчин	17.7%	6.9%	25.9%	74.4%	12.2%	13.9%	-16.1%	32.2%	20.9%
1 71401 Хог хаягдал	25.5%	15.5%	-100.0%		42.1%	33.3%	335.1%	38.4%	55.7%
2 71402 Биологийн төрөл зүйлийн хамгаалалт	-20.2%	96.0%	-36.4%	-	98.1%	-100.0%			-31.7%
3 71403 Ойжуулалт	-34.4%	144.7%	18.8%	-	31.8%	-23.4%	-12.9%	0.4%	288.2%
4 71404 Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	1.7%	5.8%	14.4%	10.0%	33.2%	12.3%	22.6%	42.9%	17.9%
5 71405 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт		1.5%	1.3%	12.3%	42.7%	3.9%	-1.8%	85.4%	20.8%
6 71406 Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	-50.5%	20.2%	37.3%	-	89.2%	129.5%	15.6%	-38.9%	-46.0%
7 71407 Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт	-17.9%	8.1%	129.9%	531.0%	0.8%	34.1%	-44.8%	-13.4%	78.5%
8 71408 Ус цаг уур, орчны шинжилгээ	-2.8%	5.5%	2.2%	11.4%	33.3%	13.7%	-14.7%	52.1%	12.6%
9 71409 Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт		-4.4%	0.3%	-2.9%	-100.0%				-26.7%

10	71410	Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх	-100.0%				79.8%	-4.3%	-4.4%	-7.2%	
11	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	53.5%	-26.6%	97.7%	11.8%	9.5%	-15.3%	34.8%	23.1%	23.6%
12	71412	Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ	-		56.5%	-	57.7%	-69.8%	-99.1%	-	-61.7%
13	71413	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх				241.3%	73.1%	-2.6%	23.0%	55.8%	78.1%

2022 онд хүрээлэн буй орчны зардал 16.1 хувиар буурсан нь дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахлын үеийн хөл хорионы нөхцөл байдалтай холбоотой. Үүнээс гадна тус онд “ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ” хуулийг баталж төсөвт байгууллагуудын зарим зардал бууруулсан нь нөлөөлсөн байна.

Хүрээлэн буй орчны хөтөлбөрүүдээс 2015-2023 оны хугацаанд агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн зардал жилд дунджаар 78.5 хувь, хог хаягдал хөтөлбөрийн зардал 55.7 хувь, ойжуулалт хөтөлбөрийн зардал 43.7 хувиар тус тус хамгийн өндрөөр өссөн байна.

• “АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ ХӨТӨЛБӨР”

2017 оны ЗГ-ын 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг баталсантай холбоотойгоор 2018 онд тус хөтөлбөрийн зардал 2 дахин өсөж 11.9 тэрбум төгрөгт, 2019 онд 6 дахин өсөж 2019-2021 оны хугацаанд дунджаар 84.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Гэсэн хэдий хөтөлбөрийн хэрэгжилт удааширч байгаатай холбоотойгоор сүүлийн 2 жилийн хугацаанд тус хөтөлбөрийн зардал 30 орчим хувиар буурсан байна.

• “ОЙЖУУЛАЛТ ХӨТӨЛБӨР”

2015 онд УИХ-ын 19 дүгээр тогтоолоор “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” батлагдаж, 2017 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/98 дугаар тушаалаар “Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дунд хугацааны төлөвлөгөө”-г баталсантай холбоотойгоор тус хөтөлбөрийн зардал 2017 онд 2 дахин өсөж 2017-2019 оны хугацаанд дунджаар 10 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн 2021 оны ЗГ-ын 350 дугаар тогтоолоор “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг баталж, хурдацтай хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 онд тус хөтөлбөрийн зардал 4 дахин өсөж 20 орчим тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 22. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн хувь, хөтөлбөрийн ангиллаар

Хөтөлбөрийн гүйцэтгэл			2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	/Дүнд эзлэх хувь, дунджаар/
№	71400	Хүрээлэн буй орчин	94.4 %	92.5%	95.6 %	90.4 %	96.3 %	87.5 %	103%	84.0 %	86.6 %	92.3%
1	71401	Хог хаягдал	93.4%	89.2%	100%		89.1%	95.2%	97.5%	94.5 %	98.5 %	94.7%
2	71402	Биологийн төрөл зүйлийн хамгаалалт	75.0%	86.2%	85.1%	85.0 %	100%					86.2%
3	71403	Ойжуулалт	79.8%	97.4%	95.2%	98.4 %	96.4%	94.7%	91.6%	67.8 %	92.3%	90.4%
4	71404	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	99.7%	93.6%	90.7%	97.7 %	95.2%	90.7%	93.9%	93.5 %	93.6%	94.3%
5	71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт		87.9%	98.1%	98.6 %	97.9%	90.0%	95.4%	94.2 %	86.3 %	93.6%
6	71406	Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	133%	84.9%	98.5%	91.6%	77.6%	82.4%	86.9%	77.1%	80.7 %	90.1%
7	71407	Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт	99.3%	88.4%	89.2%	65.3 %	83.0%	68.4%	95.3%	70.9 %	72.2%	81.3%
8	71408	Ус цаг уур, орчны шинжилгээ	100%	98.8%	99.1%	99.7 %	99.8%	99.4%	120%	99.2 %	98.5 %	102%
9	71409	Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт		95.9%	92.7%	95.3 %	80.2%					91.0%
10	71410	Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх	100%					86.5%	85.0%	91.1%	89.2 %	90.3%
11	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	89.5%	89.9%	93.3%	93.2 %	145%	150%	136%	95.0 %	91.6%	109%
12	71412	Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ	100%		73.9%	78.1%	95.7%	95.2%	7.1%		100%	78.6%
13	71413	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх				93.9 %	92.7%	91.0%	88.6%	80.6 %	79.3%	87.7%

Хүрээлэн буй орчны хөтөлбөрүүдийн төсвийн зарцуулалт 2015-2023 оны дунджаар 92.3 хувийн гүйцэтгэлтэй байсан бол 2020 онд 87.5 хувь, 2022 онд 84.0 хувь, 2023 онд 86.6 хувь буюу дунджаас доогуур гүйцэтгэлтэй байна. Энэ нь хүрээлэн буй орчны бохирдол, доройтол, агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт,

байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зэрэг хөтөлбөрүүдийн төсвийн зардлын гүйцэтгэл сүүлийн жилүүдэд хангалтгүй байсантай холбоотой бөгөөд цаашид дээрх хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийг сайжруулах шаардлагатай байна.

• **Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн хүрээнд** 2023 оны байдлаар орон нутгийн төсвөөс нийт 205.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 80.7 хувийн гүйцэтгэлтэйгээр 165.9 сая төгрөгийг зарцуулсан. Үүнд Дорнод аймгийн ЗДТГ-т байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулахаар 196.8 сая төгрөгийг баталснаас агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний 6 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй болон байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд 82.4 хувийн гүйцэтгэлтэйгээр 157 сая төгрөгийг зарцуулсан нь сөргөөр нөлөөлсөн байна.

• **Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн хүрээнд** 2023 оны байдлаар орон нутгийн төсвөөс нийт 41.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 72.2 хувийн гүйцэтгэлтэйгээр 33.8 тэрбум төгрөгийг зарцуулсан. Үүнд Ховд аймгийн ЗДТГ-т агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулахаар баталсан 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоогүй болон Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газрын агаарын бохирдолтой тэмцэх арга хэмжээний зардлын гүйцэтгэл 83.6 хувь, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын үндсэн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 84.7 хувийн гүйцэтгэлтэй байсан нь хөтөлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн байна.

Мөн тус хөтөлбөрийн хүрээнд 2023 оны байдлаар улсын төсвөөс БОАЖЯ-нд нийт 25.7 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 57.1 хувийн гүйцэтгэлтэйгээр 14.7 тэрбум төгрөгийг зарцуулсан. Үүнд агаарын бохирдлын бууруулах арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын гүйцэтгэл 61.7 хувь, бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэл 36.9 хувьтай байсан нь хөтөлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн байна.

Харин 2015-2023 оны дунджаар хүрээлэн буй орчны хөтөлбөрүүдээс ойжуулалт, усны нөөц, нуур, гол мөрний менежмент, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, ус цаг уур, орчны шинжилгээ, хүрээлэн буй орчны бодлого удирдлага гэсэн хөтөлбөрүүдийн төсвийн зардлын гүйцэтгэл 90 хувиас дээш байна.

Байгаль орчны салбарт 2024 оны байдлаар нэгдсэн төсвийн хүрээнд нийт 395.7 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд үүнээс **61.6 хувь буюу 243.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, үлдсэн 38.4 хувь буюу 151.9 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс** санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

- Улсын төсвийн батлагдсан зарлага өмнөх оноос 62.6 хувиар, орон нутгийн төсвийн зарлага өмнөх оноос 67.2 хувиар тус тус өссөнөөр салбарын нэгдсэн төсвийн зарлага өмнөх оноос 64.3 хувиар **өсөж 395.7 тэрбум төгрөгт** хүрсэн байна.

- **Улсын төсвийн зарлагын** 26.9 хувийг /65.6 тэрбум төгрөг/ 71408 ус цаг уур, орчны шинжилгээ, 19.1 хувийг /46.6 тэрбум төгрөг/ 71403 ойжуулалт, 15.2 хувийг /36.9 тэрбум төгрөг/, 71411 хүрээлэн буй орчны бодлого, удирдлага, 12.4 хувийг /30.3 тэрбум төгрөг/, 71405 тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, 10.8 хувийг /26.2 тэрбум төгрөг/ 71407 агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тус тус зарцуулахаар баталсан байна.

- **Орон нутгийн төсвийн** 36.5 хувийг /55.4 тэрбум төгрөг/ 71407 агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт, 29.8 хувийг /45.2 тэрбум төгрөг/ 71413 байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, 19.8 хувийг /30.0 тэрбум төгрөг/ 71411 хүрээлэн буй орчны бодлого, удирдлага, 6.5 хувийг /9.8 тэрбум төгрөг/ 71403 ойжуулалтын хөтөлбөрт тус тус зарцуулахаар баталсан байна.

Төсвийн зардлын дийлэнх хувийг эзэлж буй доорх хөтөлбөрүүдийн хүрээнд:

1. 71408 УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Улсын төсвөөс:

- Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (22),
- Байгаль орчны шинжилгээний төв лаборатори,
- Цаг уур, орчны шинжилгээний газар,
- Нислэгийн цаг уурын төв,
- Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн гэсэн байгууллагуудад төсөв хуваарилагдсан.

Батлагдсан төсвийн 81.5 хувь буюу 53.5 тэрбум төгрөгийг ус, цаг уур, орчны шинжилгээний төв, 9.3 хувь буюу 6.1 тэрбум төгрөгийг цаг уур, орчны шинжилгээний газар бүрдүүлж байна. Батлагдсан төсвийн **94.3 хувь буюу 61.8 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардал⁹** эзэлж

⁹Үндсэн үйл ажиллагааны зардалд цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал гэсэн зардлууд багтдаг.

байгаа бөгөөд дийлэнх байгууллагуудын зардлын **95-аас дээш хувийг үндсэн үйл ажиллагааны зардал** эзэлж байна. Харин цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн **29.9 хувь буюу 1.8 тэрбум төгрөгийг ус цаг уурын судалгаа шинжилгээнд** зарцуулахаар хуваарилсан байна. Орон нутгийн төсвийн хувьд зөвхөн Сэлэнгэ аймаг ус цаг уурын судалгаа, шинжилгээнд 30 сая төгрөгийг зарцуулахаар батлуулсан байна.

2. 71403 ОЙЖУУЛАЛТ

Улсын төсвөөс:

• Ойн газар санхүүждэг бөгөөд батлагдсан төсвийн 96.9 хувь буюу 45.1 тэрбум төгрөгийг ойжуулалтын зардал, 3.1 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулахаар баталсан байна.

Орон нутгийн төсвөөс:

• Сумдын болон сум дундын нийт 43 ойн анги болон 1 засаг даргын тамгын газарт төсөв хуваарилагдсан байна. Батлагдсан төсвийн **89.3 хувь буюу 8.8 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардал**, 7.3 хувь буюу 716.4 сая төгрөгийг ойжуулалт, 1.9 хувь буюу 181.9 сая төгрөгийг байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх зардалд тус тус зарцуулахаар хуваарилсан байна.

• Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээс ойжуулалтын зардал болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлуудыг ангилан харах боломжтой байна.

3. 71411 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ БОДЛОГО, УДИРДЛАГА

Улсын төсвөөс:

• Байгаль орчин, уур амьсгалын сан,
• Байгаль орчин, аялал жуулчлалын яам гэсэн байгууллагуудын төсөв хуваарилагддаг. Үүнээс гадна байгаль орчны салбарын нийт хөрөнгө оруулалтын зардал хуваарилагддаг.

Батлагдсан нийт төсвийн **61.4 хувь** буюу 36.9 тэрбум төгрөгийг байгаль орчны салбарын **хөрөнгө оруулалтын зардал**, **37.5 хувь** буюу 22.4 тэрбум төгрөгийг **БОАЖЯ** эзэлж байна.

БОАЖЯ-ны зардлын 79.7 хувь буюу 17.9 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардал, 9.7 хувь буюу 2.2 тэрбум төгрөгийг ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, 6.5 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийг Монгол улсыг гадаадад сурталчлах зардалд тус тус зарцуулахаар хуваарилсан байна.

Орон нутгийн төсвөөс:

• Байгаль орчны чиглэлээр бодлого хэрэгжүүлэгч аймаг, сум, нийслэлийн **нийт 60 байгууллагад төсөв хуваарилагдсан** байна.

Батлагдсан төсвийн 82.9 хувь буюу 24.8 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардал, 8.0 хувь буюу 2.4 тэрбум төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал, 1.7 хувь буюу 519 сая төгрөгийг хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээний зардалд тус тус зарцуулахаар хуваарилсан байна.

4. 71405 ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ХАМГААЛАЛТ

Улсын төсвөөс:

- 10 дархан цаазат газар
- 7 улсын тусгай хамгаалалттай газар
- 17 байгалийн цогцолборт газар
- БОАЖЯ гэсэн 35 байгууллагад төсөв хуваарилагдсан.

Батлагдсан төсвийн 95.2 хувь буюу 28.8 тэрбум үндсэн үйл ажиллагааны зардал, 1.5 хувь буюу 468 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, 1.3 хувь буюу 381 тэрбум төгрөгийг ургамал хамгаалах зардал тус тус зарцуулахаар хуваарилсан байна.

Орон нутгийн төсвийн хувьд зөвхөн Дорнод аймаг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зориулалтын зардалд 570 сая төгрөгийг зарцуулахаар батлуулсан байна.

5. 71407 АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Улсын төсвөөс:

- Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд БОАЖЯ 26.2 төгрөгийг батлуулсан.

Орон нутгийн төсвөөс:

- Ховд аймаг, Нийслэлийн гэр хорооллын хөгжлийн газар, Нийслэлийн агаарын чанарын алба, Нийслэлийн цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөлд төсөв хуваарилагдсан.
- Батлагдсан төсвийн 93.0 хувь буюу 51.5 тэрбум төгрөгийг Нийслэлийн агаарын чанарын алба, 4.7 хувь буюу 2.6 тэрбум төгрөгийг Ховд аймаг эзэлдэг бөгөөд зардлын 98 орчим хувийг агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулахаар баталсан байна.
- Харин Нийслэлийн гэр хорооллын хөгжлийн газар, Нийслэлийн цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл нь батлагдсан төсвийн 2.3 хувь буюу 1.3 тэрбум төгрөгийг эзэлж байгаа бөгөөд 97 хувийг үндсэн үйл ажиллагаанд зарцуулахаар хуваарилсан ба дээрх 2 байгууллагад агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний зардал байхгүй байна.

6. 71413 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

Зөвхөн орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг.

- Аймгуудын байгаль хамгаалах сан, нөхөн сэргээлтийн сан, сумдын засаг даргын тамгын газрууд, УБ-ын Байгаль орчин ногоон

хөгжлийн газар, УБ-ын Үндэсний цэцэрлэгт хүрээлэн зэрэг нийт 135 байгууллагад төсөв хуваарилагдсан.

· Батлагдсан төсвийн 61.0 хувь буюу 27.6 тэрбум төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх, 22.5 хувь буюу 10.2 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулахаар хуваарилсан байна.

Анхаарал хандуулах:

Байгаль орчны салбарын төсөвт байгууллагуудын зардлын дийлэнх хувийг үндсэн үйл ажиллагааны зардал бүрдүүлж байна. Мөн зарим хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны чиглэлийн хувьд ялгаатай болон хэрэгжүүлж буй арга хэмжээний хувьд тухайн хөтөлбөрт хамаарал багатай зориулалтуудын төсөв батлагдсан байна.

7.3 Төсвийн зарлагын гүйцэтгэл, зориулалтын ангиллаар

Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ний өдрийн 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад байгаль орчны салбар буюу хүрээлэн буй орчны төсвийн зардлын дараах зориулалтуудыг баталсан. Үүнд:


Хүснэгт 23. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зориулалтын ангилал

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зориулалтууд	Улсын төсвөөс санхүүжүүлсэн он	Орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн он
1	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	2015-2024	2015-2024
2	81702 Түймрийн хохирлыг арилгах	-	-
3	81703 Ургамал хамгаалал	2015-2024	-
4	81704 Ногоон хэрэм хөтөлбөр	-	-
5	81705 Ойн тооллого	-	-
6	81706 Химийн хорт бодисыг хоргуйжүүлэх арга хэмжээ	-	-
7	81707 Агаарын бохирдлыг бууруулах	2015-2024	2019-2024
8	81708 Ойжуулалт	2015-2024	2015-2024
9	81709 Ойн хортонтой тэмцэх	-	-
10	81710 Ус цаг уурын судалгаа, шинжилгээ	2015-2024	2019-2024
11	81711 Ногоон байгууламж, цөлжилтийн эсрэг арга хэмжээ түүний цогц мастер төлөвлөгөө болосвруулах /2021 онд нэмсэн/	-	-
12	81712 Мазаалай хамгаалах	2024	-

Дээрх зориулалтууд нь улсын төсөв болон орон нутгийн төсөв дээр ялгаатай байдлаар хэрэгждэг бөгөөд зориулалт тус бүр жил болгон тогтмол хэрэгждэггүй. Өөрөөр хэлбэл улсын төсвөөс 81701 байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, 81703 ургамал хамгаалал, 81707 агаарын бохирдлыг бууруулах, 81708 ойжуулалт, 81710 ус цаг уурын судалгаа, шинжилгээ гэсэн зориулалтуудыг санхүүжүүлдэг. Харин орон нутгийн төсвөөс 81701 байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, 81707 Агаарын бохирдлыг бууруулах, 81708 ойжуулалт, 81710 ус цаг уурын судалгаа шинжилгээ гэсэн зориулалтуудыг тус тус санхүүжүүлдэг байна.


Өнөөгийн байдлаар байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээнүүдийн ангиллуудаас 81704 түймрийн хохирлыг арилгах, 81704 ногоон хэрэм хөтөлбөр, 81706 химийн хорт бодисыг хоргүйжүүлэх арга хэмжээ, 81709 ойн хортонтой тэмцэх, 81711 ногоон байгууламж, цөлжилтийн эсрэг арга хэмжээ түүний цогц мастер төлөвлөгөө боловсруулах гэсэн зориулалтын ангиллуудыг ашигладаггүй байна.

График 16. Салбарын төсвийн зарлага, зориулалтын ангиллаар, /тб.₮/



2015-2023 оны дунджаар байгаль орчны салбарт зарцуулсан нэгдсэн төсвийн зардлын 42.3 хувь буюу 58.3 тэрбум төгрөгийг байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээнүүдэд зарцуулсан байна. Байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээнүүдийн зардал жилд дунджаар 26.4 хувийн өсөлттэй байсан бол 2023 онд 3.3 хувиар өсөж 83.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

График 17. Салбарын төсвийн зарлагад эзэлж буй байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зориулалтуудын дундаж хувь



2023 оны байдлаар байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээнүүдэд зарцуулсан зардлын 55.6 хувь буюу 46.2 тэрбум төгрөгийг агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд, 26.1 хувь буюу 21.7 тэрбум төгрөгийг байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд, 15.9 хувь буюу 13.3 тэрбум төгрөгийг ойжуулах арга хэмжээнд, 2.0 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийг ус цаг уурын судалгаа, шинжилгээний арга хэмжээнд, 0.4 хувь буюу 0.3 тэрбум төгрөгийг ургамал хамгааллын арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээнүүдээс гадна салбарын

нэгдсэн төсвийн зардлын 41.1 хувь буюу дунджаар 56.7 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааны арга хэмжээнд зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагааны зардал жилд дунджаар 19.4 хувийн өсөлттэй байсан бол 2023 онд 72.5 хувиар өсөж 113.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Салбарын нэгдсэн төсвийн зардлын үлдсэн 16.6 хувь буюу 23.0 тэрбум төгрөгийг төсвийн зориулалтын бусад ангиллуудад¹⁰ зарцуулсан байна.

ШИГТГЭЭ 1.

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БАТЛАГДСАН ТӨСӨВ, (ЗОРИУЛАЛТЫН АНГИЛЛААР)

Байгаль орчны салбарт 2024 оны байдлаар нэгдсэн төсвийн хүрээнд нийт 395.7 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд үүнээс **61.6 хувь буюу 243.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, үлдсэн 38.4 хувь буюу 151.9 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс** санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

• **Улсын төсвийн зарлагын** 49.4 хувийг /120.3 тэрбум төгрөг/ 801010 үндсэн үйл ажиллагааны зардалд, 18.5 хувийг /45.1 тэрбум төгрөг/ 817080 ойжуулалт, 10.8 хувийг /36.9 тэрбум төгрөг/, 71411 хүрээлэн буй орчны бодлого, удирдлага, 12.4 хувийг /30.3 тэрбум төгрөг/, 71405 тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, 10.8 хувийг /26.2 тэрбум төгрөг/ 817070 агаарын бохирдлыг бууруулах, 15.2 хувь буюу 36.9 тэрбум төгрөг нь 809180 бусад гэсэн арга хэмжээнүүдэд зарцуулахаар баталсан байна.

• **Орон нутгийн төсвийн** 35.6 хувийг /54.2 тэрбум төгрөг/ 817070 агаарын бохирдлыг бууруулах, 31.0 хувийг /47.2 тэрбум төгрөг/ 801010 үндсэн үйл ажиллагааны зардал, 20.4 хувийг /31.0 тэрбум төгрөг/ 817010 Байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх, 3.9 хувийг /6.0 тэрбум төгрөг/ 809180 бусад¹¹ гэсэн арга хэмжээнүүдэд зарцуулахаар баталсан байна.

Анхаарал хандуулах: Байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зардлын ердөө 40.9 хувь буюу 161.7 тэрбум төгрөгийг байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээнүүдэд зарцуулж байна.

Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсөвт байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдээс гадна нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, тордолт, хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ, хотын доторх золбин муур, нохой устгал, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ¹² гэх мэт хот суурин нийтийн үйлчилгээ арга хэмжээнүүд хэрэгжиж байна.

¹⁰Орон нутгийн төсөв: Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ, Төрийн өмчийн барилгын тогтмол зардал, Нийтлэг үйлчилгээ, Мэдээлэл, сурталчилгааны зардал, Харуул, хамгаалалтын зардал, Сургалт семинар, Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт, Нөхөн олговор, Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, Эрсдэлийн сангийн нөөц хөрөнгө, Өвс, тэжээлийн нөөц, Ахмадын сан, Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, Нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, тордолт, Хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ, Хотын доторх золбин муур, нохой устгал, Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ арга хэмжээний зардлууд багтдаг. Улсын төсөв: Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, Харуул, хамгаалалтын зардал, Холбооны суваг ашигласны хөлс, Гэрээт ажиллагсдын зардал, Байр ашиглалтын үйлчилгээ, Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хурдамж, Өндөр настан, ахмад дайчдад олгох хөнгөлөлт, Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж, Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, Монгол улсыг гадаадад сурталчилах арга хэмжээний зардлууд багтдаг.

¹¹Хөрөнгө оруулалтын зардал, төрийн өмчийн барилгын тогтмол зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгааны ажил гэх мэтчилэн багтана.


¹²Эдгээр арга хэмжээнүүд нь хог хаягдлын хөтөлбөрийн хүрээнд хэрэгждэг.

8.

САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААРХ ГҮЙЦЭТГЭЛ

2015-2023 оны дунджаар байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн нийт зардлын 86.1 хувь буюу 118.7 тэрбум төгрөгийг урсгал зардал, 10.4 хувь буюу 14.4 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал эзэлж байна.

График 18. Салбарын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл, эдийн засгийн ангиллаар, /тб.₮/



Салбарын урсгал зардал 2015 онд 51.9 тэрбум төгрөг байснаас 4.0 дахин өсөж 2023 онд 209.3 тэрбум төгрөгт хүрсэн ба жилийн дундаж өсөлт 21.2 хувьтай байна. Хөрөнгийн зардал 2015 онд 6.4 тэрбум төгрөг байснаас 3 дахин өсөж 19.1 тэрбум төгрөгт хүрсэн ба жилийн дундаж өсөлт 19.4 хувьтай байна.

Хүснэгт 24. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл, эдийн засгийн ангиллаар, /тб.₮/

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Дүнд эзлэх хувь
2 Нийт зардал ба цэвэр эзэл	58.3	68.6	73.4	92.4	161.2	180.8	205.9	172.7	228.3	100.0%
21 Урсгал зардал	51.9	61.3	63.8	72.0	99.6	164.7	189.0	157.1	209.3	91.7%
210 Бараа, үйлчилгээний зардал	48.7	59.8	61.7	63.1	88.3	145.0	170.9	153.6	205.5	90.0%
2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	25.2	30.3	29.7	32.9	38.3	47.0	47.7	51.4	86.9	38.1%
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2.8	3.3	3.3	3.9	4.8	6.1	6.3	6.5	10.9	4.8%
2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1.1	1.6	1.7	1.7	1.8	2.1	2.1	2.1	3.0	1.3%
2104 Хангамж, бараа материалын зардал	5.0	7.0	8.1	1.3	2.7	11.9	19.4	19.5	21.4	9.4%
2105 Норматив зардал	0.0	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.4	0.2%
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	1.6	2.5	2.7	2.6	2.7	3.5	3.5	2.8	5.4	2.4%
2107 Томилолт, зочны зардал	0.3	0.3	0.4	0.4	0.5	0.3	0.3	0.2	0.9	0.4%
2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6.4	11.5	12.3	13.0	20.0	53.2	60.5	49.5	52.6	23.0%
2109 Бараа үйлчилгээний бусад зардал	6.3	2.9	3.3	6.9	17.3	20.4	30.8	21.3	24.1	10.5%
212 Татаас	2.1	0.1	0.0	8.3	10.1	15.9	15.9	-	0.1	0.1%

2121 Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-	-	-	0.1	0.1	-	-	0.1		0.1%
2122 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2.1	0.1	0.0	8.3	10.0	15.9	15.9	-	-		0.0%
213 Урсгал шилжүүлэг	1.1	1.4	2.2	0.7	1.2	3.8	2.3	3.5	3.6		1.6%
2131 Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.1	0.6	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.8	0.1		0.0%
2132 Бусад урсгал шилжүүлэг	0.9	0.8	2.0	0.5	1.0	3.6	2.1	2.6	3.5		1.5%
22 Хөрөнгийн зардал	6.4	7.4	9.6	20.4	17.8	16.1	16.9	15.6	19.1		8.3%
2200 Барилга байгууламж	1.6	1.0	0.7	9.6	12.0	14.7	15.7	13.4	14.5		6.3%
2210 Их засвар	-	-	-	-	0.0	-	1.1	0.8	2.5		1.1%
2220 Тоног төхөөрөмж	-	-	-	0.5	-	-	-	1.4	2.0		0.9%
2230 Бусад хөрөнгө	4.8	6.4	8.9	10.3	5.7	1.5	0.0	0.1	0.1		0.0%
23 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл					43.8						0.0%

2015-2023 оны дунджаар урсгал зардлын ангиллуудаас нийт зардлын дийлэнхийг 31.4 орчим хувь буюу 43.3 тэрбум төгрөгийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, 22.5 хувь буюу 31.0 тэрбум төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 10.7 хувь буюу 14.8 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал, 7.7 хувь буюу 10.7 тэрбум төгрөгийг хангамж бараа материалын зардал тус тус эзэлж байна.

2015-2023 оны дунджаар хөрөнгийн зардлын ангиллуудаас нийт зардлын 6.7 хувь буюу 9.2 тэрбум төгрөгийг барилга байгууламжийн зардал эзэлж байна.

Хүснэгт 25. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн хувь, эдийн засгийн ангиллаар

	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Дундаж гүйцэтгэл
2 Нийт зардал ба цэвэр зээл	90.3%	92.5%	95.6%	90.4%	96.3%	87.5%	103.3%	84.0%	86.6%	91.8%
21 Урсгал зардал	98.3%	93.3%	95.8%	88.4%	88.5%	80.2%	94.9%	82.7%	86.6%	89.9%
210 Бараа, үйлчилгээний зардал	98.5%	94.7%	96.1%	87.0%	87.3%	78.2%	94.8%	82.4%	86.6%	89.5%
2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	99.5%	98.8%	98.2%	98.5%	97.8%	96.7%	96.6%	96.6%	94.4%	97.5%
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99.5%	99.1%	99.2%	98.6%	97.6%	93.5%	94.1%	95.4%	93.7%	96.8%
2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90.6%	94.1%	95.4%	93.3%	94.5%	95.1%	94.7%	94.0%	86.3%	93.1%
2104 Хангамж, бараа материалын зардал	90.2%	89.1%	99.2%	96.3%	38.0%	52.3%	87.4%	87.7%	83.6%	80.4%
2105 Нормативт зардал	72.2%	98.1%	99.3%	94.9%	98.2%	97.9%	94.2%	92.7%	87.2%	92.7%
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	81.2%	98.4%	96.0%	98.0%	94.5%	95.0%	98.4%	96.6%	97.7%	95.1%
2107 Томилолт, зочны зардал	69.9%	95.3%	89.6%	93.9%	96.7%	84.1%	86.9%	93.2%	88.8%	88.7%
2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89.2%	89.7%	91.5%	63.8%	76.6%	78.5%	96.3%	79.9%	83.3%	83.2%
2109 Бараа үйлчилгээний бусад зардал	126.9%	82.2%	87.3%	85.5%	94.1%	62.0%	93.8%	58.5%	69.9%	84.5%
212 Татаас	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	97.9%	100.0%	100.0%	99.7%

2121 Төрийн өмчит байгууллагад олгох татаас					100.0 %	100.0 %			100.0 %	100.0%
2122 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	100.0 %		100.0 %	100.0 %	100.0 %	100.0 %	97.9%			99.7%
213 Урсгал шилжүүлэг	88.6%	54.9%	86.7%	95.7%	89.9%	93.9%	86.9%	96.8%	84.9%	86.5%
2131 Засгийн газрын урсгал шилжүүлэг	108.8%	348.2 %	100.0 %	98.0%	100.0 %	52.4%	55.3%	100.0%	74.0%	115.2%
2132 Бусад урсгал шилжүүлэг	86.4%	35.2%	85.6%	94.9%	88.3%	98.1%	92.1%	95.8%	85.3%	84.6%
22 Хөрөнгийн зардал	54.4%	86.4%	94.4%	98.4%	-	-	-	100.0 %	86.0%	86.6%
2200 Барилга байгууламж	75.2%	98.1%	86.6%	97.3%				100.0%	95.5%	92.1%
2210 Их засвар								100.0%	98.0%	99.0%
2220 Тоног төхөөрөмж								100.0%	46.4%	73.2%
2230 Бусад хөрөнгө	49.8%	84.8%	95.1%	99.3%	99.8%	100.0 %	66.9%	100.0%	93.6%	87.7%

2015-2023 оны дунджаар урсгал зардлын гүйцэтгэл 89.9 хувьтай байгаа бөгөөд цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын гүйцэтгэл 97.6 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн гүйцэтгэл 96.8 хувь, эд хогшил, урсгал засварын зардлын гүйцэтгэл 95.1 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын гүйцэтгэл 93.1 хувь, нормативт зардлын гүйцэтгэл 92.7 хувийн гүйцэтгэлтэй буюу эдгээр зардлууд нь хамгийн өндөр гүйцэтгэлтэй байна.

Харин байгаль орчны салбарын голлох зардал болох хангамж, бараа материалын зардлын гүйцэтгэл 80.4 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын гүйцэтгэл 83.3 хувь, бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэл 84.5 хувьтай буюу дунджаас доогуур байна. Мөн хөрөнгийн зардлын гүйцэтгэл 86.6 хувьтай байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэл хамгийн муу байсан 2020 он, 2022 он, 2023 онуудад хангамж, бараа материалын зардлын гүйцэтгэл, засгийн газрын урсгал шилжүүлгийн гүйцэтгэл, бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн гүйцэтгэл хангалтгүй байсан нь голлон нөлөөлсөн байна.

Байгаль орчны салбарт 2024 оны байдлаар нэгдсэн төсвийн хүрээнд нийт 395.7 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд үүнээс **89.2 хувь буюу 352.8 тэрбум төгрөгийг урсгал зардал, үлдсэн 10.8 хувь буюу 42.9 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал** эзэлж байна.

Урсгал зардлын **39.1 хувь буюу 138.1 тэрбум төгрөгийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 32.0 хувь буюу 113.0 тэрбум төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамж, 9.2 хувь буюу 32.4 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус** эзэлж байна.

• **Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг нарийвчлан авч үзэхэд:**

2015-2024 онуудад тус ангиллын дийлэнх хувийг **бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал** эзэлж байгаа бөгөөд тус ангилалд ямар төрлийн зардал хамаарч байгааг нарийвчлан шинжлэхэд хүндрэлтэй.

Тус ангиллаарх зардлыг зориулалтаар нь ангилж үзвэл улсын төсөвт 802150 эрдэм шинжилгээ, судалгааны ажил, 817070 агаарын бохирдлыг бууруулах, 817080 ойжуулалт гэсэн арга хэмжээний санхүүжилтүүд багтсан байна.

Орон нутгийн төсөвт 817010 байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, 817070 агаарын бохирдлыг бууруулах, 822120 хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ, 822030 нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, 822040 нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээ үйлчилгээ зэрэг арга хэмжээнүүдийн санхүүжилт багтсан байна.

• **Бараа үйлчилгээний бусад зардлыг зориулалтаар нь ангилж үзэхэд:**

Улсын төсөвт 817070 агаарын бохирдлыг бууруулах, 803160 цахим шилжилт арга хэмжээ гэсэн зориулалтууд багтсан байна.

Орон нутгийн төсөвт 817010 байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, 817070 агаарын бохирдлыг бууруулах, 817080 ойжуулалт, 822030 нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, 822040 нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, 813050 өвс, тэжээлийн нөөц, 822070 хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ зэрэг зориулалтууд багтсан байна.


Анхаарал хандуулах: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал болон бараа үйлчилгээний бусад зардлын ангилалд хамаарах зардлуудыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Хөрөнгийн зардлын 64.4 хувь буюу 27.6 тэрбум төгрөгийг барилга байгууламж, 22.9 хувь буюу 9.8 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж, 12.7 хувь буюу 5.5 тэрбум төгрөгийг их засварын зардал тус тус эзэлж байна.

9.1 Хөрөнгийн зардлын гүйцэтгэл

Хөрөнгийн зардал нь 2015-2023 оны дунджаар нийт зардлын 12.1 хувь буюу 15.0 тэрбум төгрөгийг эзэлсэн ба жилд дунджаар 21.5 хувиар өссөн бөгөөд 2023 оны байдлаар 22.5 хувиар өсөж 19.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

График 19. Салбарын хөрөнгийн зардлын гүйцэтгэл, /тб.₮/



Сүүлийн 4 жилийн дунджаар нийт хөрөнгийн зардлын 1.7 хувь буюу 312 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн бол 98.3 хувь буюу 16.6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна. Салбарын хэмжээнд 2015-2023 оны хугацаанд нийт 57 шилжих, 9 шинэ төсөл хөтөлбөр арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжүүлж буй хөрөнгийн зардлын дийлэнх хувийг барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлаас бусад хөрөнгө оруулалтын зардал эзэлж байгаа бол улсын төсвийн хөрөнгө оруулалтын дийлэнх буюу 89.9 орчим хувийг барилга байгууламж, 3.1 хувийг их засвар, 4.7 хувийг тоног төхөөрөмж, 2.3 хувийг бусад хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

2015-2023 оны хугацаанд салбарын нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн томоохон төсөл хөтөлбөрүүдээс дурдвал:

- 2019-2023 он (5,936.1 сая.₮)- Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байр /Улаанбаатар/
- 2019-2020 он (4,284.0 сая.₮)- Хөв цөөрөм байгуулах /Увс, Хяргас сум/
- 2019-2022 он (3,737.0 сая.₮)- Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах /Архангай/
- 2020-2023 он (3,294.9 сая.₮)- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагуудын нэгдсэн конторын барилга /Хэнтий, Хэрлэн сум/
- 2019-2023 он (2,985.6 сая.₮)- Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах /Сүхбаатар/
- 2022-2023 он (2,386.2 сая.₮)- Аварга тосон, Бүрд нууруудыг сэргээх /Хэнтий, Дэлгэрхаан сум/
- 2022-2023 он (1,929.9 сая.₮)- Хог хаягдал шатаах зориулалтын дунд оврын зуух /Завхан, Отгон, Эрдэнэхайрхан, Улиастай, Тосонцэнгэл, Дөрвөлжин, Цагаанхайрхан, Тэс, Сонгино сум/

- 2020 он (1,860.0 сая.₮)- Усны техник эдийн засгийн үндэслэл боловсруулах / Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/
- 2018 он (1,228.0 сая.₮)- Ус цаг уур, орчны шинжилгээний газрын барилга /Увс, Улаангом сум/
- 2020 он (1,100.0 сая.₮)- Улз голын урсцыг нэмэгдүүлэх “Онон-Улз” төсөл / Дорнод, Хэрлэн сум/ төслүүд багтаж байна.

ШИГТГЭЭ 3.

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БАТЛАГДСАН ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ

2024 онд Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хэмжээнд нийт 2 шилжих төсөл, 13 шинэ төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нийт 20.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхээр баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулах барилга байгууламжийн арга хэмжээ:

- Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байр /Улаанбаатар хот/,
- Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат /Сүхбаатар аймаг/
- Хэрлэн голыг бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төсөл /Хэнтий аймаг/
- Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат /Архангай аймаг/
- Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Баянхонгор аймгийн Баянхонгор сум, Өвөрхангай аймгийн Хужирт сум/
- Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр, Тариалан, Цагаан-Үүр сум/,
- Чигжийн голын хөв цөөрөм /Увс аймгийн Өндөрхангай сум/),

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих тоног төхөөрөмжийн арга хэмжээ:

- Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/
 - Ногоон байгууламж бүхий эко дүүрэг /Нийслэлийн Баянгол дүүрэг/
 - Агаарын бохирдлыг бууруулах тоног төхөөрөмж /Нийслэлийн Баянгол дүүрэг /
 - Цаг уурын албаны тоног төхөөрөмж /Төв аймаг/
- болон Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/ гэсэн 1 их засварын ажил тус тус хийгдэхээр батлагдсан байна.

9.2 Гадаадын зээл тусламжийн гүйцэтгэл

Байгаль орчны салбарын 2015-2023 оны дундаж гадаадын зээл тусламжийн зардал салбарын нэгдсэн төсвийн зардлын 6.8 хувь буюу 10 орчим тэрбум төгрөг тэнцэж байгаа бөгөөд жилд дунджаар 22.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 26. Салбарын гадаад зээл, тусламжийн зардал, /тб.₮/

	Төлөвлөгөө /сая.₮/	Гүйцэтгэл /сая.₮/	Зөрүү /сая.₮/	Гүйцэтгэлийн хувь
2015	0.64	-	(0.64)	0.0%
2016	6.62	4.70	(1.92)	71.0%
2017	11.92	11.59	(0.33)	97.3%
2018	8.95	9.63	0.69	107.7%
2019	11.29	9.21	(2.08)	81.6%
2020	9.13	8.83	(0.30)	96.7%
2021	10.88	10.88	0.00	100.0%
2022	10.65	9.48	(1.18)	89.0%
2023	22.87	12.16	(10.71)	53.2%
Нийт	92.94	76.48	(16.46)	82.3%

2015-2023 оны хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хүрээнд дэх байгаль орчны салбарын гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн томоохон төсөл хөтөлбөрүүдийг Хүснэгт 16-д харуулж байна.

Хүснэгт 27. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн томоохон төслүүд

	Төслийн нэр	Хэрэгжсэн он	Олгосон санхүүжилт/сая.₮/
1	Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ төсөл	2016- 2018 он	1,077.3
2	НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын 3 дугаар тайлан илтгэл боловсруулах төсөл	2016- 2018 он	783.5
3	НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын Үндэсний хоёр жил тутмын тайлан боловсруулах төсөл	2016- 2018 он	695.5
4	Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөр	2017- 2018 он	6,067.2
5	Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь	2017- 2018 он	2,136.0
6	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл	2017- 2021 он	7,476.4
7	Мазаалай баавгайн амьдрах орчны нөхцөлийг сайжруулах" төсөл	2019-2021 он	1,033.1
8	Байгаль орчны төв лабораторийн чадавхыг сайжруулах төсөл	2021-2024 он	1,140.4
9	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл	2016-2024 он	53,108.5

Дээрх төсөл арга хэмжээнүүдээс өнөөгийн байдлаар Байгаль орчны төв лабораторийн чадавхыг сайжруулах төсөл болон Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл II гэсэн төслүүд хэрэгжиж байна.

Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг баталдаг. Төсвийн ерөнхийлөн захирагч (сайд) нар төсвийн жил дууссаны дараа төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, СЯ-нд ирүүлэх үүргийг Төсвийн тухай хуулиар хүлээдэг. Уг тайланд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлтийг багтаасан байх ёстой. СЯ-аас Монгол Улсын жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэж дараа оны 5 дугаар сарын 10-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх ба аудитын байгууллагын дүгнэлт гарсны дараа УИХ-аар хэлэлцүүлж, гүйцэтгэлийг батлуулдаг.

Байгаль орчны салбарын хүрээнд улсын төсвөөс санхүүжиж буй хүрээлэн буй орчны хөтөлбөрүүдийг салбарын улсын ТЕЗ буюу БОАЖС-ын тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтээр баталж тухайн жилийн “Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт”-д тусгадаг.

Орон нутгийн төсвөөс санхүүжиж буй хүрээлэн буй орчны хөтөлбөрийг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтээр баталдаг.

10.1 Улсын ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүн, зардлын өгөөж

Монгол Улсын 2020 он, 2021 он, 2022 оны төсвийн тухай хуулиудаар баталсан байгаль орчны салбарын хүрээлэн буй орчны хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах /Хүснэгт 17/-д харьцуулан харуулав.

Хүснэгт 28. Байгаль орчны салбарын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд

№	Хөтөлбөр	Хөтөлбөрийн үр дүнгийн чанарын ба тоон шалгуур үзүүлэлтүүд	2020 оны зорилтот түвшин	2021 оны зорилтот түвшин	2022 оны зорилтот түвшин	2023 оны зорилтот түвшин
1		Ойгоор бүрхэгдсэн газар нутгийн хэмжээ /хувь/	8.5			
2		Ойжуулах, ойг нөхөн сэргээх /мянган га/	12	6	7.1	9.0
3	Ойжуулалт	Ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх /мянган га/	50	50	27.5	27.5
4		Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх /мянган га/	30	30	1.6	36
5		Тусгай хамгаалалтад авсан гол мөрний урсац бүрэлдэх эхийн эзлэх хувь		50.5	51	

№	Хөтөлбөр	Хөтөлбөрийн үр дүнгийн чанарын ба тоон шалгуур үзүүлэлтүүд	2020 оны зорилтот түвшин	2021 оны зорилтот түвшин	2022 оны зорилтот түвшин	2023 оны зорилтот түвшин
6	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	Урсац бүрэлдэх эхийг тусгай хамгаалалтад авсан гол мөрний эзлэх хувь	50			
7		Ус хангамжийн эх үүсвэрийн нөөц тогтоох хайгуул судалгаа хийх сумын төв		4	4	4
8		Гидрогеологийн дунд масштабын 1:200000 зураглалын ажлыг өргөжүүлж, зураглал хийгдсэн талбайн нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь				16
9	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь	21	22	22	
10		Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх /мянган га/	1200	600	1900	
11	Ус цаг уур, орчны шинжилгээ	Цаг агаарын төлөв байдал, ус цаг уурын үзэгдэлд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр ашгийн түвшин /хувиар/	68	68	68	68
12		Аэрологийн өртөөдийн хөөргөлтийн тооны өсөлт /тоо/	2 дахин			
13	Хүрээлэн байгаа орчны удирдлага, судалгаа шинжилгээ	Ховор, нэн ховор болон ашиглалтад өртөмхий амьтан, ургамлын нөөцийг хамгаалах, амьдрах орчныг тэтгэх төсөл арга хэмжээ /зүйлийн тоо/	2			
14		Ховор, нэн ховор болон ашиглалтад өртөмхий амьтан, ургамлын нөөц, тоо толгой, тархцын судалгаа хийх /зүйлийн тоо/	2			
15	Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт	Бохирдуулах бодисын бууралт /суурь түвшин-2016 оны 12 дугаар сарын дундаж, хувь/	50			
16		Ногоон төсөл санаачилгыг дэмжих /Ногоон эзэлд хамрагдах өрхийн тоо/	2000		1000	50/400
17		Гэр хорооллын хэрэглэгчдийг шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтөд хамруулах нөхцөлийг бүрдүүлэх /өрхийн тоо/		138000		
18		Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт /хувиар/		80-аас доошгүй	80-аас доошгүй	
19		Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж /мкг/м3/		55	92	
20		Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцор			115	
21		Дулааны станцад шинээр суурилуулсан утаа шүүгчийн тоо (PM2.5 тоосонцор мкг/м3)				100
22		Отоглох цэгүүдэд байгуулсан ариун цэврийн байгууламжийн тоо				10

№	Хөтөлбөр	Хөтөлбөрийн үр дүнгийн чанарын ба тоон шалгуур үзүүлэлтүүд	2020 оны зорилтот түвшин	2021 оны зорилтот түвшин	2022 оны зорилтот түвшин	2023 оны зорилтот түвшин
23	Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хувь	75.8	75.8	76.9	
24		Доройтсон бэлчээрийг сэргээх, байгалийн ашигт ургамал тарих /га/			70	
25		Элсний нүүлтийг сааруулах механик хаалт хийх /га/			50	
26		Газрын доройтлыг бууруулах, элсний нүүлтийг сааруулах механик хаалт хийх талбайн хэмжээ /мянган га/, /21 аймаг, нийслэл, УТХ газар/				160
27		Цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас хийх талбайн хэмжээ /га эссөн дүнгээр/				150

Монгол Улсын 2020 он, 2021 он, 2022 он, 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан байгаль орчны салбарын хүрээлэн буй орчны нийт 8 хөтөлбөрийн **27 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг тогтмол баталсан байна.** Үүнд:

- Ойжуулалт хөтөлбөрийн Ойжуулах, ойг нөхөн сэргээх /мянган га/, Ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх /мянган га/, Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх /мянган га/ гэсэн 3 шалгуур үзүүлэлт;
- Ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн Цаг агаарын төлөв байдал, ус цаг уурын үзэгдэлд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр ашгийн түвшин /хувиар/ гэсэн 1 шалгуур үзүүлэлт багтаж байна.

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар батлагдаад 2021 он, 2022 он, 2023 онд батлагдаагүй шалгуур үзүүлэлтүүд:

- “Ойгоор бүрхэгдсэн газар нутгийн хэмжээ /хувь/”, “Урсац бүрэлдэх эхийг тусгай хамгаалалтад авсан гол мөрний эзлэх хувь”, “Аэрологийн өртөөдийн хөөргөлтийн тооны өсөлт /тоо/”, “Бохирдуулах бодисын бууралт /суурь түвшин-2016 оны 12 дугаар сарын дундаж, хувь/”, “Ховор, нэн ховор болон ашиглалтад өртөмхий амьтан, ургамлын нөөцийг хамгаалах, амьдрах орчныг тэтгэх төсөл арга хэмжээ /зүйлийн тоо/”, “Ховор, нэн ховор болон ашиглалтад өртөмхий амьтан, ургамлын нөөц, тоо толгой, тархцын судалгаа хийх /зүйлийн тоо/” гэсэн 6 шалгуур үзүүлэлт байна.

Монгол Улсын 2020 он, 2021 он, 2022 оны Төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар батлагдаад 2023 онд батлагдаагүй шалгуур үзүүлэлтүүд:

- Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хувь, Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх /мянган га/ гэсэн 3 шалгуур үзүүлэлт байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан 2020 он, 2021 он, 2022 онд батлагдаагүй шалгуур үзүүлэлтүүд:

- Гидрогеологийн дунд масштабын 1:200000 зураглалын ажлыг өргөжүүлж, зураглал хийгдсэн талбайн нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь, Дулааны станцад шинээр суурилуулсан утаа шүүгчийн тоо (PM2.5 тоосонцор мкг/м3), Отоглох цэгүүдэд байгуулсан ариун цэврийн байгууламжийн тоо, Газрын доройтлыг бууруулах, элсний нүүлтийг сааруулах механик хаалт хийх талбайн хэмжээ / мянган га/, /21 аймаг, нийслэл, УТХГ/, Цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас хийх талбайн хэмжээ /га өссөн дүнгээр/ гэсэн 5 шалгуур үзүүлэлт байна.

БОАЖС-ын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд нь жил бүрийн “Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт”-д ялгаатай байдлаар батлагдаж байгаа нь тухайн хөтөлбөрийн үр өгөөжийг тооцооход хүндрэл учруулж байна. Мөн хөтөлбөрийн хүрэх үр дүн, хэмжих шалгуур үзүүлэлтийг Төсвийн тухай хуулиар баталдаг боловч хөтөлбөрийн үр дүнгийн томьёолол хуульд тусгагдахгүй байна. Байгаль орчны салбарын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийн ихэнх нь тоон шалгуур үзүүлэлтүүд бөгөөд төсвийн хөрөнгөөр хөтөлбөр хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг бус зөвхөн хийх ажил, үйлчилгээний гарцын үзүүлэлтийг хэмжих шалгуур болж байна. Цаашид байгууллагуудаас авдаг захиргааны тоо мэдээллийг сайжруулах, албан ёсны статистик үзүүлэлтүүдийг шинэчлэх, салбарын хувийн хэвшилд ажиллагчдын тооны статистик мэдээлэл зэргийг тооцдог болох шаардлагатай байна.

10.1.1 Ойжуулалт хөтөлбөрийн үр дүн, зардлын өгөөж

Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд улсын төсвөөс Ойн газар (ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг), орон нутгийн төсвөөс аймаг, сум, сум дундын нийт 40 ойн анги үйл ажиллагаа санхүүжсэн байна. Ойжуулалтын чиглэлд үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын төсвийн зардлын дийлэнх хувийг ойжуулалт болон үндсэн үйл ажиллагааны зардал эзэлж байна.


2015-2023 оны дунджаар ойн газрын нийт зардлын 11.8 хувийг үндсэн үйл ажиллагааны зардал, 88.1 хувийг ойжуулалтын арга хэмжээний зардал эзэлж байсан бол ойн ангиудын нийт зардлын 77.8 хувийг үндсэн үйл ажиллагааны зардал, 11.7 хувийг ойжуулалтын арга хэмжээнд зарцуулсан байна.

Ойжуулалтын арга хэмжээний хүрээнд

Улсын төсвөөс ойжуулалт хөтөлбөрийн зардалд 2015-2023 оны дунджаар 6.8 тэрбум төгрөг баталснаас 88 хувийн гүйцэтгэлтэйгээр 6.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

2019-2022 оны хугацаанд “Ковид 19 цар тахал”-ын нөлөөгөөр ойжуулалт хөтөлбөрийн зардал дунджаар 35 хувиар буурч 3.4 тэрбум төгрөгийг зарцуулсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” эрчимжиж байгаатай холбоотойгоор 2022 онд 1.9 тэрбум төгрөг байсан зардал 2023 онд 15 тэрбум төгрөг болж 8 дахин өссөн байна.

График 20. Улсын төсвийн ойжуулалт хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл, /сая.₮/



2015-2023 оны хугацаанд ойжуулалт хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдээс ойжуулах, ойг нөхөн сэргээх талбайн хэмжээ, ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх талбайн хэмжээ, ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ гэсэн 3 шалгуур үзүүлэлтийг тогтмол баталж хэрэгжүүлсэн.

Ойжуулах, ойг нөхөн сэргээх: Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2015-2023 он хүртэлх хугацаанд нийт 109.8 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээх зорилттой байснаас 62.8 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээсэн хийсэн байна.

График 21. Ойжуулах, ойг нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ /мян.га/



2016-2018 он, 2022 онуудад зорилтот түвшинг өндрөөр давуулан биелүүлсэн бол 2015 он, 2019-2021 он, 2023 онуудад зорилтот түвшинд хүрээгүй байна.


2019-2021 оны дунджаар ойжуулалт хөтөлбөрийн зардал 38.2 хувиар буурсан байхад 2019 онд хэт өндөр буюу 35 мянган га талбайг ойжуулах, нөхөн сэргээх зорилт тавьсан нь зардлын хэмжээтэй уялдаагүй бөгөөд ердөө 8.6 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээсэн байна. 2020 он, 2021 онд цар тахал, хөл хориотой холбоотойгоор хөтөлбөрийн хүрэх үр дүн маш бага буюу 34 хувь, 18 хувьтай биелсэн байна.

Харин 2022 оны хувьд хөтөлбөрийн зардал хамгийн бага байсан бөгөөд 7.1 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээх зорилттой байснаас 119 хувийн биелэлттэйгээр 8.4 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээсэн байна.

2023 оны хувьд хөтөлбөрийн зардал өндрөөр өссөнтэй холбоотойгоор 36 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээх зорилттой байснаас 62 хувийн гүйцэтгэлтэйгээр 22.3 мянган га талбайг ойжуулж, нөхөн сэргээсэн байна.

Ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил: Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2015-2023 оны хугацаанд нийт 1302.5 сая га талбайд ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажлыг гүйцэтгэх зорилттой байснаас 1357.1 мянган га талбайд ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажлыг гүйцэтгэсэн байна.


График 22. Ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх талбайн хэмжээ /мян.га/



2015-2017 он, 2020 он, 2022 онуудад зорилтот түвшинг давуулан биелүүлсэн бол 2018 он, 2019 он, 2021 он, 2023 онуудад зорилтот түвшинд хүрээгүй байна.

Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ: 2015-2023 оны хугацаанд нийт 227 мянган га талбайд ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэсэн байна.

График 23. Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ /мян.га/



2015 он, 2016 он, 2020 он-2023 онуудад зорилтот түвшинг давуулан биелүүлсэн бол 2017 он, 2018 онуудад зорилтот түвшинд хүрээгүй бол 2019 онд шалгуур үзүүлэлтийг батлаагүй байна.

Энэхүү ойжуулалт хөтөлбөрийн үр дүнд 2022 оны байдлаар “Монгол орны ойн нөөц 8.2 хувьд¹³ хүрсэн” хүрсэн бөгөөд “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Ногоон хөгжлийн бодлогын “Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь” шалгуур үзүүлэлтийн 2022 оны хүрэх үр дүн хангагдсан байна. 2015-2023 оны дунджаас харахад ойжуулалт хөтөлбөрийн 6,139.1 сая төгрөгийн зардлаар 7.0 мянган га талбайд ойжуулах, нөхөн сэргээх арга хэмжээ, 150.8 мянган га талбайд ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн арга хэмжээ, 28.4 мянган га талбайд ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Дээрх үр дүнг нарийвчлан авч үзвэл 1 га талбайд ойжуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэхэд дунджаар 33 мянган төгрөг зарцуулсан байна.

Ойжуулалт хөтөлбөрийн зардал болон зардлын өөрчлөлт нь шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, хүрсэн үр дүн хооронд уялдаатай эсэхийг тодорхойлох зорилгоор корреляцийн хамаарлын шинжилгээг гүйцэтгэв.

Хүснэгт 29. Хөтөлбөрийн зардал, хүрсэн үр дүнгийн хамаарлын шинжилгээ

	Ойжуулах, ойг нөхөн сэргээх талбайн хэмжээ	Ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх талбайн хэмжээ	Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ
Ойжуулалтын зардал	0.709	0.623	(0.269)

Ойжуулах, ойг нөхөн сэргээсэн талбайн хэмжээ нь ойжуулалт хөтөлбөрийн зардалтай эерэг хүчтэй хамааралтай /0.709/ байгаа бол ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх талбайн хэмжээ нь эерэг дунд хамааралтай /0.623/ байна. Харин ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ ойжуулалтын зардлын хэмжээтэй хамааралгүй /-0.269/ байна.

Хүснэгт 30. Хөтөлбөрийн зардлын өсөлт, шалгуур үзүүлэлтийн хамаарлын шинжилгээ

	Ойжуулах, ойг нөхөн сэргээх талбайн хэмжээ /шалгуур үзүүлэлтийн биелэлт/	Ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх талбайн хэмжээ /шалгуур үзүүлэлтийн биелэлт/	Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ /шалгуур үзүүлэлтийн биелэлт/
Ойжуулалтын зардлын өөрчлөлт	(0.026)	(0.155)	(0.220)

Энэхүү шинжилгээний үр дүнд ойжуулалт хөтөлбөрийн зардлыг нэмэгдүүлэх нь шалгуур үзүүлэлтийн биелэлттэй хамааралгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Ойжуулалт хөтөлбөрийн зардал 2022 онд 23.4 хувиар буурч 1.9 тэрбум төгрөг байсан. Тухайн жилд 7.1 мянган га талбай (өмнөх оны зорилтот түвшнээс 1.1 мянган га-р их) д ойжуулах, ойг нөхөн сэргээх ажил гүйцэтгэхээр зорьсноос 119 хувийн

¹³ Монгол Улсын Засгийн Газар 3 жил /Онцлох ажлууд/

гүйцэтгэлтэйгээр 8.4 мянган га талбайд зорилтот арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх талбайн хэмжээг 27.5 мянган га талбай (өмнөх оны зорилтот түвшнээс 22.5 мянган га-р бага) хүргэнэ гэж зорьсноос 298 хувийн гүйцэтгэлтэйгээр 82 мянган га талбайд зорилтот арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээг 1.6 мянган га талбай (өмнөх оны зорилтот түвшнээс 28.4 мянган га-р бага) хүргэнэ гэж зорьсноос 1550 хувийн гүйцэтгэлтэйгээр 24.8 мянган га талбайд зорилтот арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн байгаа нь энэхүү хамаарлын шинжилгээний үр дүнг баталж байна.


10.1.2 Ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн үр дүнг, зардлын өгөөж

Ус, цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн хүрээнд улсын төсвөөс Цаг уур, орчны шинжилгээний газар (ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг), аймаг нийслэлийн нийт 22 Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчны шинжилгээний төв лаборатори, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Нислэгийн цаг уурын төв гэсэн нийт 26 төсөвт байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна. Дээрх байгууллагуудын төсвийн нийт зардлын дийлэнх хувийг үндсэн үйл ажиллагааны зардал эзэлдэг.

2015-2023 оны дунджаар Цаг уур, орчны шинжилгээний газрын нийт зардлын 60.6 хувь, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн нийт зардлын 96 хувь, Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн нийт зардлын зардлын 96.5 хувийг, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн нийт зардлын 95.2 хувь, Нислэгийн цаг уурын төвийн 97.8 хувийг тус тус үндсэн үйл ажиллагааны зардал эзэлж байна.

Улсын төсвөөс ус, цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн зардалд 2015-2023 оны дунджаар 28.8 тэрбум төгрөг баталснаас 101.3 хувийн гүйцэтгэлтэйгээр 29.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Ус цаг уур орчны шинжилгээ хөтөлбөрийн зардал жилд дунджаар 12.6 хувиар өссөн бөгөөд 2023 оны байдлаар 52.2 хувиар өсөж 48.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.


График 24. Улсын төсвийн ус, цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл, /тб.₮/



Ус, цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн хүрээнд 2016-2023 он хүртэлх хугацаанд “Цаг агаарын төлөв байдал, ус цаг уурын үзэгдэлд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр ашгийн хувь” гэсэн шалгуур үзүүлэлтийг баталж хэрэгжүүлсэн.

Цаг агаарын төлөв байдал, ус цаг уурын үзэгдэлд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр ашгийн хувь: Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2016-2023 он хүртэлх хугацаанд цаг агаарын төлөв байдал, ус цаг уурын үзэгдэлд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр ашгийн хувийг жил тутамд 66 орчим хувьд хүргэх зорилтот түвшинг баталсан.

График 25. Цаг агаарын төлөв байдал, ус цаг уурын үзэгдэлд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр ашгийн хувь



Дээрх графикаас харахад 2016-2022 онд ТЕЗ-ын “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх хувь” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрэх үр дүн бүрэн хангагдсан байна.

Хэдий шалгуур үзүүлэлт зорилтот түвшинд хүрсэн ч 2020 онд хөтөлбөрийн зардал 33.4 хувиар, 2021 онд 13.8 хувиар, 2023 онд 52.2 хувиар тус тус нэмэгдсэн байна. Ийнхүү хөтөлбөрийн зардал өөрчлөгдөж байсан боловч хөтөлбөрийн зардлаар хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтот түвшнийг сүүлийн 4 жилийн хугацаанд 68 хувьд тогтмол баталж өөрчлөөгүй байна.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйлчилгээ: Цаг агаарын үзэгдэлд нөлөөлөх ажлын нэг хэсэг нь үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэн оруулснаар хөрсний угтвар чийг, бэлчээрийн болон таримал ургамлын ургацыг нэмэгдүүлэх, усан сан, гадаргын усны нөөцийг тэтгэх, таримал ургамлыг мэдрөөс хамгаалах, хүн, газрын техник хүрч ажиллахад хүндрэлтэй ой, хөвч, тайгын түймрийг унтраах үйл ажиллагаа юм. Монгол орны дархан цаазтай болон тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн төрөл зүйл, ан амьтны идэш тэжээлийн асуудал ч мөн энд хамаатай болно.

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 96 дугаар тогтоолоор “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталж хэрэгжүүлсэн нь ус, цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт жил тутам зорилтот түвшиндээ хүрч амжилттай хэрэгжих суурь нөлөөг бүрдүүлсэн байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн зардлын өгөөж:

2021 онд Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Шарга Бороо-1,2,3 экспедицүүд 14 удаагийн ажиллагаанд явж, 224 цаг ажилласан байна. Ингэхдээ 3 автомашин 567 литр шатахууныг зарцуулж, 4700 км газрыг туулж Сүхбаатар аймгийн 13 сумын 93985.7 км.кв хэмжээтэй газар нутгийг хамарсан цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэн ажилласан байна.

Энэхүү арга хэмжээний үр дүнд цаг агаарт зориудаар нөлөөлж нэмэгдүүлсэн хур тунадасны эдийн засгийн үр ашгийн тооцоог гаргаж үзвэл 947 сая 081мянга 919.6 төгрөгийн үр ашигтай ажиллаж, байгалийн жамаар орох хур тунадасны хэмжээг 19.8%-аар нэмэгдүүлсэн байна гэж тэмдэглэжээ¹⁴.

Энэхүү тайлангаас үр дүнгээс харахад ус, цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн зарцуулалт нь эдийн засгийн үр ашиг өндөртэй байна.

10.2 Орон нутгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүн, зардлын өгөөж

Орон нутгийн төсвийн хөтөлбөрийг орон нутгийн ТЕЗ нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд батлан хэрэгжүүлдэг. Энэхүү бүлэгт 2023 оны орон нутгийн төсвөөр санхүүжүүлсэн хүрээлэн буй орчны ойжуулалт хөтөлбөрийн үр дүнгийн талаар тусгалаа.

2023 оны байдлаар 17 орон нутгийн ТЕЗ ойжуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн аймгуудын дундаж гүйцэтгэлийн хувь 94.4 хувьтай байна. Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн ТЕЗ нарын хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд, хүрсэн үр дүнг /Хүснэгт 31/-т харуулж байна.

¹⁴ Сүхбаатар аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвийн Цаг агаарт зориудаар нөлөөлсөн 2021 оны ажлын тайлан

Хүснэгт 31. Орон нутгийн ТЕЗ нарын ойжуулалт хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл

	Ойжуулалт хөтөлбөрийн хүрэх үр дүн	Ойжуулалт хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Х/Т-ний Гүйцэтгэлийн хувь
АРХАНГАЙ	Ойн ангийн үйл ажиллагааны хэвийн, жигд байдал хангагдсан	Үйл ажиллагааны хэвийн, жигд байдал, үйл ажиллагааны үр дүн	хувь	160	140.0	87.5%
БАЯН-ӨЛГИЙ	Ойн нөөц, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна	Шинээр тарьсан суулгацын хэмжээ	тоо	85,000	85,000	100.0%
БАЯН ХОНГОР	Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх	Мод үржүүлгийн талбай, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж жилд 500 мянган ширхэг тарьц суулгацыг нийлүүлэхээр зорин ажиллаж байна. Үүнээс тус онд 200 мянган ширхэг мөчрийн тайрдас бэлдэж, талбайдаа тариалалт хийнэ.	тоо	200,000.00	248,000.00	124.0%
БУЛГАН	Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж буй бодлогыг хэрэгжүүлэх	Ойжуулалтын хэмжээ	га	187.5	200	106.7%
ДОРНОД	Ойн нөөц баялгийг тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг зохион байгуулна	Тусгаарласан талбай хэмжээ	га	3867	5410.4	139.9%
ДУНДГОВЬ	Ойн нөөц баялгийг тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг зохион байгуулна	Ногоон байгууламж, ойн нөхөн сэргээлт 50 га-д хүрсэн байх	тоо	40	41	102.5%
ДУНДГОВЬ	Аймгийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, хамгаалах нөхөн сэргээх, 5 га ойн зурвас байгуулах	Үйл ажиллагааны хэвийн, жигд байдал, үйл ажиллагааны үр дүн	Хувь	97.0%	90.0%	92.8%
ЗАВХАН	Ойжуулалт, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	Хуваарилсан хөрөнгө	Санхүүжилт ээр	223.5	215.2	96.3%
ӨМНӨГОВЬ	Аймгийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, хамгаалах нөхөн сэргээх, Ойн тухай хуулийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэнэ.	Ойжуулалтын хэмжээ	га	2310	2310	100.0%
СҮХБААТАР	Аймгийн ойн сан бүхий газрын ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ болон төв суурин газрын ногоон байгууламжийн ургалтын хувийг нэмэгдүүлсэн байна.	Шинээр тарьсан модны тоо	тоо	500000	3,754	0.8%
		Ургалтын хувь	Хувь	90	88.5	98.3%
		Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ /га/	Тоо	50	5	10.0%
СЭЛЭНГЭ	Аймгийн төлөвлөгөөнд тусгасан ойжуулалт, нөхөн сэргээлтийг хэрэгжүүлэх	Мод үржүүлгийн талбай, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж жилд 500 мянган ширхэг тарьц суулгацыг нийлүүлэхээр зорин ажиллаж байна. Үүнээс тус онд 200 мянган ширхэг мөчрийн тайрдас бэлдэж, талбайдаа тариалалт хийнэ.	тоо	200,000	248000	124.0%
ТӨВ	Төв суурин газрын ногоон байгууламж, ойжуулалтын талбайг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулна.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	тоо	100	100	100.0%
УВС	Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх	ойг хамгаалах, цэвэрлэх, арчилгаа хийгдсэн талбайн хэмжээ	га	100000	103911	103.9%
ХОВД	Мод үржүүлгийн талбайд тарьц суулгацын нөөцийг бий болгоно.	Үйл ажиллагааны хэвийн, жигд байдал, үр дүн /Хувиар/	хувь	92	97.2	105.7%
ХӨВСГӨЛ	Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж буй бодлогыг хэрэгжүүлэх	Аймгийн ойн нөөц баялгийг тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг зохион байгуулах.	хувь	100	100	100.0%
ДАРХАН-УУЛ	Ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх Аймгийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, хамгаалах нөхөн сэргээх,	Төсөл, арга хэмжээний тоо Хэрэгжилт, хувь	хувь	100%	100.0%	100.0%
ОРХОН	Аймгийн төлөвлөгөөнд тусгасан ойжуулалт, нөхөн сэргээлтийг хэрэгжүүлэх	Ойн тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлж, ойжуулалтыг төлөвлөсөн хугацаанд хийсэн байх	хувь	100%	100%	100.0%
ГОВЬСҮМБЭР	Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх.	Модны тарьц, суулгацын нөөцийн нэмэгдүүлэх хувь Модны ургалтын хувь	хувь	95	90.0	94.7%

Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн ТЕЗ нарын хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс дурдвал:

- **АРХАНГАЙ аймгийн ТЕЗ-ын ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд “Ойн ангийн үйл ажиллагааны хэвийн, жигд байдал хангагдсан” гэсэн үр дүнг тодорхойлж доорх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.**

Тариат суманд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар ойжуулалтын ажлыг 7 га талбайд, Цэнхэр, Жаргалант сумын ойн мэргэжлийн байгууллагууд өөрийн хөрөнгөөр 4 га талбайд ойжуулалт, 4 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг тус тус гүйцэтгүүллээ. Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг улсын төсвийн хөрөнгөөр Ихтамир суманд “Номин хангайн төгөл” ХХК 50 га талбайд, Хангай суманд “Тэгш дүүрэн ММӨМ” ХХК 50 га талбайд, Булган суманд 25 га талбайд “Шинэ алтан бүрд ХХК-аар техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгүүллээ.

Ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлын хүрээнд тарьж суулгасан шинэсний тарьц, суулгац болон үрийн амьдралт 90 хувьтай ургасан болохыг аймгийн Засаг даргын томилсон ажлын хэсгээс тогтоолоо. Цөлжилтийг сааруулах, газрын доройтлыг бууруулах зорилгоор “Архангай-100 Ногоон төгөл”-ийг Эрдэнэбулган сумын төвлөрсөн хогийн цэгийг түшиглэн 8 га, Ихтамир суманд 6 га, Батцэнгэл суманд 5 га, Цэнхэр суманд 0.2 га Тариат суманд 0.36 га, талбайд нийт 19.56 га талбайд ойн зурвасыг шинээр бий болгож 29,800 ширхэг мод тарьж, арчилгаа хамгаалалтын ажлыг гүйцэтгэсэн. Ойн зурвас байгуулах замаар тарьж суулгасан мод, бут сөөг амьдралтын хувь 89-92 хувьтай ургуулсан болохыг намрын тооллогоор тогтоож ажиллалаа¹⁵.

- **БУЛГАН аймгийн ТЕЗ-ын ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд “Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж буй бодлогыг хэрэгжүүлэх” гэсэн үр дүнг тодорхойлж доорх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.**

Ойн ангиуд бургас, улиас, үхрийн нүдний мөчир 10,000 ширхэг, нарс, шинэсний 4-5 кг үрийг тарилтад гаргасан. Хялганат тосгон, Хутаг-Өндөр, Булган сум дундын ойн ангиуд Бугат, Сэлэнгэ, Хутаг-Өндөр суманд насны I, II ангийн ойд арчилгааны огтлолтыг 180 га талбайд, мод бэлтгэлийн 36 аж ахуйн нэгж өөрийн хөрөнгөөр 20 га талбайд арчилгааны огтлолт хийж, 1250 га талбайд ойн цэвэрлэгээний ажлыг хийж энэ онд насны I, II ангийн ойд арчилгааны огтлолт 70 га талбайд хийхээр төлөвлөсөн. Баян-Агт, Бүрэгхангай, Бугат, Орхон, Хангал, Хишиг-Өндөр, Сэлэнгэ суманд 2021-2023 онд “Хожуул” төслийг хэрэгжүүлж, 394.4 га талбайд тусгаарлалт хийж, 264,960 ширхэг хожуулаас 5410.4 м.куб модыг аймаг, сумын иргэдийн түлшний хэрэгцээнд олгох ажлыг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 150.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэв¹⁶.

¹⁵ Аймгийн Засаг даргын жилийн хөгжлийн төлөвлөгөө, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

¹⁶ Аймгийн Засаг дарга, Байгаль орчны сайдтай байгуулсан гэрээ, БОАЖГ-ын гэрээ

• **ӨМНӨГОВЬ** аймгийн ТЕЗ-ын ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд “Аймгийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, хамгаалах нөхөн сэргээх, Ойн тухай хуулийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэнэ” гэсэн үр дүнг тодорхойлж доорх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Өмнөговь аймгийн “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-г зохион байгуулж Даланзадгад сумын 80 га ойн зурвасын талбайд мод тарих ажлыг эхлүүлсэн. Тус талбайд улиас, агч, голт бор, шар хуайс, сухай, бүйлс, барбарис, хайлаас зэрэг нийт 1000 гаруй мод, мөн хүүхдийн паркт 2498 ширхэг модыг нөхөн тарилт болон шинээр тарих үйл ажиллагаанд 35 төрийн болон төсөвт байгууллагууд оролцсон. Намрын бүх нийтээр мод тарих өдрийг 2023 оны 10 сарын 04-ний өдрөөс 10 сарын 16-ний хооронд зохион байгуулсан. Тус өдрийн хүрээнд Даланзадгад сумын 2024 онд ойн зурвас байгуулахаар хашсан 50 га талбайд БОАЖГ-ын төлөөллүүд, 21 аймгаас ирсэн сэтгүүлчидтэй хамтран мод тарих ажлыг зохион байгуулсан. Мөн Баяндалай, Сэврэй сумдын иргэн, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран 2500 ширхэг бортоготой загийн тарилт хийсэн¹⁷ байна.

Орон нутгийн ТЕЗ нарын хэрэгжүүлсэн ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд ойжуулах, байгалийн сэргэн ургалтад туслах арга хэмжээнүүдийг аймаг тус бүр амжилттай гүйцэтгэсэн хэдий ч зарим аймгуудын хувьд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлттэйгээ уялдахгүй байна. Мөн хүрээлэн буй орчны бусад хөтөлбөрүүдийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд салбарын хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтүүд, зорилтуудтай уялдаагүй байх хандлага ажиглагдсан.

Орон нутгийн ТЕЗ нарын хүрээлэн буй орчны хөтөлбөрүүдийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд нь аймаг тус бүрээр ялгаатай бөгөөд хүрсэн үр дүнг тооцоолох нэгдсэн хэмжүүр тодорхойгүй байгаагийн улмаас аймгуудын хувьд ижил арга хэмжээ хэрэгжүүлсэн ч ялгаатай хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдэд ангилагдсан тохиолдол их байна.

Үүнээс гадна хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрэх үр дүн болон хэрэгжилтийг нэгдсэн төсвийн хэмжээнд тодорхойлдоггүй бөгөөд улсын болон орон нутгийн төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд эрс ялгаатай байгаа тул байгаль орчны салбарын хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрээнд зарцуулж буй нийт төсвийн зарлагын бодит үр өгөөжийг хэмжихэд хүндрэлтэй байна.

10.3 Байгаль орчны салбарын сүүлийн 3 жилийн онцлох үр дүнгүүд

Монгол Улсын Засгийн Газрын 2021-2023 оны хугацаанд гүйцэтгэсэн онцлох ажлуудын тайлангаас байгаль орчны салбарын онцлох үр дүнгүүдийг тусгалаа.

¹⁷ Аймгийн Засаг дарга, Байгаль орчны сайдтай байгуулсан гэрээ, БОАЖГ-ын гэрээ

2021 он

- “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнийг эхлүүлж улсын тусгай хамгаалалтад 32.8 сая га талбай бүхий 120 газрыг авч, нийт газар нутгийн 21 хувь, гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн 49.9 хувь, ойн сан бүхий газрын 39.8 хувийг хамгаалсан.
- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд өртсөн 2123 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 679 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийсэн.
- 270 булаг шандын эхийг хашиж хамгаалсан ба 670 нуур, тойром, гол, горхи, булаг, шанд, хөв, цөөрөм сэргэсэн.
- Байгаль орчинд ээлтэй, ногоон бүтээгдэхүүн худалдан авахад зориулж 355 иргэн, ААН-д 1.18 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлтийн санхүүжилт олгосон.

2022 он

- “ТЭРБУМ МОД” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 10 гаруй сая мод тарьж, арчилж, хамгаалсан.
- “Монгол орноо хогноос салгая” аяны хүрээнд усны сан бүхий газрын 8019.2 га талбайн их цэвэрлэгээг хамруулж 1.4 мянган тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.
- 2946.6 га талбайд ойжуулалт, 168 га талбайд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажил, 668.4 га талбайд хамгааллын ойн зурвас, 445.4 га талбайд ногоон байгууламж тарьснаар ойгоор бүрхэгдсэн талбай 8.2 хувь болж өссөн.
- Богдхан уулны дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийг 5593.55 га талбайгаар тэлж, хамгааллыг сайжруулсан.
- 325 булаг шандын эхийг хашиж хамгаалсан ба 313 нуур, тойром, гол, горхи, булаг, шанд, хөв, цөөрөм сэргэсэн.

2023 он

- “ТЭРБУМ МОД” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2023 оны байдлаар 45 сая мод тарьж, арчилж, хамгаалсан.
- Салбарын албан хаагчдын цалингийн сан 20-46 хувиар буюу сүүлийн 5 жилтэй харьцуулахад 2.5 дахин нэмэгдсэн.
- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, орхигдсон 9773 га талбайд нөхөн сэргээлт хийсэн
- Аюултай хог хаягдлыг түр хадгалах стандартын шаардлагад нийцсэн агуулахыг Нийслэлийн Баянзүрх дүүрэг болон 15 аймагт барьж байгуулсан.
- Байгаль орчинд ээлтэй, ногоон бүтээгдэхүүн худалдан авахад зориулж 217 иргэн, ААН-д 1.0 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлтийн санхүүжилт олгосон.

Байгаль орчны салбарын санхүүжилт нь хамрах хүрээний хувьд ихэнхдээ улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагуудын санхүүжилт, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, болон хувь хүн, байгууллагын өргөсөн хандив, тусламжаар хязгаарлагдаж байна.

11.1 Байгалийн нөөц ашигласны төлбөр (БНАТ)

Нэгдсэн төсөв дэх байгаль орчны салбарын орлогын томоохон эх үүсвэр бол байгалийн нөөц ашигласны төлбөр юм. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг “байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулиар зохицуулдаг бөгөөд хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нь зөвхөн орон нутгийн төсвийн орлогод төвлөрдөг бөгөөд дараах орлогууд багтдаг. Үүнд:

- Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого;
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого;
- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого;
- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого;
- Газрын нөөцийн төлбөрийн орлогууд хамаарна.

2015-2023 оны хугацаанд орон нутгийн төсөвт жилд дунджаар байгаль орчны нөөц ашигласны төлбөрийн 152.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрөх хүлээлттэй байснаас 105.1 хувийн гүйцэтгэлтэйгээр 159.7 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

График 26. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын батлагдсан төсөв ба гүйцэтгэл /тб.₮/



2015-2023 он хүртэлх хугацаанд БНАТО жилд дунджаар 12.6 хувиар өссөн бөгөөд 2023 онд 255.4 тэрбум төгрөгт хүрсэн нь 2015 оноос 2.5 дахин, 2022 оноос 13.3 хувиар өссөн үзүүлэлт юм. БНАТО-ын гүйцэтгэлийн хувьд дийлэнх жилүүдэд төлөвлөгөөнөөс давж биелсэн сайн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 32. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын батлагдсан төсөв ба гүйцэтгэл /тб.₮/

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	НИЙТ
Батлагдсан төсөв	101.6	92.2	106.7	107.1	132.7	168.7	213.5	209.5	255.4	1,387.6
Гүйцэтгэл	102.4	104.8	121.9	117.1	159.8	161.1	191.2	225.3	236.2	1,419.8
Гүйцэтгэлийн хувь	100.8%	113.7%	114.3%	109.3%	120.5%	95.4%	89.6%	107.5%	108.1%	102.3%

2015-2023 он хүртэлх хугацаанд дунджаар БНАТО-ын 56.3 хувийг газрын төлбөр, 26.0 хувийг ус, рашаан ашигласны төлбөр, 6.1 хувийг ойн нөөц ашигласны төлбөрийн орлого, 10.0 хувийг ан амьтны нөөц ашигласны төлбөр, 1.6 хувийг байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тус тус бүрдүүлж байгааг /график 18/-т харуулж байна.

График 27. БНАТ-ийн орлогод эзлэх объектын дүн




Харин 2023 оны байдлаар нийт БНАТО-д нийт 255.4 тэрбум төгрөг төвлөрсний 56.9 хувь буюу 145.4 тэрбум төгрөгийг газрын төлбөр, 33.4 хувь буюу 85.3 тэрбум төгрөгийг ус, рашааны нөөц ашигласны төлбөр, 5.5 хувь буюу 14.1 тэрбум төгрөгийг ан амьтны нөөц ашигласны төлбөр, 4.0 хувь буюу 10.3 тэрбум төгрөгийг ойн нөөц ашигласны төлбөр, 0.1 хувь буюу 346.6 сая төгрөгийг байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тус тус бүрдүүлсэн байна.

11.1 Газрын нөөцийн төлбөрийн орлого

“Газрын төлбөрийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлд газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөдөө аж ахуйн газар, хот, тосгон, бусад суурины газар, зам, шугам сүлжээний газар, ойн сан бүхий газар, усны сан бүхий газрууд болон тусгай хэрэгцээний газарт төлбөр ногдуулна гэж заасан.

2015-2023 он хүртэлх хугацаанд газрын нөөцийн төлбөрийн орлого жилд дунджаар 14.0 хувиар өсөж 94.2 тэрбум төгрөг төвлөрч байсан бол 2020 онд 3.7 хувиар буурч 97.1 тэрбум төгрөг, 2021 онд 16.7 хувиар өсөж 113.3 тэрбум төгрөг, 2022 онд 15.9 хувиар өсөж 131.3 тэрбум төгрөг, 2023 онд 10.8 хувиар өсөж 145.4 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

График 28. Газрын нөөцийн төлбөрийн орлого /тб.₮/



2015-2023 он хүртэлх хугацаанд газрын нөөцийн төлбөрийн орлого дунджаар 103.4 хувийн биелэлттэй байсан бол 2020-2023 онд дунджаас доогуур буюу 87.6 хувь, 75.2 хувь, 91.2 хувь, 99.8 хувийн биелэлттэй байлаа.


2023 оны байдлаар газрын нөөцийн төлбөрийн орлогын дийлэнх буюу 53.8 хувийг Улаанбаатар, 20.2 хувийг Орхон, 9.1 хувийг Өмнөговь аймаг тус тус бүрдүүлж байна.

11.1.2 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 6 дугаар зүйлд хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус; уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус; эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан; эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашаан тэдгээрийн орчинд төлбөр ногдуулна гэж заасан.

2015-2023 он хүртэлх хугацаанд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого жилд дунджаар 13.2 хувиар өсөж 49.8 тэрбум төгрөг төвлөрсөн бол 2020 онд 5.5 хувиар буурч 45.1 тэрбум төгрөг, 2021 онд 6.6 хувиар өсөж 48.1 тэрбум төгрөг, 2022 онд 7.0 хувиар өсөж 51.5 тэрбум төгрөг, 2023 онд 65.7 хувиар өсөж 85.3 тэрбум төгрөгт т тус тус хүрсэн байна.

График 29. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого /тб.₮/



2015-2023 он хүртэлх хугацаанд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого дунджаар 102.3 хувийн биелэлттэй байсан бол 2020-2022 онд дунджаас доогуур буюу 93.5 хувь, 96.9 хувь, 98.9 хувийн биелэлттэй байлаа.


2023 оны байдлаар ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын дийлэнх буюу 39.5 хувийг Өмнөговь, 35.4 хувийг Булган, 7.0 хувийг Дорнод аймаг тус тус бүрдүүлж байна.

11.1.3 Ойн нөөц ашигласны төлбөр

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 7 дугаар зүйлд аливаа зориулалтаар ойгоос бэлтгэж ашигласан бүх төрлийн хэрэглээний мод, түлээ болон ойн дагалт баялгийн нөөц самар, мөөг, давирхай, шилмүүс, мөчир, үр, хусны шүүсэнд төлбөр ногдуулна гэж заасан.

2015-2023 он хүртэлх хугацаанд ойн нөөц ашигласны төлбөрийн орлого жилд дунджаар 43.9 хувиар өсөж 9.3 тэрбум төгрөг төвлөрсөн бол 2020 онд 268.3 хувиар өсөж 13.5 тэрбум төгрөг, 2021 онд 11.6 хувиар өсөж 15.1 тэрбум төгрөг, 2022 онд 24.0 хувиар өсөж 18.7 тэрбум төгрөг, 2023 онд 45.0 хувиар буурч 10.3 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

График 30. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого /тб.₮/



2015-2023 он хүртэлх хугацаанд ойн нөөц ашигласны төлбөрийн орлого дунджаар 146.5 хувийн биелэлттэй байсан бол 2020-2022 онд дунджаас дээгүүр буюу 200.7 хувь, 167.1 хувь, 294.3 хувийн биелэлттэй байлаа.

2023 оны байдлаар ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын дийлэнх буюу 28.8 хувийг Сэлэнгэ, 20.7 хувийг Хөвсгөл, 11.2 хувийг Хэнтий аймаг тус тус бүрдүүлж байна.

11.1.4 Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр болон ан амьтны нөөц ашигласны төлбөр

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 5 дугаар зүйлд нэн ховор ургамал, ховор ургамал болон элбэг ургамал ашиглалтад төлбөр ногдуулна гэж заасан бол 8 дугаар зүйлд ахуйн зориулалтаар агнасан, барьсан, үйлдвэрлэлийн зориулалтаар агнасан, барьсан, тусгай зориулалтаар агнасан, барьсан /соёл,

шинжлэх ухаан, тусгай төлбөртэй/ ан амьтны нөөц ашиглалтад төлбөр ногдуулна гэж тус тус заасан.

2015-2023 он хүртэлх хугацаанд ан амьтны нөөц ашигласны төлбөр болон байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогод дунджаар 8.0 тэрбум төгрөг болон 2.6 тэрбум төгрөг төвлөрсөн бөгөөд 2023 оны байдлаар ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого өмнөх оноос 30.6 хувиар буурч 14.1 тэрбум, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого өмнөх оноос 90.1 хувиар буурч 0.3 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

2023 оны байдлаар байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогын дийлэнх буюу 40.4 хувийг Сэлэнгэ, 32.0 хувийг Сүхбаатар, 12.8 хувийг Хөвсгөл аймаг тус тус бүрдүүлж байгаа бол ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын дийлэнх буюу 25.1 хувийг Баянхонгор, 10.0 хувийг Төв, 9.2 хувийг Ховд аймаг тус тус бүрдүүлж байна.

11.1.5 Аймгуудын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлэлт


2015-2023 он хүртэлх хугацаанд орон нутгийн төсвийн нийт татварын орлогод БНАТО дунджаар 12 хувийг бүрдүүлж байсан бол 2020 онд 13.0 хувь, 2021 онд 11.6 хувь, 2022 онд 9.0 хувийг тус тус бүрдүүлсэн байна.

График 31. Орон нутгийн татварын орлогод эзлэх БНАТ-ийн дүн, /тб.₮ ба хувь/




2015-2023 оны дунджаар нийт БНАТО-ын дийлэнх буюу 36.0 хувийг Улаанбаатар, 15.8 хувийг Өмнөговь, 11.0 хувийг Булган, 10.3 хувийг Орхон, 4.2 хувийг Төв, 3.8 хувийг Сэлэнгэ аймаг тус тус бүрдүүлж байна.

График 32. БНАТ-ийн орлого бүрдүүлэлтэд аймгуудын эзлэх хувь



Харин 2023 оны байдлаар орон нутгийн төсөвт БНАТО-ын 255.4 тэрбум төгрөг төвлөрснөөс дийлэнх буюу 32.0 хувь буюу 81.7 тэрбум төгрөгийг Улаанбаатар, 18.7 хувь буюу 47.7 тэрбум төгрөгийг Өмнөговь, 11.7 хувь буюу 29.9 тэрбум төгрөгийг Орхон, 12.5 хувь буюу 31.9 тэрбум төгрөгийг Булган аймаг тус тус бүрдүүлсэн нь нийт БНАТО-ын 78 орчим хувийг бүрдүүлж байна.

Зураг 4. БНАТ-ийн орлого бүрдүүлэлтэд аймгуудын эзлэх дүн, /тб.₮/



БНАТ-ийн орлогын дийлэнх буюу 32.0 хувийг дангаараа бүрдүүлж буй Улаанбаатар хотын БНАТ-ийн орлого нь газрын төлбөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөр, ойн нөөц ашигласны төлбөрөөс бүрддэг бөгөөд нийт орлогын 96 орчим хувийг газрын төлбөр дангаараа бүрдүүлж байна.

БНАТ-ийн орлогын 18.7 хувийг бүрдүүлж буй Өмнөговь аймгийн БНАТ-ийн нийт орлогын 70.8 хувийг ус, рашааны нөөц ашигласны төлбөр, 27.7 орчим хувийг газрын нөөцийн төлбөр тус тус бүрдүүлж байна.

БНАТ-ийн орлогын 12.5 хувийг бүрдүүлж буй Булган аймгийн БНАТ-ийн нийт орлогын 94.5 хувийг ус, рашааны нөөц ашигласны төлбөр, 3.9 хувийг газрын нөөцийн төлбөр, 1.5 хувийг ойн нөөц ашигласны төлбөр тус тус бүрдүүлж байна.

11.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын зарцуулалт

БНАТ-ийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг тогтоосныг хүснэгт 2-т харуулж байна.

Хүснэгт 33. БНАТ-ийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаар

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/
1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15 хувь
2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь
3. Газрын нөөцийн төлбөрийн орлого	15 хувь
4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35 хувь

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан дээрх хуулийн заалтад үндэслэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан зардлыг тооцооллоо.

2015-2023 ОНЫ ДУНДЖААР: байгаль орчны салбарт БНАТ-ийн орлогоос жилд дунджаар хамгийн багадаа 40 ОРЧИМ ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛБАЛ ЗОХИХ байснаас 35 ОРЧИМ ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛСАН бөгөөд зөвхөн 2023 онд зарцуулбал зохих доод хэмжээнээс илүү зардал салбарт зарцуулсан байна.

График 33. БНАТ-ийн орлогоос зарцуулбал зохих дүн болон зарцуулсан дүнгийн харьцуулалт, /тб.₮/



БНАТ-ийн орлогоос жилд дунджаар зарцуулбал зохих 40 орчим тэрбум төгрөгийн дийлэнх буюу 40.3 хувийг ус, рашааны нөөц ашигласны төлбөр, 31.2 хувийг газрын төлбөр, 18.3 хувийг ойн нөөц ашигласны төлбөр, 9.3 хувийг ан амьтны нөөц ашигласны төлбөр, 0.9 хувийг байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 34. БНАТ-ийн орлогоос зарцуулбал зохих дүн (бүрэлдэхүүнээр)

	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	Газрын төлбөр	Ойн нөөц ашигласны төлбөр	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	Нийт
2015	1.19	0.41	8.69	3.11	12.49	25.90
2016	1.67	0.76	7.74	3.69	14.16	28.02
2017	2.57	0.71	8.05	9.05	16.70	37.08
2018	2.79	0.07	9.05	3.45	16.35	31.70
2019	3.67	0.03	15.12	3.11	16.72	38.66
2020	0.57	0.63	14.57	11.47	15.80	43.03
2021	6.49	0.25	17.00	12.80	16.85	53.39
2022	10.16	0.53	19.69	15.86	18.02	64.27
2023	7.05	0.05	21.81	8.73	29.86	67.50

2023 оны байдлаар БНАТ-ийн орлогын эх үүсвэрээс зарцуулбал зохих зардал болон аймгуудын байгаль орчны салбарт зарцуулсан зардлыг /Хүснэгт 35/-т харуулж байна.

Хүснэгт 35. Аймгуудын байгаль орчны салбарт зарцуулсан зардал болон БНАТ-ийн орлогын эх үүсвэрээс зарцуулбал зохих зардлын харьцуулалт /2023 оны байдлаар/

	2023 оны БНАТ-ийн орлого, сая.₮	2023 онд БНАТ-ийн орлогын эх үүсвэрээс зарцуулбал зохих доод хэмжээ, сая.₮	2023 онд аймгуудын байгаль орчны салбарт зарцуулсан зардал сая.₮	Зөрүү
Архангай	1,461.78	1,044.3	1,453.1	408.8
Баян-Өлгий	1,546.97	677.0	970.4	293.4
Баянхонгор	4,787.51	2,052.2	1,251.5	(800.7)
Булган	31,974.58	11,182.7	7,428.5	(3,754.2)
Говь-Алтай	1,386.18	406.2	1,234.4	828.2
Говь-сүмбэр	1,123.22	338.0	701.4	363.4
Дархан-Уул	2,282.54	463.6	689.9	226.3
Дорноговь	6,670.42	1,448.2	1,346.3	(101.9)
Дорнод	8,240.56	2,438.4	2,438.9	0.5
Дундговь	2,202.76	545.9	635.3	89.4
Завхан	1,944.28	779.9	1,651.0	871.2
Орхон	29,945.01	4,597.9	1,891.4	(2,706.5)
Өвөрхангай	3,699.45	1,806.0	929.9	(876.1)
Өмнөговь	47,663.77	14,151.2	1,985.3	(12,165.9)
Сүхбаатар	2,538.40	715.5	1,258.1	542.6
Сэлэнгэ	7,052.46	3,565.5	3,858.4	292.8
Төв	7,370.10	2,564.2	3,493.5	929.3
Увс	1,428.11	601.2	1,959.3	1,358.1
Улаанбаатар	81,668.52	12,945.4	34,699.5	21,754.1
Ховд	2,593.64	889.8	1,685.0	795.2
Хөвсгөл	3,289.40	2,145.5	1,906.1	(239.4)
Хэнтий	4,576.73	2,144.1	1,339.8	(804.3)
Нийт	255,446.39	67,502.7	74,807.2	7,304.5

2023 оны байдлаар байгаль орчны салбарт БНАТ-ийн орлогоос хамгийн багадаа **68 ОРЧИМ ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛБАЛ ЗОХИХ** байснаас **75 ОРЧИМ ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛСАН** байна. Гэсэн хэдий ч БНАТ-ын орлогоор тэргүүлэгч Өмнөговь, Булган, Орхон аймгуудын хувьд байгаль орчны салбарт зарцуулсан зардал нь зарцуулбал зохих доод хэмжээнд хүрээгүй байна.

2015-2023 оны дунджаар дийлэнх аймгуудын хувьд байгаль орчны салбарт зарцуулж буй төсвийн зардал нь БНАТ-ийн орлогоос зарцуулбал зохих зардлаас харьцангуй бага байна. Иймээс байгалийн нөөц ашигласны төлбөрийн(БНАТ) тухай хуулийн заалтуудад үндэслэн төсвийн хөтөлбөрийн ангиллуудыг шинэчилж, байгаль орчны салбарын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж оновчтой захиран зарцуулах, зарцуулалтыг оновчтой бүртгэлжүүлэх шаардлагатай байна.

11.3 Байгаль орчин, уур амьсгалын сан

Байгаль Орчин, Уур Амьсгалын Сан нь “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлд заасныг үндэслэн Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор анх “Байгаль Хамгаалах Сан” нэртэйгээр байгуулагдсан. Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор “Байгаль Хамгаалах Сан”-гийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг шинэчлэн баталж бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

УИХ-ын 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар “Байгаль Хамгаалах Сан”-гийн үйл ажиллагааг өргөтгөн “Байгаль Орчин, Уур Амьсгалын Сан” болгон өөрчлөн байгуулсан. Байгаль орчин, уур амьсгалын сан нь байгаль орчныг хамгаалах, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай. Байгаль орчин, уур амьсгалын сан нь улсын төсөвт хамаардаг.

11.3.1 Байгаль орчин, уур амьсгалын сангийн орлого

Засгийн Газрын тусгай сангийн тухай хуулийн 7.2 дугаар заалтад байгаль орчин, уур амьсгалын сангийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ гэж заасан. Үүнд:

- Хандив, тусламж;
- Тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого;
- Эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр;
- Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж болон тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил, үйлчилгээний нэг удаагийн хөлс;
- Ус бохирдуулсны төлбөр /хаягдал усны стандартад нийцсэн агууламж бүхий ус зайлуулсан, хаясан тохиолдолд төлөх төлбөрийг/
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого;
- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого;
- Байгалийн баялгийг хууль бусаар бэлтгэж борлуулсны орлого;
- Агаарын бохирдлын төлбөр /түүхий нүүрс олборлогч, органик уусгагч үйлдвэрлэгч, импортлогч, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл

эзэмшигч, агаарын бохирдлын эх үүсвэр хэрэглэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнд гаргасан тохиолдолд төлөх төлбөрийг/;

- Аймаг, нийслэлийн Засаг дарга бүх нийтээр мод тарих сарын ажлыг жил бүр зохион байгуулж, 16 насанд хүрсэн иргэн бүр нэг, аж ахуйн нэгж, байгууллага таваас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлах;
- Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны төлбөрийн орлогууд тус тус багтсан байна.

Засгийн Газрын тусгай сангийн тухай хуулийн 7.2-т заасан байгаль орчин уур амьсгалын сангийн хөрөнгийн эх үүсвэр болох ус бохирдуулсны төлбөр болон агаарын бохирдлын төлбөр нь улсын төсөвт төвлөрдөг.

- Агаарын бохирдлын төлбөр: Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 5.6-т агаарын бохирдлын нөхөн төлбөрийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэн Байгаль орчин, уур амьсгалын санд төлнө гэж заасан.


График 34. Агаарын бохирдлын төлбөрийн орлого, /тб.₮/



Агаарын бохирдлын төлбөрийн орлого 2015-2023 оны дунджаар жилд 36 хувиар өсөж 37.6 тэрбум төгрөг төвлөрсөн байна. 2015 онд 13.9 тэрбум төгрөг байсан агаарын бохирдлын төлбөрийн орлого 2023 онд 69.8 тэрбум төгрөгт хүрч 5 дахин өссөн байна.

- Ус бохирдуулсны төлбөр: Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.3-т төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн, усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба орлогын 50-иас доошгүй хувийг цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулна гэж заасан.

График 35. Ус бохирдуулсны төлбөрийн орлого, /тб.₮/



Ус бохирдуулсны төлбөрийн орлогод 2018-2023 оны дунджаар жилд 830.9 тэрбум төгрөг төвлөрсөн бол сүүлийн 2 жилийн хугацаанд дундаж орлого 2 тэрбум төгрөгт хүрч 2021 оноос 4 дахин өссөн байна.

- “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 6.1-т заасан “хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, ажлыг 6.1.2-т зааснаар агаар бохирдуулсны төлбөрийн орлого, 6.1.3-т зааснаар ус бохирдуулсны төлбөрийн орлогоор санхүүжүүлнэ гэж заасан байдаг.

11.3.2 Байгаль орчин, уур амьсгалын сангийн зарлага


Засгийн Газрын тусгай сангийн тухай хуулийн 7.3 дугаар заалтад Байгаль орчин, уур амьсгалын сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна гэж заасан. Үүнд:

- Байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал, өөрчлөлтийн байдлыг судлан тогтоох, мэдээллийг хуримтлуулж боловсруулах, дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилтэт арга, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй, эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах;
- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дэмжих;
- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардлыг санхүүжүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулахад дэмжлэг үзүүлэх;
- Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах;
- Агаар, орчны бохирдлыг бууруулах нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Мэрэгч, хөнөөлт хортон шавж устгах;
- Усыг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх;

- Байгалийн гамшигт үзэгдлээс учирч болох эрсдэлийг бууруулах чиглэлээр олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, танин мэдэхүйн үйл ажиллагааг дэмжих;
- Генетик нөөцийг тогтоох, судлах, хамгаалах, нөхөн сэргээх, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, генийн санг хөгжүүлэх зардлууд тус тус багтсан байна.

2015-2023 оны дунджаар байгаль орчин уур амьсгалын сангийн дундаж зарцуулалт 1,331.8 сая төгрөгтэй байсан бол сүүлийн 4 жил дунджаас доогуур буюу 2020 онд 1,121.5 сая төгрөг, 2021 онд 853.1 сая төгрөг, 2022 онд 513.7 сая төгрөг, 2023 онд 628.1 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

График 36. Байгаль орчин уур амьсгалын сангийн төсвийн зарцуулалт /сая.₮/



Байгаль орчин, уур амьсгалын сангийн орлогоос улсын төсөвт төвлөрсөн орлогоор байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулалт, агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд төсвийн зарцуулалт хийдэг. Улсын төсвийн агаар болон ус бохирдуулсны төлбөрийн орлогыг БОУАС-аас агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан зардалтай харьцуулахад 2015-2023 оны дунджаар нийт зардлын 82.6 хувь буюу 30.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

График 37. Улсын төсвийн агаар болон ус бохирдуулсны төлбөрийн орлого, БОУАС-аас агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт зарцуулсан зардлын харьцуулалт, /тб.₮/



Үүнээс гадна ойжуулалт болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлд байгаль орчин уур амьсгалын сангаас зарцуулсан. Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 16.4 тэрбум төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлд 2018-2023 оны дунджаар жилд 30 тэрбум төгрөг, нийт 181 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

11.4 Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлдэг. Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн эх үүсвэрийг НӨАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хайгуул хийх, олборлолт хийх тусгай зөвшөөрлийн орлого зэрэг төсвийн орлогын тодорхой хувиар тооцож бүрдүүлдэг. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэг, үндсэн нөхцөлд Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг

- Байгаль орчныг хамгаалах;
- Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/ арга хэмжээнүүдэд зарцуулахаар заасан байдаг.

Үүнтэй холбоотойгоор 2018-2023 оны хугацаанд улсын хэмжээнд ОНХС-аас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлд жилд дунджаар 4,243.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд сүүлийн 2 жилийн байдлаар дунджаас дээгүүр буюу 2022 онд 8,2 тэрбум төгрөг, 2023 онд 7.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. 2023 оны байдлаар нийт хөрөнгө оруулалтын 12.3 хувийг малын тоо толгойн албан татварын орлого бүрдүүлсэн байна.

График 38. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж буй ОНХС-ийн хөрөнгө оруулалт /сая.₮/




ОНХС-гаас байгаль орчны салбарын хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, геологи хайгуул, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, нохой устгал, ойжуулах, тоног төхөөрөмж, машин механизм, усжуулах, булаг шандын эхийг засварлах, үерийн хамгаалалт, хортон шавж устгах, ариутгал, халдваргүйжүүлэлт, худаг гаргах, засварлах, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, засварлах, цэцэрлэгжүүлэлт гэсэн төсөл арга хэмжээнүүдийг санхүүжүүлдэг байна. Үүнээс дийлэнх буюу 58.6 хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа, 12.4 хувийг үерийн хамгаалалт, 3.2

хувийг тоног төхөөрөмж, машин механизм, 3.2 хувийг ойжуулах, 2.3 хувийг худаг гаргах, засварлах зардал тус тус бүрдүүлж байна.

2023 оны байдлаар улсын хэмжээнд ОНХС-гаас байгаль орчны салбарт оруулсан нийт хөрөнгө оруулалтын зардлын дийлэнх буюу 14.9 хувийг Сэлэнгэ аймаг, 12.2 хувийг Баянхонгор аймаг, 11.5 хувийг Дорнод аймаг тус тус зарцуулсан байна.

Зураг 5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж буй ОНХС-ийн нийт хөрөнгө оруулалтад аймгуудын эзлэх хувь



Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д төсвийн ил тод байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэхдээ төсвийн байгууллагууд нь Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих, төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор тус тус хангахыг хуульчилсан байдаг. Түүнчлэн Төсвийн тухай хуульд хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх тухай заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл болон ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагууд нь төсөв, санхүүгийн мэдээллээ тодорхой давтамжийн дагуу www.shilendans.mn цахим хуудсанд нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй.

Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн аудитын тайланд дурдсанаар 2020 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл нь дараа онд мэдээлэх тул хугацаа нь болоогүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна. Харин 2022 онд шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 311 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан байна.

Хэдийгээр тухайн оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагчаар сараар гаргаж цахим хуудсанд ил тод байршуулж байгаа боловч, төсвийн зардлыг эдийн засгийн ангиллаар харуулдаг тул энгийн иргэд, олон нийт ийм мэдээлэлд боловсруулалт хийж, дүн шинжилгээ хийх, харьцуулалт хийх бараг боломжгүй байна.

1. Байгаль орчны салбарын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо харьцангуй сайн хэдий ч шалгуур үзүүлэлтүүдийн хүрсэн үр дүн, хэрэгжилтийн түвшин ил тод бус байна. Алсын Хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хөгжлийн бодлогуудын баримт бичгүүдэд салбарын бодлогыг “Ногоон хөгжлийн бодлого”-оор тодорхойлж, зорилт, зорилгууд тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд, хүрэх түвшнийг тодорхой баталсан ч “Ногоон хөгжил”-ийн бодлого ямар түвшинд хэрэгжиж байгаа нь ил тод бус байна.

2. Монгол Улс байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээгээр дэлхийн дунджаас доогуур байна. Йелийн их сургууль, Колумбын их сургууль хамтран боловсруулдаг EPI үзүүлэлтээр Монгол Улс 2024 онд 37 оноо авч 180 орноос 144 дүгээр байранд эрэмбэлэгджээ. Монгол Улс ногоон хөгжлийн бодлогын үр дүнд EPI оноог 2025 онд 58, 2030 онд 59, 2050 онд 61+ түвшинд хүргэх зорилттой буюу 5 жилд 1-2 оноогоор ахиулах зорилттой байгаагаас 2024 оны байдлаар 37 оноотой байгаа нь төлөвлөсөн хугацаанд зорилтот үр дүнд хүрэхэд хүндрэлтэй байгааг илэрхийлж байна. Монгол Улсын EPI үзүүлэлтэд агаарын чанар, агаарын бохирдол, хог хаягдлын менежмент, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлууд сөргөөр нөлөөлж байна.

3. Байгаль орчны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг төсөвт байгууллагууд нь улсын болон орон нутгийн төсөв гэсэн 2 ялгаатай эх үүсвэрээс санхүүждэг. Улсын төсвийн санхүүжилт нь салбарын төрийн захиргааны төв байгууллага болох Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн ерөнхийлөн захирах багцад багтдаг бол орон нутгийн төсвийн санхүүжилт нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас баталсан ерөнхийлөн захирагчийн хүрээнд батлагддаг. 2015-2023 оны дунджаар салбарын нэгдсэн төсвийн зардлын 32.0 хувь (45 тб.₮)-ийг орон нутгийн төсвөөс, 68 хувь (93 тб.₮)-ийг улсын төсвөөс тус тус санхүүжүүлсэн байна.

4. Монгол Улсын байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зарцуулалт нь дэлхийн дунджаас доогуур байна. Дэлхийн улс орнуудын байгаль орчны салбартаа зарцуулж буй төсвийн зардал нь дунджаар ДНБ-ий 0.7 хувийг, нийт төсвийн зардлын 1.7 орчим хувийг эзэлдэг бол Монгол Улсын байгаль орчны салбарын төсвийн зардал нийт төсвийн зардлын 1.0 хувь, ДНБ-ий 0.4 хувьтай тэнцэж байна. Үүнээс гадна улс орнуудын 1 мк.2 газар нутагт оногдож буй төсвийн зардал дунджаар 910 орчим сая төгрөгтэй тэнцэж байгаа бол Монгол Улсын хувьд 0.13 сая төгрөгтэй тэнцэж байна.

5. Байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зардлын урт хугацааны динамик цуваа өсөлттэй байна. 2015-2023 онд салбарын батлагдсан улсын төсвийн зардал жилд дунджаар 19.3 хувиар, орон нутгийн төсвийн зардал 25.1 хувиар тус тус өссөн бол нэгдсэн төсвийн батлагдсан зардал 20.8 хувиар өссөн байна. Тус хугацаанд салбарын улсын төсвийн зарцуулалт жилд дунджаар 20.6 хувиар, орон нутгийн төсвийн зарцуулалт 23.3 хувиар тус тус өссөн бол салбарын нэгдсэн төсвийн зарцуулалт 20.9 хувиар өссөн байна.

6. Байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл сүүлийн 2 жилд тайлант хугацааны дунджаас доогуур байна. 2015-2023 оны дунджаар салбарын

нэгдсэн төсвийн гүйцэтгэл 91.8 хувьтай байсан бол улсын төсвийн гүйцэтгэл 94.9 хувь, орон нутгийн төсвийн гүйцэтгэл 85.4 хувьтай байна.

Салбарын улсын төсвийн гүйцэтгэл 2022 онд 84.0 хувь, 2023 онд 86.6 хувь, орон нутгийн төсвийн гүйцэтгэл 2022 онд 86.7 хувь, 2023 онд 84.3 хувьд тус тус хүрч дунджаас доогуур гүйцэтгэлтэй байсан. Улсын төсвийн гүйцэтгэлд агаарын бохирдлыг бууруулах зориулалтын арга хэмжээний гүйцэтгэл муу байгаа нь голлон нөлөөлсөн бол орон нутгийн төсвийн гүйцэтгэлд өвс тэжээлийн нөөц, агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнүүдийн зардлын гүйцэтгэл болон хөрөнгийн зардлын гүйцэтгэл хангалтгүй байгаа нь голлон нөлөөлжээ.

7. Байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зардлын дийлэнх хувийг цөөн хэдэн байгууллага эзэлж байна. 2023 оны байдлаар улсын төсвийн нийт зардлын 29.5 хувийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 29.1 хувийг 21 аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, 11.1 хувийг Ойн газар дангаараа бүрдүүлж байна. Харин орон нутгийн төсвийн зардлын 36.2 хувийг Нийслэлийн Агаарын Чанарын алба, 35.2 хувийг 21 аймаг, нийслэлийн Байгаль орчны салбарын бодлого хариуцсан төсөвт байгууллагууд эзэлж байна.

8. Байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн зардлын дийлэнх хувийг урсгал зардал бүрдүүлж байна. 2015-2023 оны дунджаар салбарын нэгдсэн төсвийн зардлын 86.1 хувийг урсгал зардал, 10.4 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна. Урсгал зардлын гүйцэтгэл дунджаар 89.9 хувь, хөрөнгийн зардлын гүйцэтгэл дунджаар 86.6 хувьтай байна.

9. Байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн урсгал зардлын 70-80 орчим хувийг ердөө 4 төрлийн зардалд зарцуулж байна. 2015-2023 оны дунджаар салбарын нэгдсэн төсвийн зардлыг эдийн засгийн ангиллаар шинжлэхэд нийт зардлын дийлэнх буюу 31.4 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал, 23.0 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, 10.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 9.4 хувийг хангамж, бараа материалын зардал тус тус эзэлж байна.

10. Байгаль орчны салбарын төсөвт байгууллагуудын дундаж цалин өсөлттэй байна. 2017-2023 оны дунджаар салбарт нийтдээ 4,176 албан хаагч хөдөлмөр эрхэлсэн бөгөөд салбарын нийт цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал жилд дунджаар 18.8 хувиар өссөн ба салбарын нэг албан хаагчид ногдох сарын дундаж цалин жилд дунджаар 15.9 хувиар өсөж 2023 оны байдлаар 1.6 сая төгрөгт хүрсэн байна. Энэ нь төрийн албан хаагчийн дундаж цалинтай харьцуулахад бага зэрэг өндөр үзүүлэлт юм.

11. Байгаль орчны салбарын бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын дийлэнх хувийг ойжуулалт болон агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан байна. Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд модны суулгац, үр, ургамлын материал бэлтгэх, нийлүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, ойжуулалтын талбайд модыг зөв зохистой тарьж ургуулах ажлыг мэргэжлийн компани, байгууллагаар хийлгэх, тарьсан ойг хамгаалахад чиглэсэн хашаа барих, хортон шавж, өвчнөөс хамгаалах бодис цацах, ойн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагаар

хийлгэх гэх мэт арга хэмжээнүүд голчлон багтдаг. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанарыг сайжруулах технологи нэвтрүүлэх, сайжруулсан түлш үйлдвэрлэх, нийлүүлэх, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор үйлдвэрүүдэд нэвтрүүлэх шинэ технологи, инновацыг хөгжүүлэх, нэвтрүүлэх ажлыг мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх гэх зэрэг ажлууд багтдаг.

12. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, болон бараа үйлчилгээний бусад зардлуудыг зориулалт арга хэмжээгээр нь ангилж үзвэл бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, агаарын бохирдлыг бууруулах, ойжуулалт, цахим шилжилт арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээнүүдэд зарцуулж байна.

Үүнээс гадна хог хаягдал хөтөлбөрийн хүрээнд хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ зэрэг хот суурин, нийтийн арга хэмжээг санхүүжүүлсэн бөгөөд зардлын гүйцэтгэл 100 орчим хувьтай байна. Харин хангамж, бараа материалын зардлын 85 орчим хувийг тээвэр шатахууны зардалд зарцуулсан байна.

13. Байгаль орчны салбарын хөрөнгийн зардал нь 2015-2023 оны дунджаар жилд 19.4 хувиар өссөн бөгөөд нийт зардлын 1.7 хувь буюу 312 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 98.3 хувь буюу 16.6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс тус тус санхүүжүүлсэн бөгөөд хөрөнгийн зардлын 64.4 хувийг барилга байгууламж, 3.4 хувийг их засвар, 3.0 хувийг тоног төхөөрөмж, 29.9 хувийг бусад хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

14. Байгаль орчны салбарын гадаадын зээл тусламж нь салбарын нэгдсэн төсвийн зардлын 6.8 орчим хувь буюу жилд дунджаар 9.6 орчим тэрбум төгрөгтэй тэнцэж байна. 2015-2023 оны хугацаанд гадаадын зээл тусламжаар салбарт нийтдээ 76.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд Байгаль орчны төв лабораторийн чадавхыг сайжруулах төсөл, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл гэсэн томоохон төслүүд өнөөг хүртэл хэрэгжиж байна.

15. Байгаль орчны салбарын зардлыг тодорхойлохдоо хүрээлэн буй орчны төсвийн хөтөлбөрийн ангиллуудад үндэслэнэ. Салбарын нэгдсэн төсвийн зардлын хүрээнд хүрээлэн буй орчны 13 хөтөлбөр, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний 12 зориулалт арга хэмжээний ангиллыг Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ний өдрийн 7 дугаар тушаалаар баталсан ч цөөн хэдэн хөтөлбөр, зориулалт арга хэмжээ улсын болон орон нутгийн төсөв дээр ялгаатай байдлаар хэрэгжсээр ирсэн. 2015-2023 онуудад улсын төсвийн хүрээнд 8 хөтөлбөр, 5 зориулалт арга хэмжээ, орон нутгийн төсвийн хүрээнд 7 хөтөлбөр, 4 зориулалт арга хэмжээ тогтмол хэрэгжсэн байна.

16. Байгаль орчны салбарын нэгдсэн төсвийн нийт зардлын 80 орчим хувийг ердөө 4 төрлийн хөтөлбөрт зарцуулж байна. 2015-2023 оны дунджаар салбарын нэгдсэн төсвийн зардлын 31 хувь (43 тб.₮)-ийг агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, 23 хувь (31 тб.₮)-ийг хүрээлэн буй орчны бодлого удирдлага, 21 хувь (29 тб.₮)-ийг ус цаг уур, орчны шинжилгээ, 6.3 хувь (8.7 тб.₮)-ийг ойжуулалт хөтөлбөр эзэлж байна.

17. Салбарын дийлэнх зардлыг эзэлдэг ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газар, 21 аймаг болон нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Байгаль орчны шинжилгээний төв лаборатори, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Нислэгийн цаг уурын төв гэсэн байгууллагууд үйл ажиллагаа эрхэлж байгаагаас нийт зардлын 92.4 хувийг үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулж байна.

18. Хүрээлэн буй орчны хөтөлбөрүүдээс агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх, хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрүүдийн зардлын гүйцэтгэл дундаж (91.2 хувь)-аас доогуур буюу хангалтгүй байна. Мөн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд олгож буй төсвийн санхүүжилт сүүлийн 2 жилийн хугацаанд 26.6 хувиар буурсан байна.

19. Байгаль орчны салбарын хог хаягдал хөтөлбөрийн зардал нь салбарын нэгдсэн төсвийн зардал болон хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлоготой харьцуулахад бага байна. Үүнээс гадна хог хаягдал хөтөлбөрийн арга хэмжээний зардлууд төсвийн зарлагын ангиллын бусад хөтөлбөрт бүртгэгдэж байна. Орон нутгийн төсөвт 2015-2023 оны хугацаанд жилд дунджаар “Хог хаягдлын тухай хууль”-ийн 41.8-д заасан хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 20 орчим тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн ба тус хугацаанд хүрээлэн буй орчны хог хаягдал хөтөлбөрийн хүрээнд жилд дунджаар 3.8 тэрбум төгрөгийг зарцуулсан бол 2023 оны байдлаар хог хаягдал хөтөлбөрийн хүрээнд 6.5 тэрбум төгрөг буюу нийт хог хаягдлын хураамжийн 22.8 хувийг зарцуулсан байна.

Дээр дурдсан хог хаягдлын хөтөлбөрийн зарцуулалт нь улсын хэмжээн дэх нийт хог хаягдлын салбарт зарцуулж буй төсвийн зардлыг бүрэн хамардаггүй бөгөөд нийт хог хаягдлын салбарын төсвийн зардлын ердөө 2.5 орчим хувийг энэхүү хөтөлбөрт бүртгэж байна. Өөрөөр хэлбэл 2023 оны байдлаар хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээнд улсын хэмжээнд нийтдээ 71.2 тэрбум төгрөгийг зарцуулсан ба үүний 63.9 хувь нь хот байгуулалт, тохижилтын хөтөлбөрт, 4.8 хувь нь орон нутгийн гүйцэтгэх удирдлагын хөтөлбөрт бүртгэгдсэн байна. Энэхүү хог хаягдлын хөтөлбөрөөс бусад хөтөлбөрт бүртгэгдэж буй хог хаягдлын зардлууд нь хог хаягдлын салбар болон хөтөлбөрийн зардлыг оновчтой бүртгэх, хөтөлбөрийн үр өгөөжийг тооцоход хүндрэл учруулж байгаа бөгөөд улсын хэмжээн дэх хог хаягдлын салбарын нийт зардлыг зөвхөн хог хаягдлын хөтөлбөрт оновчтой бүртгэх шаардлагатай байна.

20. Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд улсын ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлын үр өгөөж харьцангуй сайн хэдий ч орон нутгийн төсвийн ТЕЗ нарын хүрээнд хөтөлбөрийн нэгдсэн үр дүнг хэмжихэд хүндрэлтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд улсын төсвөөс “Ойн газар”, орон нутгийн төсвөөс ойн ангиуд тус тус санхүүждэг. Орон нутгийн ТЕЗ нарын хүрээнд аймаг тус бүр дээр хөтөлбөрийн хүрэх үр дүнг ялгаатай шалгуур үзүүлэлтээр хэмжиж байгаа тул хөтөлбөрийн нэгдсэн үр дүнг, зардлын өгөөжийг тодорхойлоход хүндрэлтэй байна. Үүнээс гадна орон нутгийн төсвийн ойжуулалт хөтөлбөрийн зардлыг ойн нөөц ашигласны төлбөрийн орлоготой харьцуулахад ойг нөхөн сэргээх, ойжуулах арга хэмжээнд зарцуулах ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 80 хувийн эх үүсвэрээс 2015-2023 онуудын дунджаар 47 орчим хувийг тус хөтөлбөрт зарцуулсан бол 2023 оны байдлаар 80

орчим хувийг зарцуулсан байна.

Улсын ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд 2015-2023 оны хугацаанд нийт 62.8 мянган га талбайг ойжуулж, ойг нөхөн сэргээсэн ба шалгуур үзүүлэлтийн биелэлт 57.2 хувьд хүрсэн бол нийт 1,357.1 мянган га талбайд ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийсэн ба шалгуур үзүүлэлтийн биелэлт 104.2 хувьд хүрсэн байна. Мөн нийт 226.8 мянган га талбайд ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийсэн ба шалгуур үзүүлэлтийн биелэлт 121.9 хувьд хүрсэн байна.

Хүрээлэн буй орчны ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд “Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтүүд болох “Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь” 2022 онд 8.2 хувьд хүрч зорилтот түвшин хангагдсан байна. Хөгжлийн бодлогын зорилтот үр дүндээ хүрч байгаа нь тус хөтөлбөрийн зарлагын үр өгөөж сайн байгааг илтгэж байгаа хэдий ч хөтөлбөрийн нэгдсэн төсвийн хүрээн дэх хүрсэн үр дүн, гарц тодорхой бус байгаагаас үр өгөөжийг хэмжихэд хүндрэлтэй байна.

21. Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн ангиллууд нь агуулгын хувьд адил төстэй байгаагаас шалтгаалан хөтөлбөрүүдийн зарим зардлуудыг оновчгүй бүртгэсэн байж болох хандлага ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл хүрээлэн буй орчны бохирдол доройтол гэсэн ойлголт нь хог хаягдал, агаарын бохирдол, цөлжилт, уур амьсгалын өөрчлөлт гэх зэрэг олон агуулгыг хамрах боломжтой. Гэсэн хэдий ч эдгээр үзүүлэлтүүд нь тус бүрчлэн хөтөлбөрийн ангилалтай бөгөөд мөн тухайн нэршлээрээ зориулалт арга хэмжээний ангилалтай байна. Энэ нь байгаль орчны салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээний зардлуудыг зөв хөтөлбөрийн ангилалд оновчтой бүртгэхэд хүндрэл үүсгэж байна.

Иймд тухайн хөтөлбөр нь байгаль орчны салбарын тухайлсан ямар асуудлыг хамрах, ямар төрлийн зориулалт, арга хэмжээний зардлыг бүртгэлжүүлэхийг тодорхойлж өгснөөр тухайн хөтөлбөрт зарцуулж буй зардлыг илүү оновчтой бүртгэж тодорхойлох бөгөөд зардлын үр өгөөжийг хэмжихэд хялбар болно.

22. Байгаль орчны салбарын ихэнх байгууллагуудын зардлын дийлэнх хувийг үндсэн үйл ажиллагааны арга хэмжээнд зарцуулж байна. 2015-2023 оны дунджаар салбарын нэгдсэн төсвийн зардлын 41.1 хувь (56.7 тб.₮)-ийг үндсэн үйл ажиллагааны зардал эзэлж байсан бол 2023 оны байдлаар үндсэн үйл ажиллагааны зардал 72.5 хувиар өсөж нийт зардлын 49.5 хувь буюу 113.0 тэрбум төгрөгийг эзэлж байна. Салбарын төсвийн зардлын өсөлтийн дийлэнх хувийг үндсэн үйл ажиллагааны зардал тэр дундаа цалин хөлс, нэмэгдлийн зардлын өсөлт бүрдүүлж байна.

23. Байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээнүүдэд дунджаар салбарын нийт зардлын 39.4 хувь (58.3 тб.₮)-ийг зарцуулсан байна. Салбарын нэгдсэн төсвийн зардлаас байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээний ангиллуудаас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ургамал хамгаалал, агаарын бохирдлыг бууруулах, ойжуулалт, ус цаг уурын судалгаа, шинжилгээ гэсэн хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг. Эдгээр арга хэмжээнүүдийн хүрээнд 2015-2023 оны дунджаар нийт зардлын ердөө 39.4 хувь буюу 58 орчим тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Ингэхдээ байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээнд зарцуулсан нийт зардлын 50.0 хувийг агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд, 30.0 хувийг байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд, 17.0 хувийг ойжуулах арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

24. Улсын ТЕЗ болон орон нутгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хүрээлэн буй орчны хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтүүд эрс ялгаатай. Орон нутгийн ТЕЗ нарын хүрээлэн буй орчны хөтөлбөрүүдийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд нь аймаг тус бүрээр ялгаатай бөгөөд хүрсэн үр дүнг тооцоолох нэгдсэн хэмжүүр тодорхойгүй байгаагийн улмаас аймгуудын хувьд ижил арга хэмжээ хэрэгжүүлсэн ч ялгаатай хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдэд ангилагдсан тохиолдол их байна.

Мөн аймгуудын хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд харилцан адилгүй бөгөөд хөтөлбөр болон зориулалтын арга хэмжээнүүдийн уялдаа хамаарал бага байна. Өөрөөр хэлбэл аймгийн байгаль орчны газрын үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчны бодлого удирдлага болон байгаль хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрүүдэд хамаарч байгаа бол хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ нь хүрээлэн буй орчны бохирдол доройтлыг бууруулах, хот байгуулалт тохижилт, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт бүртгэгдэж байгаагаас шалтгаалан хөтөлбөрийн зардлын гүйцэтгэлийг бодитоор тооцоход хүндрэлтэй байна.

Үүнээс гадна хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрэх үр дүн болон хэрэгжилтийг нэгдсэн төсвийн хэмжээнд тодорхойлдоггүй бөгөөд улсын болон орон нутгийн төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд эрс ялгаатай байгаа тул байгаль орчны салбарын хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрээнд зарцуулж буй нийт төсвийн зарлагын бодит үр өгөөжийг хэмжихэд хүндрэлтэй байна.

25. ТЕЗ-ийн хөтөлбөрийн үр дүн болон салбарын төсвийн зарлагын өсөлт хоорондын хамаарал бага байх хандлагатай байна. 2015-2023 онуудад улсын ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдээс шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тогтмол баталсан ойжуулалт болон ус, цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн нийт 4-н шалгуур үзүүлэлтийг байсан. Ойжуулалт хөтөлбөрийн зардлын өсөлт нь ойжуулах, ойг нөхөн сэргээх талбайн хэмжээтэй $-0.026/$ хамааралтай, ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх талбайн хэмжээтэй $-0.155/$ хамааралтай, ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээтэй $-0.220/$ хамааралтай гарсан бөгөөд ойжуулалт хөтөлбөрийн зардлыг нэмэгдүүлэх нь шалгуур үзүүлэлтийн биелэлттэй хамааралгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Энэ нь шалгуур үзүүлэлтийн хүрэх үр дүнг зардлын өсөлттэй уялдуулан оновчтой тодорхойлох шаардлагатай байгааг илтгэж байна.

26. Байгаль орчны салбарын санхүүжилтийн эх үүсвэрүүдээс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого хамгийн том эх үүсвэр юм. Байгалийн нөөц ашигласны тухай хуульд тус татварын орлого бүрдүүлэгч объектуудаас тодорхой хувийг байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулна гэж заасан байдаг. 2015-2023 оны дунджаар байгаль орчны салбарт БНАТ-ийн орлогоос жилд дунджаар хамгийн багадаа 40 орчим тэрбум төгрөгийг зарцуулбал зохих байснаас жилд дунджаар 35 орчим тэрбум төгрөгийг зарцуулсан бөгөөд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын эх үүсвэр нь байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас гадна байгалийн ямар төрлийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулсныг тодорхойлоход хүндрэлтэй байна. Дээрх шинжилгээний үр дүнгээс харахад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр бүрдүүлсэн эх үүсвэр нь байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд бүрэн зарцуулагдахгүй байна.

27. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор Улаанбаатар, Өмнөговь, аймгууд тэргүүлдэг. 2023 оны байдлаар Улаанбаатар хот 81.7 тэрбум төгрөгийн БНАТ-ийн орлого төвлөрүүлснээс хамгийн багадаа 12.9 тэрбум төгрөгийг байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулбал зохих байснаас 34.7 тэрбум төгрөгийг БНАТ-ийн орлогоос байгаль орчны салбартаа зарцуулсан нь сайн үзүүлэлт юм. Харин Өмнөговь аймгийн хувьд 47.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс хамгийн багадаа 14.2 тэрбум төгрөгийг зарцуулбал зохих байснаас ердөө 2.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

28. БОУАС-гийн ус бохирдуулсны болон агаарын бохирдлын төлбөрийн орлогын дийлэнх хувийг агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт зарцуулж байна. Улсын төсвийн агаар болон ус бохирдуулсны төлбөрийн орлогыг БОУАС-аас агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан зардалтай харьцуулахад 2015-2023 оны дунджаар нийт зардлын 82.6 хувь буюу 30.9 тэрбум төгрөгийг тус хөтөлбөрт зарцуулсан байна. Ингэхдээ 2020-2022 онуудад агаар болон ус бохирдлын төлбөрийн орлогоос 1.8 дахин илүү төсөв зарцуулсан бол 2023 оны байдлаар агаар болон ус бохирдуулсны нийт төлбөрийн орлогоос 2.8 дахин бага төсөв зарцуулсан байна.

29. Байгаль орчны салбарын өнөөгийн байдлаарх төсвийн орчныг тодорхойлох зорилгоор 2024 оны батлагдсан төсвийг шигтгээ хэсгүүдэд тусгасан бөгөөд зарим хөтөлбөрийн хүрэх үр дүнгүүд нь хэрэгжихгүй байгаа хөтөлбөрүүд болон бусад хөтөлбөрийн ангилалд хамрагдаж болохоор байна. Үүнд:

71410 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтод улсын тусгай хамгаалалтад авах цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийн хүрээг нэмэгдүүлж, сүлжээг өргөжүүлнэ гэж заасан. Тухайн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг биологийн төрөл зүйлийн хамгаалалт болон усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх нь илүү тохиромжтой байна.

71412 Хүрээлэн буй орчны судалгаа, шинжилгээ хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтод ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны биологийн болон ашиглалтын нөөцийг тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчилнэ. Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, генийн санг хадгалахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж заасан. Тухайн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт болон биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх нь илүү тохиромжтой байна.

71406 Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтод орчны чанар, төлөв байдал, бохирдолд нөлөөлөх хүчин зүйлийн иж бүрэн судалгааг хийж, бохирдлын эрсдэлийг бууруулна. Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бүх төрлийн эх үүсвэрээс ялгарах бохирдуулах бодисын хаягдал, ялгарлыг бууруулна гэж заасан. Тухайн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хүрээлэн буй орчны судалгаа, шинжилгээ, агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, хог хаягдал хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх нь илүү тохиромжтой байна.

30. Байгаль орчны салбарын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнтэй улсын болон орон нутгийн ТЕЗ нарын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг уялдуулан тодорхойлж үр дүнг хангахад чиглэсэн төсвийн зарцуулалтыг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж төлөвлөх явцад одоогоор ашиглагдаж буй хүрээлэн буй орчны төсвийн хөтөлбөр, зориулалтын ангиллууд нь агуулгын хувьд давхацсан, ерөнхий, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэлбэрүүдийг бүрэн хамрахгүй байх зэрэг сул талууд ажиглагдлаа. Энэ нь хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар төлөвлөх, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг оновчтой хэмжихэд хүндрэл учруулж байна.

Тухайлбал: Хөтөлбөрийн ангиллын “71407 Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, “71403 Ойжуулалт”, “71413 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх”, “71401 Хог хаягдал” “71408 Ус цагуур, орчны шинжилгээ” зэрэг ангиллууд нь зориулалт, арга хэмжээний ангиллын “81707 Агаарын бохирдлыг бууруулах”, “81708 Ойжуулалт”, “81701 Байгаль орчны хамгаалах нөхөн сэргээх”, “81710 Ус цаг уурын судалгаа, шинжилгээ”, “822120 Хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ” гэсэн ангиллуудтай агуулга, нэр томъёо ижил бөгөөд зааг ялгаа нь тодорхой бус байна.

Мөн 71401, 71402, 71404, 71405, 71406, 71410, 71412 код бүхий хөтөлбөрийн ангиллуудад нийцэх зориулалт, арга хэмжээний ангилал байхгүй бөгөөд эдгээр хөтөлбөрийн ангиллуудын зарим нь зориулалт, арга хэмжээний ангилалд хамаарах шинж чанартай байна.

Хөтөлбөр зориулалтын ангиллын давхцалтай холбоотойгоор

Орон нутгийн төсөвт байгалийн нөөцийн төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр тооцсон эх үүсвэрээр “Байгаль хамгаалах нөхөн сэргээх” хөтөлбөрийг хэрэгжүүлж хууль тогтоомжийн хүрээнд олон зориулалтаар зарцуулж байгаа боловч ихэнх аймгууд 81701” байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх” ангиллыг ашиглаж байна.

Жишээлбэл: ИТХ-аас Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан төсвийн зардлыг Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан зардлын зориулалт, арга хэмжээний ангиллаас зөвхөн “81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ” ангилалд бүртгэсэн байгаа боловч ойн сан бүхий газрын арчлалт, нөхөн сэргээлт, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, ан амьтныг хамгаалах, булаг шанд хамгаалах зэрэгт зарцуулагдсан байна.

31. Байгаль орчны салбарын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудыг хангахад чиглэгдсэн, байгаль орчны салбарын чиг үүрэгтэй холбогдох, хөтөлбөрийн үр дүнтэй уялдуулан хөгжлийн бодлого төсвийн уялдааг хангах, бүртгэл, тайлагналыг сайжруулах, төсвийн хуваарилалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор салбарын хөтөлбөрийн ангилал болон хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх зориулалт арга хэмжээ, үйл ажиллагааны ангиллуудыг оновчтой тодорхойлж сайжруулан шинэчлэх, үүнтэй зэрэгцэн хөтөлбөрийн үр дүн, гарц шалгуур үзүүлэлт бүхий хөтөлбөрийн тодорхойлолтуудыг боловсруулан мөрдүүлэх шаардлагатай байгааг онцолж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн ангиллууд хоорондоо давхцал ихтэй мөн зарим арга хэмжээнүүдийн зардал зорилтот хөтөлбөрүүдэд бүртгэгдэхгүй байгаа тул хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн санхүүжилтийг зөв бүртгэхэд хүндрэл үүсэж байна. Тиймээс одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хүрээлэн буй орчны төсвийн хөтөлбөр, зориулалтын ангиллуудыг шинэчлэх, давхцалгүй болгох шаардлагатай байна. Энэ хүрээнд Засгийн газрын чиг үүргийн COFOG ангилал, биологийн олон янз байдлыг хамгаалах зардлын GLOBE ангилал, болон Боифин II төслийн хүрээнд боловсруулагдсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний ангиллын төсөл болон Монгол улсын байгаль орчны салбарын хөгжлийн бодлогын зорилт, хүрэх үр дүн, салбарын эрх зүйн орчин болон БНАТ-ын орлогын эх үүсвэрт үндэслэн хүрээлэн буй орчны шинэчилсэн хөтөлбөрийн ангиллуудыг санал болгож байна.

Хүснэгт 36. Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн ангилал шинэчлэх санал

No	Хөтөлбөрийн ангилал	Олон Улсын төсвийн зардлын зарим ангилалтай нийцэх байдал	
	(шинэчлэх санал)	GLOBE - Global Biodiversity Expenditure taxonomy for the Public Sector – level 1	COFOG - Classification of Functions of Government – level 1, 2
1	Байгалын ургамал, амьтны генетик нөөц	Biofin Category 1. Access and Benefit Sharing	n/a
2	Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах	Biofin Category 6. Pollution Management	COFOG 7051. Waste Management, COFOG 7052. Waste Water Management,
3	Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах хөтөлбөр		
4	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалал	Biofin Category 7. Protected Areas and other conservation measure	
5	Ойн нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт	Biofin Cat: 9. Sustainable use and biodiversity	
6	Байгалийн ургамлын нөөцийн хамгаалал, нөхөн сэргээх	Biofin Category 8. Restoration,	COFOG 7054. Protection of Biodiversity and Landscape
7	Амьтны нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт		
8	Ус нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт		
9	Газрын нөөцийг хамгаалал, нөхөн сэргээлт		
10	Ус цаг уур орчны шинжилгээ	Biofin Category 2. Biodiversity awareness and Knowledge	COFOG 7055. R&D Environmental Protection
11	Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	Biofin Category 5. Planning and Finance	COFOG 7056. Environmental Protection (not elsewhere classified)

Салбарын хөрөнгийн зардал нь хүрээлэн буй орчны бодлого удирдлага хөтөлбөрт тусгагдаж удирдлагын зардлыг хийсвэрээр нэмэгдүүлж байгааг анхаарч хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардал нь ямар гарцад чиглэж байгаагаас шалтгаалан холбогдох хөтөлбөрийн зардалд төсвийг тусгуулж байх нь зүйтэй юм. Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал дах хүрээлэн буй орчны хөтөлбөрийн ангилал болон санал болгож буй шинэчилсэн хөтөлбөрийн ангилал хоорондын хамаарлыг доорх хүснэгтэд харуулж байна.

Хүснэгт 37. Батлагдсан хөтөлбөрийн ангилал, санал болгож буй хөтөлбөрийн ангилал хоорондын хамаарал

Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн ангилал		Санал болгож буй шинэчилсэн хөтөлбөрийн ангилал	
71401	Хог хаягдал		
71406	Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	71406	Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах
71407	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр		
71404	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	714XX	Усны нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт
71403	Ойжуулалт	714XX	Ойн нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт
71410	Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх	714XX	Газрын нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт
71402	Биологийн төрөл зүйлийн хамгаалалт	714XX	Байгалийн ургамлын нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт
71409	Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт	714XX	Амьтны нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт
71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт
71408	Ус цаг уур орчны шинжилгээ		Өөрчлөхгүй
71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага		Өөрчлөхгүй
71412	Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ		Өөрчлөхгүй
71413	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх		Хасах
GLOBE ангилалтай уялдуулан нэмэх хөтөлбөрийн ангилал:		714XX	Байгалын ургамал, амьтны генетик нөөц
		714XX	Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах хөтөлбөр

2. Байгаль орчныг хамгаалах зориулалтын арга хэмжээний ангиллуудыг оновчтой тодорхойлон шинэчилж, төсвийн зарцуулалтыг оновчтой бүртгэлжүүлэх. Хүрээлэн буй орчны төсвийн хөтөлбөрийн хүрээнд батлагдсан нийт зардлын ихэнх хувийг байгаль орчныг хамгаалах зориулалт арга хэмжээний ангилалд зарцуулж, хөтөлбөрийн зарцуулалт, салбарт үзүүлж буй үр нөлөөг тогтмол хэмжиж байх нь чухал юм. Үүний тулд арга хэмжээний ангиллыг оновчтой боловсруулах нэн шаардлагатай байна. Энэхүү төсвийн зарлагын шинжилгээний үр дүнгээс харахад одоогийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй зориулалт арга хэмжээний ангиллууд нь төсвийн хөтөлбөрийн үр дүн болон гарцын хүрээнд хэрэгжүүлэх зориулалт арга хэмжээг бүрэн илэрхийлж чадахгүй байгаа тул дараах байдлаар томьёолж, тодорхойлж байна. Энэхүү арга хэмжээний ангилал нь хүрээлэн буй орчны төсвийн хөтөлбөрийн ангиллын саналтай нягт уялдсан болно.

Хүснэгт 38. Байгаль орчин хамгаалах зориулалт арга хэмжээний ангилал шинэчлэх санал

№	код	Шинэчилсэн зориулалт арга хэмжээний ангилал	Ангиллын тодорхойлолт
1	81710	Ус цаг уурын судалгаа, шинжилгээ	Ус цаг уурын судалгаа шинжилгээ хийхтэй холбоотой зардлууд багтана.
2	81707	Агаар бохирдлыг бууруулах	Агаарын бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон зардлууд багтана.
3	82212	Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	Орчны бохирдлыг устгах цэвэрлэх,нийтийн эзэмшлийн зам, талбайг цэвэрлэгээ үйлчилгээ ,хог хаягдлыг зайлуулахтай холбогдсон зардлууд багтана.
4	822XX	Хог хаягдлыг дахин боловсруулах	Хог хаягдлыг ангилан ялгах, боловсруулахтай холбогдсон зардлууд багтана.
5	822XX	Бохирдуулагч эх үүсвэрийг орлох болон,ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд олгох дэмжлэг	Агаар орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд төсвөөс олгох дэмжлэг, урамшууллууд багтана.
6	81708	Ойжуулалт	Ойжуулалтын тухай хуульд заасны дагуу таримал ой, ойн сан байгуулж өмчлүүлэх, ой нөхөн сэргээх, үржүүлэх, ойн тооллого зохион байгуулахтай холбоотой зардлууд багтана.
7	81709	Ойн хөнөөлт шавж, хортонтой тэмцэх	Ойн хөнөөлт шавж хортонтой тэмцэхтэй холбогдсон зардлууд багтана.
8	81702	Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, түймрийн хохирлыг арилгах	Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, түймрийг унтраах, түймрийн хохирлыг арилгахтай тэмцэхтэй холбогдсон зардлууд багтана.
9	81705	Ойн тооллого	Ойн хуульд заасны дагуу ойн тооллого хийхтэй холбогдсон зардлууд багтана.
10	817XX	Ойн хяналт	Ойн хяналт, хамгааллыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлууд багтана.

11	817XX	Ой зохион байгуулалт	Сум дундын ойн ангийн үйл ажиллагаатай холбогдох зардлууд багтана.
12	817XX	Ойн судалгаа шинжилгээ	Ойн нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой судалгаа шинжилгээний зардлууд багтана.
13	81703	Ургамлын хамгаалал нөхөн сэргээлт	Байгалийн ургамлыг хамгаалах нөхөн сэргээхтэй холбогдсон зардлууд багтана.
14	817XX	Нэн ховор, ховор, ашигт ургамлыг тарималжуулах	Нэн ховор, ховор ашигт ургамлыг үржүүлэх, тарималжуулахтай холбогдсон зардлууд багтана.
15	817XX	Байгалийн ургамлын судалгаа	Байгалийн ургамлын нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой бүх төрлийн судалгаа шинжилгээний зардлууд багтана.
16	817XX	Амьтны хамгаалал био технологийн арга хэмжээ	Амьтны хамгаалал био технологийн арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлууд багтана.
17	817XX	Нэн ховор ,ховор амьтныг өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах	Нэн ховор, ховор амьтныг өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулахтай холбоотой зардлууд багтана.
18	817XX	Амьтны судалгаа шинжилгээ	Амьтны нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой судалгаа шинжилгээний зардлууд багтана.
19	817XX	Ус, рашааны нөөцийн хамгаалал (булаг, шанд, гол, мөрөн, нуур)	Ус рашааны нөөцийг хамгаалахтай холбогдсон зардлууд багтана.
20	817XX	Улсын тусгай хамгаалалттай гол, мөрний урсац бүрэлдэх эхийн менежментийн хэрэгжилт зохицуулалт	Улсын тусгай хамгаалалттай гол мөрний хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдсон зардлууд багтана.
21	817XX	Хаягдал ус дахин боловсруулах , цэвэршүүлэх	Хаягдал ус, дахин боловсруулах ,цэвэршүүлэхэд чиглэсэн арга хэмжээтэй холбогдсон зардлууд багтана.
22	817XX	Генетик нөөцийг бүртгэх,хадгалах, ашиглах	Байгалийн ургамал амьтны генетик нөөцийг бүртгэх,хадгалахтай холбогдсон зардлуудыг хамааруулна.

23	817XX	Генетик нөөцийн судалгаа шинжилгээ	Байгалийн ургамал амьтны генетик нөөцийг судлах шинжлэхтэй холбогдсон зардлууд багтана.
24	817XX	Газрын нөхөн сэргээлт	Эвдэрсэн газрыг нөхөн сэргээхтэй холбогдсон зардал энэ ангилалд хамаарна.
25	817XX	Газрын доройтлыг бууруулах цөлжилтийг сааруулах элсний нүүдлээс хамгаалах	Газрын доройтлыг бууруулах цөлжилтийг сааруулах, элсний нүүдлээс хамгаалахтай холбогдсон зардлууд багтана.
26	817XX	Бэлчээрийн талбайг хашиж хамгаалах, ургамлын нөмрөгийг нөхөн сэргээх	Малын бэлчээрийн талбайг хашиж хамгаалах, ургамлын нөмрөгийг нөхөн сэргээхтэй холбогдсон зардлууд багтана.
27	817XX	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн хэрэгжилт зохицуулалт	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдсон зардлууд багтана.
28	817XX	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн хэрэгжилт зохицуулалт	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдсон зардлууд багтана.
29	817XX	Газрын нөөцийн судалгаа шинжилгээ	Газрын нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой судалгаа шинжилгээний зардлууд багтана.

3. Байгаль орчны салбарын төсөвт байгууллагуудын санхүүжилтийг олгохдоо үр дүнд суурилсан төсөвлөлтөд үндэслэх. Салбарын төсвийг батлахдаа улсын болон орон нутгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээнүүдийг “шалтгаан-үр дагаврын цогц шинжилгээ”-нд үндэслэн гарц/бүтээгдэхүүн, үр дагавар, үр нөлөөг оновчтой тодорхойлж баталснаар салбарт олгож буй төсвийн зарлагын үр ашгийг оновчтой тооцоолох нөхцөл бүрдэх бөгөөд зардал илүү үр өгөөжтэй зарцуулагдана. Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг үр дүнд суурилсан төсөвлөлтөд үндэслэн тодорхойлж улсын болон орон нутгийн төсөвт хөтөлбөрийн хүрэх үр дүнг ижил хэмжигдэхүүнээр хэмжиж салбарын нэгдсэн төсвийн хүрэн дэх үр дүнгүүдийг оновчтой тодорхойлж, төсвийн үр өгөөжийг хэмжих нөхцөлийг сайжруулах шаардлагатай байна

4. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн үйл ажиллагааг тогтмолжуулж салбарын төсвийн мэдээллийн ил тод байдлыг хангах. “Байгаль орчны мэдээллийн сан /БОХАХТЗМС/” гэж байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах мэдээллийн технологийн иж бүрдлийг хэлэх бөгөөд БОАЖЯ-аас уг мэдээллийн санг хөгжүүлж байна. Одоогийн байдлаар байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогуудыг

бүртгэсэн байгаа бөгөөд цаашид байгаль орчны салбарын орон нутгийн болон улсын төсвийн нийт санхүүжилтийг тус мэдээллийн санд бүртгэж СЯ болон БОАЖЯ, бусад харьяа байгууллагууд байгаль орчны салбарын төсвийн орчны мэдээллийн нэгдсэн нэг эх үүсвэртэй болох ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

5. БНАТ-ийн орлого болон бусад санхүүжилтийн эх үүсвэрт үндэслэн салбарын төсвийн зарлагыг нэмэгдүүлэх. Салбарын шинжилгээний тайлант хугацааны дийлэнх үед БНАТ-ийн орлогоос зарцуулбал зохих хамгийн бага зардалд аймгуудын байгаль орчны салбарт зарцуулсан зардал хүрээгүй байдалтай байсан. БНАТ-ийн орлогын дийлэнх зардлыг бүрдүүлж буй газрын төлбөрийн орлогын өсөлтөд үндэслэн газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ(2015-2023 оны дунджаар нийт зардлын ердөө 0.2 хувь)-ний зардлуудыг нэмэгдүүлэх, БОУАС-нд төвлөрч буй агаарын бохирдлын орлогын өсөлттэй уялдуулан агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн арга хэмжээ(2015-2023 оны дунджаар хөтөлбөрийн нийт гүйцэтгэл ердөө 79.1 хувь)-ний санхүүжилтийг нэмэгдүүлэх гэх мэтчилэн байгаль орчны салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төсвийн санхүүжилтүүдийг хуулийн дагуу нэмэгдүүлэх шаардлагатай байна.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

2024 Environmental Performance Index

Гео-мэдээллийн сан

Алсын хараа 2050

Тогтвортой Хөгжлийн Зорилго 2030

PUBLIC GOVERNANCE DIRECTORATE COMMITTEE OF SENIOR BUDGET OFFICIALS, (2024). *Green Budgeting in OECD Countries 2024*

Manual on sources and methods for the compilation of COFOG statistics, (2019).

CLASSIFICATION OF THE FUNCTIONS OF GOVERNMENT (COFOG)

UNDP. Монгол улс дахь агаарын бохирдол ба хэтийн боломжууд /Төсвийн зарлагын шинжилгээний тайлан/

Амартүвшин, С., & Энхбилэг, Д. (2024). Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ангиллыг боловсруулах нь

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025 он)

БИОФИН төслийн зөвлөхүүдийн баг. (2019). Монгол Улсын Биологийн олон янз байдлын санхүүжилтийн хэрэгцээ, бодлого, хандлага

БОАЖЯ. (2023). Биологийн олон янз байдлын талаарх монгол улсын баримталж буй бодлого, холбогдох хууль тогтоомж

Ногоон эдийн засгийн бодлогын үнэлгээ: Монгол Улсын ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилт (2021).

НЭЗТТ-ийг төлөөлөн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр. (2018). Ногоон эдийн засгийн бодлогын дүн шинжилгээ: МОНГОЛ УЛС

Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл (2023). ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСӨВЛӨЛТ /Үндсэн ойлголт, зарчим, практик хэрэглээний гарын авлага/

Засгийн Газраас Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө (2021)

Байгаль орчны салбарын орон нутгийн зарлагын шинжилгээ /Хандлага болон өнөөгийн нөхцөл байдал/ (2022)

Монгол улсын Засгийн Газар онцлох ажлууд 3 жил (2024)

Бусад

ХАВСРАЛТ 1. “АЛСЫН ХАРАА 2050”-ИЙН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭС

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	2020	2021	Хүрэх түвшин		
						2025	2030	2050
1	Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI	оноо	57.2	32.2		58	59	61+
2	Улсын тусгай хамгаалалттай Газар нутгийн эзлэх хувь	хувь	20.1	21	21	27	30	35
3	Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	хувь	48.3	49.9	49.9	55	60	75
4	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	7.9	8.0	8.1	8.7	9	10.5
5	Газрын доройтлын хувь	хувь	22.9	23.3	23.3	22.9	22.9	
6	Гидрогео-логийн дунд машлабын зураглал хийгдэх газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь	хувь	14	14.8	14.8	23	30	50
7	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	82.5			85	87	90
8	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	69			70	75	90
9	Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хувь	хувь	суурь сценари			12.3	22	-
10	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	7.6	10.3	15.7	27	40	50
11	Хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	25.6	26	43.5	52	64	90
12	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	хувь	-	-	-	10	20	50
13	Нэгж амдолларын дотоодын нийт бүтээгдэхүүнд ногдох дотоодын материалын хэрэглээ	кг/ам.\$	15	17.9		10	6	3

ХАВСРАЛТ 2. “МОҢГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ХҮРЭХ ҮР ДҮН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин(2025)
1	Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI	ОНОО	57.2	58
2	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	хувь	20.1	27
3	Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	хувь	48.3	55
4	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	7.9	8.7
5	Газрын доройтлын хувь	хувь	22.9	22.9
6	Гидрогео-логийн дунд масштабын зураглал хийгдэх газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь	хувь	14	23
7	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	82.5	85
8	Шаардлага хангасан ариун цэврийн байгуулам-жаар хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	69	70
9	Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хувь	хувь	суурь сценари	12.3
10	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	7.6	27
11	Хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	25.6	52
12	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	хувь	-	10
13	Нэгж ам.долларын дотоодын нийт бүтээгдэхүүнд ногдох дотоодын материалын хэрэглээ	кг/ам.\$	15	10

ХАВСРАЛТ 3. “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ХҮРЭХ ҮР ДҮН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Сүүрх түвшин	Хүрэх түвшин (2025)			
				2021	2022	2023	2024
1	Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/м3	60	55	50	46	43
2	Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/м3	124	115	107	101	94
3	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	хувь	20.1	22	23	24	25
4	Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	хувь	48.3	50	51	52	53
5	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	7.9	8	8.2	8.4	8.6
6	Гидрогеологийн дунд маштабын зураглал хийгдэх газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь	хувь	14	15	17	19	21
7	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	82.5	82.6	83	83.5	84
8	Барилгын салбарын хүлэмжийн хийн бууралт	мян.тн CO2	0.3	0.6	0.9	1.2	1.5
9	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	7.6	10	15	20	24
10	Хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	25.6	30	36	42	50
11	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	хувь	0	2	4	6	8
12	Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI	хувь	57.2	57.2	57.2	58	58
13	Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хувь	кг/ам.\$	25,815.30	9.2	10	10.8	11.8
14	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	38	40	42	44	46

